



“ЭМЗЭГ БҮЛГИЙН ИРГЭДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ” ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ
49173-003-МОН

ЭРҮҮЛ МЭНДИЙН АНХАН ШАТНЫ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ХӨГЖЛИЙН ЗӨВЛӨХ БАГ (CS01)

ЭРҮҮЛ МЭНДИЙН АНХАН ШАТНЫ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН ТҮРГЭВЧИЛСЭН ҮНЭЛГЭЭ

ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Улаанбаатар хот
2022 оны 6 дугаар сар

Агуулга

1.	ҮНДЭСЛЭЛ	5
2.	ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД	7
2.1	Түргэвчилсэн үнэлгээний зорилго	7
2.2	Түргэвчилсэн үнэлгээний зорилтууд	7
3.	ҮНЭЛГЭЭНИЙ АРГА, АРГАЧЛАЛ	8
3.1	Түргэвчилсэн үнэлгээний аргачлал	8
3.2	Өрхийн эрүүл мэндийн төвөөс цуглуулсан өгөгдөл мэдээлэл	8
3.3	Сумын эрүүл мэндийн төвөөс цуглуулсан өгөгдөл мэдээлэл	9
3.4	Дэлхийн банкны аргачлалаар цуглуулсан өгөгдөл мэдээлэл	9
4.	ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН	11
4.1	ӨЭМТ-ийн тусламж үйлчилгээний өнөөгийн байдал	11
4.2	СЭМТ-ийн тусламж үйлчилгээний өнөөгийн байдал	18
4.3	Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгааны үр дүн	26
4.3.1	Нийслэлийн иргэдийн сэтгэл ханамжийн судалгааны үр дүн	26
4.3.2	Хөдөөгийн иргэдийн сэтгэл ханамжийн судалгааны үр дүн	32
4.4	Дэлхийн банкны аргачлалаар хийсэн үнэлгээний үр дүн	37
4.4.1	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж буй барилга байгууламж, орчны үнэлгээ	37
4.4.2	Халдвартай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үнэлгээ	43
4.4.3	Эмийн хангалт, зохион байгуулалтын үнэлгээ	53
4.4.4	Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын үнэлгээ	53
4.5	ЭМАШТҮ-ний байгууллагын мэдээллийн технологийн өнөөгийн байдал	55
4.5.1	Интернэт ба мэдээллийн сүлжээ	55
4.5.2	Мэдээллийн технологийн тоног төхөөрөмжийн хангамж, хэрэгцээ	56
4.5.3	Програм хангамж	58
4.6	ЭМАШТҮ-ний санхүүжилтын өнөөгийн байдал	59
4.6.1	Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн шинэчлэл	59
4.6.3	Гэрээлэх	68
4.7	СЭМТ-ийн нөхцөл байдлын үнэлгээний дүн	69
5.	ДҮГНЭЛТ	73
5.1	ЭМАШТҮ-ний байгууллагын удирдлага, бүтэц, зохион байгуулалтын тулгамдсан асуудлууд	73
5.2	ЭМАШТҮ-ний чанар	73
5.3	ЭМАШТҮ-ний хүний нөөц	76
5.4	ЭМАШТҮ-ний санхүүжилт	79
6.	ЗӨВЛӨМЖ	81

6.1 ЭМАШТҮ-ний байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтийн санал, зөвлөмж.....	81
6.1.1 Одоогийн үйлчилгээний загвар	82
6.1.2 Одоогийн үйлчилгээний загвар – Хязгаарлах хүчин зүйлүүд	82
6.1.3 Санал болгож буй нэгдмэл тусламж үйлчилгээний загвар	83
6.1.4 Эрүүл мэндийн үйлчилгээг нэгтгэх үндэслэл нь юу вэ?	86
6.1.5 Эрүүл мэндийн цогц, нэгдмэл, тасралтгүй үйлчилгээний тухай ойлголт, тэдгээрийн төрөл бүрийн хэлбэрүүд	88
6.1.6 Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх нэгдмэл сүлжээ гэж юу вэ?	89
6.2 ЭМАШТҮ-ний чанарын удирдлагын шинэчлэлийн санал, зөвлөмж	91
6.3 Хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах талаарх санал, зөвлөмж.....	94
6.4 ЭМАШТҮ-ний санхүүжилтын шинэчлэлийн санал, зөвлөмж.....	94
ХАВСРАЛТУУД.....	96
Хавсралт 1. Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн түргэвчилсэн үнэлгээний асуумж	97
Хавсралт 2. Дэлхийн банкны Эрүүл мэндийн байгууллагуудын үнэлгээний аргачлалын асуумж.....	121
Хавсралт 3. Нөхцөл байдлын үнэлгээний ярилцлагын асуумж.....	132
Хавсралт 4. Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгааны асуумж	133
Хавсралт 5. Мэдээллийн технологи, програм хангамжийн өнөөгийн байдлын үнэлгээний асуумж	135
Хавсралт 6. Үнэлгээний асуумж авах албан бичиг	136
Хавсралт 7. Булган, Хөвсгөл аймагт түргэвчилсэн.....	137
үнэлгээний ажлын удирдамж	137
Хавсралт 8. Дорноговь аймагт түргэвчилсэн	139
үнэлгээ хийх ажлын удирдамж.....	139
Хавсралт 9. Дэлхийн банкны аргачлалаар хийсэн	141
үнэлгээний товч тайлан	141

Товчилсон үгс

АХБ	Азийн Хөгжлийн Банк
ДЭМБ	Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага
ИЭМЦБ	Иргэний Эрүүл Мэндийн Цахим Бүртгэл
ӨЭМТ	Өрхийн Эрүүл Мэндийн Төв
ОХБ	Оношийн Хамааралтай Бүлэг
МХХТ	Мэдээлэл Харилцаа Холбооны Технологи
МЭЗЭМ	Макро Эдийн Засаг ба Эрүүл Мэнд
НЭМГ	Нийслэлийн Эрүүл Мэндийн Газар
СЯ	Сангийн Яам
СЭМТ	Сумын Эрүүл Мэндийн Төв
ТББ	Төрийн Бус Байгууллага
ТЭМТ	Тосгоны Эрүүл Мэндийн Төв
ТХН	Төсөл Хэрэгжүүлэх Нэгж
ТХХТ	Төр, Хувийн Хэвшлийн Түншлэл
ТХБ	Төсөл Хэрэгжүүлэх Баг
ТУХ	Төслийн Удирдах Хороо
ТАХ	Техникийн Ажлын Хэсэг
ХСС	Хамтдаа суралцах сүлжээ
ЭМАШТҮ	Эрүүл Мэндийн Анхан Шатны Тусламж Үйлчилгээ
ЭМТҮНС	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний нэгдмэл сүлжээ
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭМДЕГ	Эрүүл Мэндийн Даатгалын Ерөнхий Газар
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ЭМДС	Эрүүл Мэндийн Даатгалын Сан
ЭМХТ	Эрүүл мэндийн хөгжлийн төв
ЭММСП	Эрүүл Мэндийн Мэдээлэл Солилцох Платформ
ЭМДҮЗ	Эрүүл Мэндийн Даатгалын Үндэсний Зөвлөл

1. ҮНДЭСЛЭЛ

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас “Бүх нийтийн эрүүл мэндийн хамрагдалтад хүрэх”-ийн тулд анхан шатлалын эрүүл мэндийн байгууллагыг бэхжүүлж, тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахыг зөвлөмж болгож байна.

Монгол улс Дэлхийн Тогтвортой хөгжлийн зорилт, Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогын зорилтод хүрэхэд эрүүл мэндийн анхан шатлалын тусламж үйлчилгээг бэхжүүлэх, нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэргүүлэх чиглэл болгон ажиллаж байна.

Монгол орны хувьд дэд бүтэц сайн хөгжөөгүй, алслагдмал нөхцөлд амьдардаг хүн амд хүртээмжтэй тэгш, шударга, чанартай тусламж, үйлчилгээг сэтгэлд нь хүртэл үзүүлэх өөрчлөлтийг удирдлага, санхүүжилт, эмнэлгийн тусламж, үйлчилгээний хүрээнд цогцоор нь хийх шаардлага тулгараад байна. Эдгээр өөрчлөлт шинэчлэлтийг хийхийн тулд өнөөгийн эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээнд цогц үнэлэлт өгч, алдаа оноогоо тодорхойлох шаардлага гарч байна.

Монгол улсын засгийн газар, АХБ-ны зээлээр 49173-003-MON “Эмзэг бүлгийн иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр” төслийн хүрээнд “Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний хөгжил”-ийн зөвлөх багийн ажлын удирдамжид “Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний өнөөгийн байдлын түргэвчилсэн үнэлгээ” хийхээр төлөвлөгдсөний дагуу энэхүү үнэлгээг хийж байна.

Монгол Улсад эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ (ЭМАШТҮ)-г Улаанбаатар хот болон аймгийн төвд Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд, хөдөө орон нутагт Сумын эрүүл мэндийн төвүүдэд үзүүлж байна. Гэвч дэд бүтэц, байшин барилга, тоног төхөөрөмжийн хувьд элэгдэж муудсан, хоцрогдсон, ард иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх туршлага хомс залуу эмч нар ихэвчлэн ажилладаг байна. Иймээс ЭМАШТҮ-ий чанар тааруу гэж ойлгогдож, өвчтөнүүд анхан шатны түвшинг алгасч, шууд аймаг, дүүрэг болон хотын эмнэлгүүд рүү ханддаг явдал нь тухайн өвчтөн болон эрүүл мэндийн тогтолцооны хувьд өндөр үнэтэй, үр ашиг муутай шийдэл болж байна.

ЭМАШТҮ-г шинэчлэх анхны алхам “Өрхийн эмнэлэг байгуулах тухай” 1999 оны ЗГ-ын тогтоол гарч өрхийн эмнэлгүүдийг байгуулсанаар эхэлсэн. Өрхийн эмнэлэг нь хот, суурин газрын хүн амд төрөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх үндсэн чиг үүрэг бүхий сайн дурын үндсэн дээр бүртгүүлсэн хувийн хэвшлийн эрүүл мэндийн

байгууллага юм. Өрхийн эмнэлгүүдийн нэг иргэнээр тооцсон санхүүжилт бага байгаа нь тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, хөрөнгө оруулалт хийх нөхцлийг бүрдүүлэхгүй байжээ. ӨЭМТ, СЭМТ-үүд нь өвчтөн шилжүүлэх тогтолцоо мөрдөж лавлагаат шатлалын тусламж үйлчилгээг эмнэлгийн хэрэгцээ шаардлага, үндэслэлгүйгээр иргэдэд үзүүлэхээс урдчилан сэргийлж “хаалга баригч”-ийн үүргээ хангалттай сайн гүйцэтгэхгүй бол эрүүл мэндийн анхан шатны түвшинд үзүүлж буй тусламж үйлчилгээний чанарыг дорвитой сайжруулан хөгжүүлэх боломжгүй юм. Монгол улсад эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд (өрх, сумын эрүүл мэндийн төвүүд) нь харьяаллын хүн амд чиг үүргийн дагуу тав хүртэлх насны хүүхдийн дархлаажуулалт, жирэмсэн эмэгтэйчүүдийн хяналт, эх, хүүхдийн гэрийн эргэлт зэрэг 8 төрлийн тусламж үйлчилгээг үзүүлэн ажилладаг. Монгол орны цаг уурын эрс тэс уур амьсгалын улмаас өвөл, хаврын улиралд амьсгалын замын өвчлөл нэмэгддэг нь өрх, сумын эрүүл мэндийн төвүүдийн ажлын ачааллыг ихэсгэдэг.

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн гаргасан “Эрүүл мэндийн үзүүлэлт”-ээс харахад 2020 оны байдлаар улсын хэмжээнд 322 сумын эрүүл мэндийн төв, 209 өрхийн эрүүл мэндийн төв үйл ажиллагаа явуулж байгаагаас Улаанбаатар хотын 1 сая 466.1 мянган хүн амд 131 өрхийн эрүүл мэндийн төв, 21 аймгийн төвийн 702.1 мянган хүн амд 78 өрхийн эрүүл мэндийн төв эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлж байна.

2. ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД

2.1 Түргэвчилсэн үнэлгээний зорилго

Монгол улсын ЭМАШТҮ-ний өнөөгийн байдлыг үнэлж, дүгнэн, тусламж үйлчилгээний гүйцэтгэл, үр ашиг, чанар, хүртээмжийг сайжруулах тогтолцооны шинэчлэлийн чиг хандлагыг тодорхойлох.

2.2 Түргэвчилсэн үнэлгээний зорилтууд

Дараах зорилтуудыг дэвшүүлсэн. Үүнд:

1. ЭМАШТҮ үзүүлэгч байгууллагуудын тулгамдсан асуудлуудыг тодорхойлж, бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтийн саналыг боловсруулах,
2. ЭМАШТҮ-ний чанар, аюулгүй байдлыг үнэлж, чанарын удирдлагын шинэчлэлийн санал дэвшүүлэх,
3. ЭМАШТҮ-ний хүний нөөцийн өнөөгийн байдлыг үнэлж, тогтвортой байдлыг хангах стратегийн төлөвлөлтийн саналыг боловсруулах,
4. ЭМАШТҮ-ний санхүүжилтын өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, санхүүжилтын шинэчлэлийн саналыг боловсруулах,
5. ЭМАШТҮ-нд мэдээллийн технологийн ашиглалтын байдлыг үнэлэх,
6. ЭМАШТҮ-ний хүртээмж, чанарын талаарх үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг судлах, дүгнэх,
7. Анхан шатлалын тусламж, үйлчилгээнд төр хувийн түншлэлийг нэвтрүүлэхэд тулгарах боломж, эрсдлүүдийг судлах, санал зөвлөмж боловсруулах,
8. Төслийн хүрээнд барилга барих СЭМТ, ӨЭМТ-үүдээс дэлгэрэнгүй мэдээлэл цуглуулж, барилгын үйл ажиллагааны төлөвлөлтөд ашиглах тус тус зорилттой.

3. ҮНЭЛГЭЭНИЙ АРГА, АРГАЧЛАЛ

3.1 Түргэвчилсэн үнэлгээний аргачлал

“Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний байгууллагуудын өнөөгийн байдлын түргэвчилсэн үнэлгээ”-г дараах үнэлгээний аргуудыг хослуулан хэрэглэсэн. Үүнд :

1. “Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийг магадлан шинжлэх шалгуур батлах тухай” Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/179 тоот тушаалаар батлагдсан шалгуураас төслийн үнэлгээний зорилго, зорилтуудтай нийцэх хэсгүүдээр үнэлгээний асуумж (**хавсралт 1**) боловсруулан 154 ӨЭМТ-үүдэд, 204 СЭМТ-үүдэд тус тус үзүүлэлт тус бүрийг 5 оноогоор үнэлсэн,
2. Дэлхийн банкны Эрүүл мэндийн байгууллагуудын үнэлгээний аргачлалын асуумж (**хавсралт 2**)-ийн дагуу 3 аймгийн 10 СЭМТ, нийслэлийн 4 ӨЭМТ дээр очиж үзүүлэлт тус бүрийг 10 оноогоор үнэлсэн. Энэхүү Дэлхийн банкны аргачлал нь эрүүл мэндийн байгууллагын удирдлагын манлайлал, эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарыг судлах зориулалттай ба олон улсад өргөнөөр ашиглагддаг, мэдээллийн үнэн бодит байдлыг бүрэн тодорхойлдог судалгааны хэрэгсэл юм.
3. Найман СЭМТ-ийн дарга, их эмч, ахлах сувилагч, эмнэлгийн мэргэжилтнүүдтэй тусламж, үйлчилгээний давуу болон сул талуудын талаар ярилцаж, тулгамдсан асуудлуудыг тодорхойлж, нөхцөл байдлын үнэлгээ (SWOT analyzes) (**хавсралт 3**) хийсэн,
4. ӨЭМТ-ийн 110, СЭМТ-ийн 120 үйлчүүлэгчдээс тус тус сэтгэл ханамжийн судалгаа (**хавсралт 4**) авсан,
5. Дөрвөн ӨЭМТ, арван СЭМТ-үүдийн мэдээллийн технологи, програм хангамжийн өнөөгийн байдлыг өөрсдийн бэлтгэсэн асуумж (**хавсралт 5**)-аар үнэлгээ хийсэн.

3.2 Өрхийн эрүүл мэндийн төвөөс цуглуулсан өгөгдөл мэдээлэл

МӨАМХ-ноос ДЭМБ-ын техникийн болон санхүүгийн дэмжлэгтэйгээр 21 аймаг, нийслэлийн 8 дүүргийн 206 ӨЭМТ-ийн ахлагч, нягтлан бодогч нар, холбооны 19 салбарын дарга нар нийт 350 төлөөлөгч оролцсон зөвлөгөөн, хэлэлцүүлгийг 2022 оны 2 дугаар сарын 24-ний өдөр, ӨЭМТ-ийн удирдлагуудыг чадавхжуулах сургалтыг 2022 оны 2 дугаар сарын 25, 26-ны өдөр, мөн өрхийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тулгамдаж буй асуудлаар хэлэлцүүлэг, ярилцлагыг ЭМЯ, ЭМДЕГ, ЭМХТ, аймаг, нийслэлийн ЭМГ-ын дарга

мэргэжилтнүүдийг урьж 2 дугаар сарын 27-ны өдөр тус тус зохион байгуулсан.

Дээрх арга хэмжээний үеэр 2 дугаар сарын 26-ны өдөр “Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийг магадлан шинжлэх шалгуур батлах тухай” Эрүүл мэндийн сайдын 2020 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн А/179 тоот тушаалаар батлагдсан шалгуурын Бүлэг 2, дэд бүлэг 1-6-ийн асуумжийг нийт ӨЭМТ-ийн ахлагч нарт тараан бөглүүлж, 154 ширхэг асуумжийг цуглуулан авсан. Энэхүү асуумж нь ӨЭМТ-ийн Засаглал, удирдлага, манлайлал, Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын удирдлага, Хүний нөөцийн хөгжил, Мэдээллийн удирдлага, аюулгүй байдал, Тоног төхөөрөмжийн чанар, аюулгүй ажиллагаа, засвар, техникийн үйлчилгээ, Барилга, инженерийн байгууламжийн аюулгүй ажиллагааг тус тус үнэлэх зорилготой.

3.3 Сумын эрүүл мэндийн төвөөс цуглуулсан өгөгдөл мэдээлэл

“Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний байгууллагуудын өнөөгийн байдлын түргэвчилсэн үнэлгээ”-г Сум, тосгоны эрүүл мэндийн төвүүдийн магадлан шинжлэх шалгуурын дагуу хийхдээ дараах линкээр холбогдож, өгөгдөл цуглуулсан.

https://docs.google.com/forms/d/e/1FAIpQLSc1OGuvZnwTI5e1MhhAfUVL2V8DxKkk3IC14BXLTKeGe1ea_A/viewform

Энэхүү линкээр GOOGLE FORM-д орж асуумжийн дагуу сумын эрүүл мэндийн төвийн дарга, их эмч, статистикч эмч нар өгөгдөл оруулсан.

ЭМЯ-ны Санхүү, эдийн засгийн газрын дарга, “Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр” төслийн захирал Б.Мөнхтуулын 2022 оны 3 дугаар сарын 4-ний өдрийн 7/988 тоот “Асуумж авах тухай” албан бичиг (**хавсралт-6**)-ийг, үнэлгээ хийх аргачлалын хамт 322 СЭМТ-ийн дарга, статистикч бага эмч нарт цахим шуудангаар хүргүүлсэн. 40 гаруй СЭМТ-ийн мэйл хаяг алдаа өгсөн. Эдгээр сумдтай утсаар холбогдож, өөр цахим шуудангийн хаяг авч, дахин илгээсэн. 60 гаруй СЭМТ-ийн үнэлгээний асуумж бөглөхтэй холбоотой асуултанд, мэйлээр болон утсаар хариу өгсөн.

GOOGLE FORM-д 226 СЭМТ бөглөж хариу ирүүлснээс, нэг СЭМТ-өөс 2 өөр хүн бөглөсөн, хариултууд дутуу зэрэг 22 СЭМТ-ийн хариултыг өгөгдлийн сангаас хасч 204 СЭМТ-ийн өгөгдлийн санд статистикийн анализ, дүгнэлт хийсэн.

3.4 Дэлхийн банкны аргачлалаар цуглуулсан өгөгдөл мэдээлэл

“Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг

сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр” төслийн зохицуулагч А.Мөнхтайваны баталсан “Анхан шатны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагын үйл ажиллагааны түргэвчилсэн үнэлгээ”-г Булган, Хөвсгөл аймагт хийх үнэлгээний ажлын удирдамж (**хавсралт-7**)-ийн дагуу 2022 оны 3 дугаар сарын 21-25-ны өдрүүдэд Булган аймгийн ЭМГ, Дашинчилэн, Орхон, Баяннуур сумын ЭМТ, Хутаг-Өндөр сум дундын эмнэлэг, “Эмийн цэцэглэн” өрхийн ЭМТ, Хөвсгөл аймгийн ЭМГ, Тариалан, Алаг-Эрдэнэ, Тосонцэнгэл, Хатгал сумын ЭМТ, Их-Уул сум дундын эмнэлэгт тус тус очиж, эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ (ЭМАШТҮ) үзүүлэгч байгууллагын үйл ажиллагаатай танилцаж, Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн ЭМАШТҮ-ний өнөөгийн байдалд Дэлхийн банкны аргачлалаар үнэлэлт дүгнэлт өгч, ӨЭМТ, СЭМТ-өөр үйлчлүүлэгчдээс сэтгэл ханамжийн судалгаа авч, төслийн хүрээнд Булган аймгийн Дашинчилэн СЭМТ, Хөвсгөл аймгийн Тариалан СЭМТ-ийн шинээр барих байрны үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай өгөгдөл мэдээллийг цуглуулсан.

Мөн Дорноговь аймагт хийх ажлын удирдамж (**хавсралт-8**)-ийн дагуу 2022 оны 3 дугаар сарын 28, 29-ний өдрүүдэд Дорноговь аймгийн ЭМГ, Эрдэнэ СЭМТ, “Мишээл мана-3” ӨЭМТ-ийн үйл ажиллагаатай танилцаж, Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн ЭМАШТҮ-ний өнөөгийн байдалд Дэлхийн банкны аргачлалаар үнэлэлт дүгнэлт өгч, ӨЭМТ, СЭМТ-өөр үйлчлүүлэгчдээс сэтгэл ханамжийн судалгаа авч, төслийн хүрээнд Эрдэнэ СЭМТ-ийн шинээр барих байрны үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай мэдээллийг цуглуулсан.

Дэлхийн банкны аргачлалаар сум, өрхийн эрүүл мэндийн төвийн ЭМАШТҮ-ний өнөөгийн байдалд дараах 4 чиглэлээр ярилцаж үнэлгээ өгсөн. Үүнд:


1. Тусламж, үйлчилгээ үзүүлж буй барилга байгууламж, орчны үнэлгээ
2. Халдвартай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа
3. Эмийн хангалт, зохион байгуулалтын үнэлгээ
4. Тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлын үнэлгээ.

Энэхүү аргачлалын дагуу нийслэл Улаанбаатар болон 3 аймгийн нийтдээ 14 ӨЭМТ, СЭМТ-ийн (**хавсралт-9**) тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа өрөө тасалгаануудаар тойрч танилцаад, төвийн дарга, ахлах сувилагч нартай уулзаж ярилцаж, бэлтгэсэн асуумжийн дагуу үнэлгээ хийсэн.

4. ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

4.1 ӨЭМТ-ийн тусламж үйлчилгээний өнөөгийн байдал

График 1. Өрхийн эрүүл мэндийн төвийн ерөнхий үнэлгээ




Өрхийн эрүүл мэндийн төвийн ерөнхий үнэлгээний дээрх графикаас харахад хамгийн бага үзүүлэлтүүд нь “Тоног төхөөрөмжийн чанар, аюулгүй ажиллагаа” – 3.38, “Тоног төхөөрөмжийн чанар, аюулгүй ажиллагаа” – 3.52, “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын удирдлага” – 3.88 оноогоор тус тус үнэлэгдсэн нь цаашид эдгээр үзүүлэлтүүд дээр анхаарч, сайжруулах шаардлагатайг харуулж байна.

График 2. ӨЭМТ-ийн засаглал, удирдлага, манлайлалын үнэлгээ




Дээрх графикаас харахад хамгийн бага үзүүлэлтүүд нь “Ажилтнуудад хууль зүйн ба сэтгэл зүйн зөвлөгөө өгөх нөхцөлийг бүрдүүлсэн байх” – 3.0, “Судалгаа, шинжилгээнд үндэслэсэн дунд хугацааны хөгжлийн стратеги төлөвлөгөөтэй, хэрэгжилтэд үнэлгээ хийсэн, үр дүнг тооцсон байх” – 3.4, “Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллаж мэргэжил аргазүйн дэмжлэг авдаг байх” – 3.5 оноогоор тус тус үнэлэгдсэн байна.

График 3. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын удирдлага




Дээрх графикаас харахад хамгийн бага үзүүлэлтүүд нь “Тусламж, үйлчилгээг үзүүлэх явцад үйлчлүүлэгчийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх нөхцөл байдал үүссэн тохиолдлыг бүртгэж, хариу арга хэмжээ авдаг байх” – 3.3, “Тусламж, үйлчилгээний аюулгүй байдлыг хангах журамтай, зохион байгуулалтыг бүх нэгжид хийсэн байх” – 3.4, “Эрсдэлийг үнэлэх, эрэмбэлэх, хариу арга хэмжээ авах үйл ажиллагааг тогтмолжуулсан байх” – 3.6 оноогоор тус тус үнэлэгдсэн байна.

График 4. ӨЭМТ-ийн хүний нөөцийн хөгжил




Дээрх графикаас харахад хамгийн бага үзүүлэлтүүд нь “Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг гадаад, дотоод сургалтанд хамруулж хөгжүүлдэг тогтолцоо бүрдэж, үйл ажиллагаа хэвшсэн байх” – 2.2, “Хүний нөөцийн хөгжлийн (төгсөлтийн дараах сургалт, эрдмийн болон мэргэжлийн зэрэг гэх мэт) хөтөлбөр/төлөвлөгөө батлан, хэрэгжүүлдэг байх” – 3.1, “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авдаг байх” – 3.3 оноогоор тус тус үнэлэгдсэн байна.

График 5. ӨЭМТ-ийн мэдээллийн удирдлага, аюулгүй байдал




Дээрх графикаас харахад хамгийн бага үзүүлэлтүүд нь “Байгууллага нь гадаад сүлжээтэй (цахим хуудас, Facebook page гэх мэт), байнга баяжилт хийгддэг, ашигладаг байх” – 3.0, “Хөтлөгдөх анхан шатны баримт бичгийн хөтлөлт, үг товчлол, тэмдэг, тэмдэглэгээг тодорхойлж, ашиглах заавар, зохицуулалтыг хийсэн байх” – 3.7, “Байгууллага нь тусламж, үйлчилгээний үзүүлэлтүүд, хүний нөөц, багаж тоног төхөөрөмж, эм эмнэлгийн хэрэгсэл, санхүү зэрэг чиглэлээр 5 жилээс доошгүй хугацаагаар үүсгэсэн мэдээний сантай байх” – 3.7 оноогоор тус тус үнэлэгдсэн байна.

График 6. ӨЭМТ-ийн тоног төхөөрөмжийн чанар, аюулгүй ажиллагаа, техникийн засвар, үйлчилгээ



Дээрх графикаас харахад хамгийн бага үзүүлэлтүүд нь “Тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны дүрэм, заавартай, санамжийг холбогдох ажлын байран дээр байрлуулж, хяналт тавьдаг байх” – 2.6, “Тоног төхөөрөмжийг ашиглах, ажиллуулах, аюулгүй ажиллагааны сургалтыг хийдэг байх” – 2.7, “Багаж, тоног төхөөрөмжийн техник ашиглалтын паспорт, цаг ашиглалтыг тогтмол хөтөлдөг байх” – 2.8 оноогоор тус тус үнэлэгдсэн байна.

График 7. ӨЭМТ-ийн барилга, инженерийн байгууламжийн аюулгүй ажиллагаа



Дээрх графикаас харахад хамгийн бага үзүүлэлтүүд нь “Байгууллагын гадаад орчин, барилга байгууламж нь эрүүл ахуйн шаардлага хангасан байх” – 1.9, “Байгууллагын хүчин чадалд тохирсон цахилгааны нөөц үүсгэвэртэй байх” – 2.4, “Байгууллага нь барилга, инженерийн байгууламжийн байршил, бүрэлдэхүүн хэсгүүдийг харуулсан схем, зураглалтай байх” – 2.6 оноогоор тус тус үнэлэгдсэн байна.

4.2 СЭМТ-ийн тусламж үйлчилгээний өнөөгийн байдал

"Анхан шатны эрүүл мэндийн тусламж үйлчилгээний байгууллагуудын өнөөгийн байдлын түргэвчилсэн үнэлгээ"-нд нийт СЭМТ-үүдийн 63,4 хувь нь хамрагдсан. Орхон, Төв, Сэлэнгэ, Өмнөговь аймгуудын СЭМТ-үүдийн хамрагдалт хангалтгүй (**хүснэгт-1**) байсан. Харин Хөвсгөл, Ховд, Говьсүмбэр аймгууд бүх сумдууд хамрагдсан байна. Үнэлгээний асуумжийг статистикч бага эмч нар 59,3 хувь, төвийн дарга 32,8 хувь, их эмч 7,8 хувь тус тус бөглөсөн байна.

Хүснэгт 1. Түргэвчилсэн үнэлгээний хамрагдалт, асуумж бөглөсөн байдал

№	Аймгийн нэр	Нийт СЭМТ-ийн тоо	Үнэлгээнд хамрагдсан СЭМТ-ийн тоо	Хамрагдалтын хувь	Үнэлгээний асуумж бөглөсөн			Бүгд
					Төвийн дарга	Их эмч	Статистикч бага эмч	
1	Архангай	18	17	94.4	4	1	12	17
2	Баян-Өлгий	14	10	71.4	3	0	7	10
3	Баянхонгор	19	14	73.7	4	3	7	14
4	Булган	16	12	75.0	4	0	8	12
5	Говь-Алтай	19	10	52.6	4	3	3	10
6	Говь-Сүмбэр	2	2	100.0	1	1	0	2
7	Дархан-Уул	3	2	66.7	1	0	1	2
8	Дорноговь	13	11	84.6	4	0	7	11
9	Дорнод	13	7	53.8	4	1	2	7
10	Дундговь	15	9	60.0	7	0	2	9
11	Завхан	22	11	50.0	3	2	6	11
12	Орхон	1	0	0.0	0	0	0	0
13	Өвөрхангай	17	12	70.6	4	0	8	12
14	Өмнөговь	14	5	35.7	1	0	4	5
15	Сүхбаатар	12	6	50.0	5	0	1	6
16	Сэлэнгэ	21	6	28.6	3	1	2	6
17	Төв	26	6	23.1	4	0	2	6
18	Увс	18	13	72.2	2	0	11	13
19	Ховд	15	15	100.0	3	1	11	15
20	Хөвсгөл	23	23	100.0	2	3	18	23
21	Хэнтий	21	13	61.9	4	0	9	13
Бүгд		322	204	63.4	67	16	121	204
Эзлэх хувь					32.8	7.8	59.3	

Үнэлгээнд хамрагдсан 204 СЭМТ-ийн мэдээний санд боловсруулалт хийж, дараах үр дүнг гаргаж авсан.

График 8. Сумын эрүүл мэндийн төвийн ерөнхий үнэлгээ


Сумын эрүүл мэндийн төвийн ерөнхий үнэлгээний дээрх графикаас харахад хамгийн бага үзүүлэлтүүд нь “Тоног төхөөрөмжийн чанар, аюулгүй ажиллагаа, засвар, техникийн үйлчилгээ” – 3.70, “Барилга, инженерийн байгууламжийн аюулгүй ажиллагаа” – 3.93, “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын удирдлага” – 3.95 оноогоор тус тус үнэлэгдсэн нь цаашид эдгээр үзүүлэлтүүд дээр анхаарч, сайжруулах шаардлагатайг харуулж байна.

График 9. СЭМТ-ийн засаглал, удирдлага, манлайлалын үнэлгээ



Дээрх графикаас харахад хамгийн бага үзүүлэлтүүд нь “Ажилтнуудад хууль зүйн ба сэтгэл зүйн зөвлөгөө өгөх нөхцөлийг бүрдүүлсэн байх” – 3.53, “Судалгаа, шинжилгээнд үндэслэсэн дунд хугацааны хөгжлийн стратеги төлөвлөгөөтэй, үнэлгээ хийсэн, үр дүнг тооцсон байх” – 3.76, “Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах хөтөлбөр/ төлөвлөгөөг хэрэгжүүлж, үр дүнтэй ажилладаг байх” – 3.77 оноогоор тус тус үнэлэгдсэн байна.

График 10. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын удирдлага



Дээрх графикаас харахад хамгийн бага үзүүлэлтүүд нь “Үйл ажиллагаа, үзүүлж буй тусламж, үйлчилгээнд тохирсон чанар, аюулгүй байдлыг хэмжих өвөрмөц шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулан баталсан, хэмжилт, дүн шинжилгээ хийдэг байх” – 3.67, “Эрсдэлийг үнэлэх, эрэмбэлэх, хариу арга хэмжээ авах чиглэлээр байгууллагын ажилтнуудыг сургадаг байх” – 3.74, “Эрсдэлийг үнэлэх, эрэмбэлэх, хариу арга хэмжээ авах үйл ажиллагааг тогтмолжуулсан байх” – 3.79 оноогоор тус тус үнэлэгдсэн байна.

График 11. СЭМТ-ийн хүний нөөцийн хөгжил



Дээрх графикаас харахад хамгийн бага үзүүлэлтүүд нь “Үзүүлж буй тусламж, үйлчилгээндээ дүн шинжилгээ хийж, эмч, эмнэлгийн мэргэжилтэн бүр эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийдэг, хэвшсэн байх” – 3.27, “Ажлын байрны хөдөлмөрийн эрүүл ахуйн нөхцөлд үнэлгээ хийлгэж, арга хэмжээ авдаг байх” – 3.82, “Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг гадаад, дотоод сургалтанд хамруулж хөгжүүлдэг тогтолцоо бүрдэж, үйл ажиллагаа хэвшсэн байх” – 3.88 оноогоор тус тус үнэлэгдсэн байна.

График 12. СЭМТ-ийн мэдээллийн удирдлага, аюулгүй байдал




Дээрх графикаас харахад хамгийн бага үзүүлэлтүүд нь “Зайнаас /телемедицина/ эмнэлзүйн зөвлөгөө авдаг тогтолцоог бүрдүүлсэн байх” – 3.26, “Тусламж, үйлчилгээнд цаг товлох үйлчилгээг нэвтрүүлсэн байх” – 3.46, “Байгууллагын хөгжлийн төлөвлөгөөнд мэдээллийн удирдлагыг сайжруулах арга хэмжээг тусгасан, хэрэгжүүлдэг байх” – 3.83 оноогоор тус тус үнэлэгдсэн байна.

График 13. СЭМТ-ийн тоног төхөөрөмжийн чанар, аюулгүй ажиллагаа, техникийн засвар, үйлчилгээ



Дээрх графикаас харахад хамгийн бага үзүүлэлтүүд нь “Рентген туяаны хор нөлөөнөөс сэргийлэх арга хэмжээ авдаг байх” – 2.25, “Цацрагийн үүсгүүртэй рентген тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авдаг байх” – 2.47, “Тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг төлөвлөгөө, графикийн дагуу хийдэг байх” – 3.40 оноогоор тус тус үнэлэгдсэн байна.

График 14. СЭМТ-ийн барилга, инженерийн байгууламжийн аюулгүй ажиллагаа



Дээрх графикаас харахад хамгийн бага үзүүлэлтүүд нь “Даралтат сав, хийн баллоны аюулгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн байх” – 3.31, “Байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор гадны байгууллагаар гүйцэтгүүлэх инженерийн үйлчилгээг хийж гүйцэтгүүлдэг гэрээтэй байх” – 3.44, “Барилга, инженерийн байгууламжийн хэвийн ажиллагааг хянан шалгаж, сайжруулдаг тогтолцоо бүрдсэн байх” – 3.50 оноогоор тус тус үнэлэгдсэн байна.

4.3 Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгааны үр дүн


Эмнэлгийн мэргэжилтэн бүр эерэг хандлага, зөв харилцаатай, ёс зүйн өндөр түвшинд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг иргэн бүрт чанартай хүргэж чадаж байгаа эсэхийг иргэдийн сэтгэл ханамжаар тодорхойлдог.

Манай зөвлөх баг нийслэлийн 5 дүүргүүд болон хөдөөгийн 3 аймгийн 10 гаруй сум, ӨЭМТ-өөр үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгааг хийсэн.


4.3.1 Нийслэлийн иргэдийн сэтгэл ханамжийн судалгааны үр дүн

Нийслэлийн 98 иргэд сэтгэл ханамжийн судалгаанд хамрагдсан. Судалгаанд хамрагдагсдын дундаж нас 44.9 байна.


График 15. Сэтгэл ханамжийн судалгаанд хамрагдагсад, хүйсээр



Судалгаанд хамрагдагсдын 71 хувь эмэгтэйчүүд байна. Судалгаа хийх үед ӨЭМТ-өөр үйлчлүүлэгсдийн дунд эмэгтэйчүүд дийлэнх нь байсан.


График 16. Судалгаанд хамрагдагсад, нийслэлийн дүүргээр

Судалгаанд хамрагдагсдыг нийслэлийн дүүргүүдийн ӨЭМТ-ээр үйлчлүүлэгчдээс ойролцоо тоогоор судалгаанд хамруулсан.

График 17. Судалгаанд хамрагдагсдын ажил, хөдөлмөр эрхлэлтийн байдал

Дээрх графикаас харахад судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгчдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал нь төрийн байгууллагын ажилтнууд 31 хувь буюу хамгийн их, оюутан, тэтгэврийн болон групптэй иргэд 27 хувь, хувийн хэвшил, компанийн ажилтнууд 17 хувь, ажилгүй иргэд 10 хувь тус тус эзэлж байна.


График 18. Судалгаанд хамрагдагсдын эмнэлгээр үйлчлүүлсэн байдал




Дээрх графикаас харахад үйлчлүүлэгчдийн эмнэлгээр үйлчлүүлсэн давтамж нь жилд 4 ба түүнээс дээш удаа үйлчлүүлсэн 45 хувь, 2-3 удаа үйлчлүүлсэн 34 хувь, жилд 1 удаа 20 хувь, үйлчлүүлж байгаагүй 1 хувь гэж тус тус хариулсан байна.

График 19. Судалгаанд хамрагдагсад эмнэлгээр үйлчлүүлэхэд тулгардаг бэрхшээлүүд


Судалгаанд хамрагдагсад эмнэлгээр үйлчлүүлэхэд ямар нэг бэрхшээл тохиолддог 46.9%, Удаан хүлээдэг – 32%, Хүнд сурталтай – 15,5%, Цагийн хуваариа мөрддөггүй -11,7, Эмч, эмнэлгийн ажилтны зан харьцаа муу - 10,7% гэж тус тус хариулсан байна.

График 20. Эмнэлгийн үйлчилгээний шуурхай байдал

Дээрх графикаас харахад “Таны үйлчлүүлсэн эмнэлгийн үйлчилгээ хэр зэрэг түргэн шуурхай, эелдэг байсан бэ?” гэсэн асуултад үйлчлүүлэгчдийн 47 хувь нь “Сайн”, 33 хувь нь “Дунд”, 9 хувь нь “Муу”, 8 хувь нь “Маш сайн”, 3 хувь нь “Маш муу” гэж тус тус хариулсан байна.

График 21. Эмнэлгийн ая тухтай байдал

Дээрх графикаас харахад “Таны үйлчлүүлсэн эмнэлгийн дотоод орчин хэр тохилог, ая тухтай, цэвэрхэн байсан бэ?” гэсэн асуултад үйлчлүүлэгчдийн 55 хувь нь “Сайн”, 38 хувь нь “Дунд”, 4 хувь нь “Муу”, 2 хувь нь “Маш сайн”, 1 хувь нь “Маш муу” гэж тус тус хариулсан байна.

График 22. Эмнэлгийн ажилтнуудын харилцаа, ёс зүйн байдал

Дээрх графикаас харахад “Эмч, эмнэлгийн ажилчдын харилцаа, ёсзүйг ямар гэж дүгнэдэг вэ?” гэсэн асуултад үйлчлүүлэгчдийн 54 хувь нь “Сайн”, 31 хувь нь “Дунд”, 6 хувь нь “Маш сайн”, 5 хувь нь “Маш муу”, 4 хувь нь “Муу” гэж тус тус хариулсан байна.

Хүснэгт 2. Хотын үйлчлүүлэгчдээс нэн тэргүүнд шийдвэрлэх асуудлуудын талаар гаргасан саналууд


Үйлчлүүлэгчдээс нэн тэргүүнд шийдвэрлэх асуудлуудын талаар гаргасан саналууд	Саналын тоо
Эмч, эмнэлгийн ажилтнуудын харилцааны соёл дээшлүүлэх	26
Түргэн шуурхай үйлчлэх	21
Эмнэлгийн барилга, байгууламжийг сайжруулах	19
Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлэх	18
Эмнэлгийн орчныг сайжруулах	11
Хүнд суртлыг багасгах	10
Шинжилгээний нэр төрөл, тоог нэмэгдүүлэх	10
Тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах	8
Хүний нөөцийг нэмэгдүүлэх	8
Ялган гадуурхахгүй байх	7
Үзлэгийн ерөөний зай талбайг нэмэгдүүлэх	7
Удаан хүлээдэг, дугаарлуулдгыг багасгах	6
Үйлчилгээний чанарыг сайжруулах	6
Автомашинь зогсоолыг шийдвэрлэх	4
Үзлэгийн цагийг нэмэгдүүлэх	3
Үзлэгээ цагтаа эхлэх	3
Танил тал хардгыг багасгах	2
Үйлчлүүлэгчээ хүндэлдэг болох	2
Эмч, мэргэжилтний мэдлэгийг дээшлүүлэх	2
Цаг олголтын тогтолцоог боловсронгуй болгох	2
Үйлчилгээний мэдээллийг шуурхай, ил тод болгох	2
Цахимжуулах	2
Эмнэлгийн үйлчилгээг нэг дор төвлөрүүлэх	2
Эмч, мэргэжилтний цалинг нэмэгдүүлэх	2
Эмнэлгүүдийг оновчтой байршуулах	2
Өдрийн эмчилгээний төрөл, тоог нэмэгдүүлэх	1
Ажлын хариуцлага сайжруулах	1
Эмчийг тогтвор суурьшилтай ажиллах нөхцлөөр хангах	1
Эм, тариагаар бизнес хийхгүй байх	1
Үйлчилгээний соёлыг дээшлүүлэх	1
Туршлагагүй, залуу эмч ажиллуулдаг	1
Эмч нар үйлчлүүлэгчид нарийн учрыг тайлбарлаж өгдөггүй	1
Хүнлэг чанар дутагдах болсон	1
Мэргэжлийн эмч дутагдалтай	1
Эмийн үнийг бууруулах	1
Төсөв санхүүг нэмэгдүүлэх	1
Эмч, эмнэлгийн ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдэх	1
Эмчийн ёсзүйд анхаарах	1
Хувцас, хамгаалах хэрэгслээр хангах	1
Нийт саналын тоо	199

Үйлчлүүлэгчдээс “Эмч, эмнэлгийн ажилтнуудын харилцааны соёл дээшлүүлэх”, “Түргэн шуурхай үйлчлэх”, “Эмнэлгийн барилга, байгууламжийг сайжруулах”, “Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлэх” гэсэн саналууд хамгийн олон гарсан байна.

4.3.2 Хөдөөгийн иргэдийн сэтгэл ханамжийн судалгааны үр дүн

Хөдөөгийн 111 иргэд сэтгэл ханамжийн судалгаанд хамрагдсан. Судалгаанд хамрагдагсдын дундаж нас 39.4 байна.

График 23. Судалгаанд хамрагдагсад, хүйсээр




Судалгаанд хамрагдагсдын 72 хувь эмэгтэйчүүд байна. Судалгаа хийх үед СЭМТ-өөр үйлчлүүлэгсдийн дунд эмэгтэйчүүд дийлэнх нь байсан.


График 24. Судалгаанд хамрагдагсад, сумдаар



Судалгаанд хамрагдагсдыг аймгуудын СЭМТ-ээр үйлчлүүлэгчдээс ойролцоо тоогоор судалгаанд хамруулсан.

График 25. Судалгаанд хамрагдагсад, хөдөлмөр эрхлэлт


Дээрх графикаас харахад судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгчдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал нь төрийн байгууллагын ажилтнууд 27 хувь буюу хамгийн их, оюутан, тэтгэврийн болон групптэй иргэд 26 хувь, хувийн хэвшил, компанийн ажилтнууд 11 хувь, хувиараа хөдөлмөр эрхэлдэг иргэд 10 хувь тус тус эзэлж байна.

График 26. Судалгаанд хамрагдагсдын эмнэлгээр үйлчлүүлсэн байдал


Дээрх графикаас харахад үйлчлүүлэгчдийн СЭМТ-өөр үйлчлүүлсэн давтамж нь жилд 4 ба түүнээс дээш удаа үйлчлүүлсэн 45 хувь, 2-3 удаа үйлчлүүлсэн 40 хувь, жилд 1 удаа 15 хувь гэж тус тус хариулсан байна.

График 27. Судалгаанд хамрагдагсдад эмнэлгээр үйлчлүүлэхэд тулгардаг бэрхшээл

Судалгаанд хамрагдагсдад эмнэлгээр үйлчлүүлэхэд ямар нэг бэрхшээл тохиолддог 33.3%, Удаан хүлээдэг – 26.7%, Цагийн хуваариа мөрддөггүй -17,8% Эрүүл мэндийн даатгалгүй 11%, Хүнд сурталтай – 6.7%, Эмч, эмнэлгийн ажилтны зан харьцаа муу - 6,7% гэж тус тус хариулсан байна.

График 28. Эмнэлгийн үйлчилгээний шуурхай байдал

Дээрх графикаас харахад “Таны үйлчлүүлсэн эмнэлгийн үйлчилгээ хэр зэрэг түргэн шуурхай, эелдэг байсан бэ?” гэсэн асуултад үйлчлүүлэгчдийн 68 хувь нь “Сайн”, 19 хувь нь “Дунд”, 1 хувь нь “Муу”, 8 хувь нь “Маш сайн”, 4 хувь нь “Маш муу” гэж тус тус хариулсан байна.

График 29. Эмнэлгийн ая тухтай байдал

Дээрх графикаас харахад “Таны үйлчлүүлсэн эмнэлгийн дотоод орчин хэр тохилог, ая тухтай, цэвэрхэн байсан бэ?” гэсэн асуултад үйлчлүүлэгчдийн 59 хувь нь “Сайн”, 28 хувь нь “Дунд”, 2 хувь нь “Муу”, 6 хувь нь “Маш сайн”, 5 хувь нь “Маш муу” гэж тус тус хариулсан байна.

График 30. Эмнэлгийн ажилтнуудын харилцаа, ёс зүйн байдал

Дээрх графикаас харахад “Эмч, эмнэлгийн ажилчдын харилцаа, ёсзүйг ямар гэж дүгнэдэг вэ?” гэсэн асуултад үйлчлүүлэгчдийн 71 хувь нь “Сайн”, 22 хувь нь “Дунд”, 3 хувь нь “Маш сайн”, 3 хувь нь “Маш муу”, 1 хувь нь “Муу” гэж тус тус хариулсан байна.

Хүснэгт 3. Хөдөөгийн үйлчлүүлэгчдээс нэн тэргүүнд шийдвэрлэх асуудлуудын талаар гаргасан саналууд

Үйлчлүүлэгчдээс нэн тэргүүнд шийдвэрлэх асуудлуудын талаар гаргасан саналууд	Саналын тоо
Эмнэлгийн барилга, байгууламжийг сайжруулах	40
Халаалт дулааныг сайжруулах	25
Хүний нөөцийг нэмэгдүүлэх	16
Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлэх	16
Өрөө тасалгаа хүрэлцдэггүй	12
Ариун цэврийн ерөөний асуудлыг шийдвэрлэх	10
Шүдний эмчтэй болох	8
Ажиллах тав тухтай орчныг бүрдүүлэх	8
Эмнэлгийн орны тоог нэмэгдүүлэх	7
Эмнэлгийн орчныг сайжруулах	7
Түргэн шуурхай үйлчлэх	4
Автомашинь зогсоолыг шийдвэрлэх	4
Шороо тоос ихтэй	3
Эмч, мэргэжилтний мэдлэгийг дээшлүүлэх	2
Цэвэр ус уух орчин бүрдүүлэх	2
Төсөв санхүүг нэмэгдүүлэх	2
Эмч, эмнэлгийн ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдэх	2
Эмч, эмнэлгийн ажилтнуудын харилцааны соёл дээшлүүлэх	1
Лабораторийг сайжруулах	1
Хүнд суртлыг багасгах	1
Тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах	1
Үзлэгийн ерөөний зай талбайг нэмэгдүүлэх	1
Эм тарианы хангамжийг нэмэгдүүлэх	1
Удирдлага зохион байгуулалтыг сайжруулах	1
Удаан хүлээдэг, дугаарлуулдгыг багасгах	1
Үзлэгийн цагийг нэмэгдүүлэх	1
Үзлэгээ цагтаа эхлэх	1
Нөхөн сэргээх эмчилгээ хийдэг байх	1
Үйлчлүүлэгчээ хүндэлдэг болох	1
Эмч, мэргэжилтний цалинг нэмэгдүүлэх	1
Хүнлэг чанар дутагдах болсон	1
Эмчийн ёсзүйд анхаарах	1
Нийт саналын тоо	183

Үйлчлүүлэгчдээс “Эмнэлгийн барилга, байгууламжийг сайжруулах”, “Халаалт дулааныг сайжруулах”, “Хүний нөөцийг нэмэгдүүлэх”, “Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлэх” гэсэн саналууд хамгийн олон гарсан байна.

4.4 Дэлхийн банкны аргачлалаар хийсэн үнэлгээний үр дүн

4.4.1 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж буй барилга байгууламж, орчны үнэлгээ

Дэлхийн банкны Эрүүл мэндийн байгууллагуудын үнэлгээний аргачлалын дагуу сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн барилга байгууламж, хэсэг, нэгжийн үйл ажиллагаатай биечлэн танилцаж, төвийн дарга, ахлах сувилагч, статистикийн бага эмч нартай ярилцаж, “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж буй барилга байгууламж, орчны үнэлгээ” хийж, дараах түргэвчилсэн үнэлгээг (**Хүснэгт 4**) хийсэн.

Хүснэгт 4. СЭМТ, ӨЭМТ-ийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж буй барилга байгууламж, орчны үнэлгээ

№	Эрүүл мэндийн төвийн нэр	Давуу тал	Сул тал	Үнэлгээний оноо
1	Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 17 дугаар хорооны “Увидаст-Од” ӨЭМТ	Турк улсын тусламжтай 2019 онд баригдсан шинэ барилгатай. Гадна дотно орчин маш тохилог, үзлэгийн өрөөнүүд стандартын дагуу том, гэрэлтүүлэг сайн. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд үйлчлэх нөхцөлтэй. Хүлээлгийн талбайтай. Аюулгүй байдал сайн хангагдсан. Үйлчлүүлэгчдэд зориулсан мэдээллийн самбартай.	Шүдний тоног төхөөрөмж, өрөөтэй боловч шүдний эмчгүй, 4Д эхо-аппарат ашиглалт муутай, 600 м.кв талбайн урсгал зардал өндөр, цахилгаан ашигласан өртэй. Ундны ус доголддог.	10 оноо
2	Хөвсгөл аймгийн Их-Уул СЭМТ	Улсын төсвөөр 2019 онд баригдсан 2 давхар шинэ барилгатай. Гадна дотно орчин маш тохилог, үзлэгийн өрөөнүүд стандартын дагуу том, гэрэлтүүлэг сайн. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд үйлчлэх нөхцөлтэй. Аюулгүй байдал сайн хангагдсан. Хүлээлгийн талбайтай. Үйлчлүүлэгчдэд зориулсан мэдээллийн	Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан нэвтрэх боломжтойгоор тохижуулсан боловч лифт суурилуулаагүй бөгөөд тэргэнцэртэй хүмүүсийг ажилчид хоёрдугаар давхарт өргөх шаардлага гардаг. Энэ нь ажилтан болон өвчтнийг гэмтэх эрсдэлд оруулна.	9 оноо

		самбартай. Үйлчлүүлэгчдийн болон ажилтнуудын ариун цэврийн өрөөг давхар бүрт шийдсэн.		
3	Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл СЭМТ	Улсын төсвөөр 2020 онд баригдсан 3 давхар шинэ барилгатай. Гадна дотно орчин маш тохилог, үзлэгийн өрөөнүүд стандартын дагуу том, гэрэлтүүлэг сайн. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд үйлчлэх нөхцөлтэй. Хүлээлгийн талбайтай. Аюулгүй байдал сайн хангагдсан. Үйлчлүүлэгчдэд зориулсан мэдээллийн самбартай. Үйлчлүүлэгчдийн болон ажилтнуудын ариун цэврийн өрөөг давхар бүрт шийдсэн.	Төрөх өрөө, төрсний дараах өрөөнүүд хэтэрхий том тул өвөл хүйтэн тул ашиглаагүй. Цахилгаан шатгүй тул яаралтай тусламжийг 1 давхарт шилжүүлсэн. Ашигласан тариурын зүүг цаасан хайрцагт хийж байгаа, эмнэлгийн ажилтан гэмтэх эрсдэлтэй.	8 оноо
4	Булган аймгийн Баяннуур СЭМТ	Төвийн 1 давхар барилга 1983 онд баригдсан, 2020 онд их засвар хийсэн. Төвийн дотно орчин тохилог, таатай орчин бүрдүүлсэн. Хүлээлгийн талбайтай. Аюулгүй байдал сайн хангагдсан.	Магадлан итгэмжлэл; үйлчилгээ үзүүлэх, гэх мэт байгууллагын талаарх мэдээлэл хязгаарлагдмал. Ажилтнууд энгэртээ нэрийн тэмдэг зүүхгүй байгаа нь ажиглагдсан. Ашигласан тариурын зүүг цаасан хайрцагт хийж байгаа, эмнэлгийн ажилтан гэмтэх эрсдэлтэй.	7 оноо
5	Булган аймгийн Хутаг-Өндөр СЭМТ	Төвийн 2 давхар барилга 2002 онд, амбулаторийн барилга 2016 онд тус тус баригдсан. Аюулгүй байдал сайн хангагдсан. Үзлэгийн өрөөнүүд зориулалтын дагуу тохиромжтой. Ундны усны хангамж хангалттай. Ажилчдын нэр, зургийг нүдэнд тусах газарт	Тус байгууламж нь үйлчилгээ үзүүлэх хязгаарлагдмал орчинтой. Магадлан итгэмжлэл, үйлчилгээ үзүүлэх, гэх мэт байгууллагын талаарх мэдээлэл хязгаарлагдмал. Үйлчлүүлэгчийн хүлээлгийн	7 оноо

		байрлуулсан бөгөөд олон нийтийн санал асуулга авах хайрцагтай.	талбай хязгаарлагдмал. Ашигласан тариурын зүүг цаасан хайрцагт хийж байгаа, эмнэлгийн ажилтан гэмтэх эрсдэлтэй.	
6	Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ СЭМТ	Төвийн 2 давхар барилга 2008 онд баригдсан. Аюулгүй байдал сайн хангагдсан. Үзлэгийн өрөөнүүд жижиг боловч зориулалтын дагуу тохиромжтой. Ажилчдын нэр, зургийг нүдэнд тусах газарт байрлуулсан бөгөөд олон нийтийн санал асуулга авах хайрцагтай.	Хөгжлийн бэрхшээлтэй, хөдөлмөрийн чадваргүй хүмүүсийн хэрэгцээг зохих ёсоор хангах дотоод чадавхи байхгүй. Үйлчлүүлэгчийн хүлээлгийн хязгаарлагдмал талбайтай. Ашигласан тариурын зүүг цаасан хайрцагт хийж байгаа, эмнэлгийн ажилтан гэмтэх эрсдэлтэй. Ажилтнууд энгэртээ нэрийн тэмдэг зүүхгүй байгаа нь ажиглагдсан. Төвийн дотор ариун цэврийн өрөөнүүд ажиллахгүй байсан.	6 оноо
7	Дорноговь аймаг “Мишээлт мана” ӨЭМТ	2019 онд баригдсан байрны 1 дүгээр давхарт байрладаг, сайн нөхцөлтэй бетон барилгатай. Магадлан итгэмжлэл, үйлчилгээ үзүүлэх, гэх мэт байгууллагын талаарх мэдээллийг тавьсан байна. Үзлэгийн өрөөнүүд жижиг боловч зориулалтын дагуу тохиромжтой. Аюулгүй байдал сайн хангагдсан. Ажилтнууд энгэртээ нэрийн тэмдэг зүүсэн байна. Ундны усны хангамж хангалттай.	Байгууламж нь жижиг хавчигдмал зай талбайтай. Ашигласан тариурын зүүг цаасан хайрцагт хийж байгаа, эмнэлгийн ажилтан гэмтэх эрсдэлтэй.	6 оноо
8	Хөвсгөл аймгийн Тариалан СЭМТ	Төвийн барилга 1995 онд баригдсан. Төслийн санхүүжилтээр шинэ барилга барихаар төлөвлөгдсөн.	Байгууламж нь 3 барилгаас бүрдсэн, муу нөхцөлтэй. Үзлэгийн өрөөнүүд хэмжээний хувьд	5 оноо

		Ажилтнууд энгэртээ нэрийн тэмдэг зүүж байна. Ундны усны хангамж хангалттай.	хязгаарлагдмал. Үйлчлүүлэгчийн хүлээлгийн талбай хязгаарлагдмал. Аюулгүй байдлын менежмент муу.	
9	Нийслэлийн Баянзүрх дүүргийн 17 дугаар хорооны “Орхон түшээ мөрөн” ӨЭМТ	Үзлэгийн өрөөнүүд хангалттай зай бүхий дотоод хуваалтаар тохижуулсан түрээсийн байранд үйлчилгээ үзүүлж байна. Гэрэлтүүлэг, дотоод тохижилт сайн. Төслийн санхүүжилтээр шинэ барилга барихаар төлөвлөгдсөн. Аюулгүй байдлын менежмент сайн. Үйлчлүүлэгчийн хүлээлгийн талбайтай.	Төвийн 1999 онд баригдсан байр нь цууралт өгч, мэргэжлийн хяналтын байгууллагаас үйлчилгээ явуулахыг хориглосон тул, түрээсийн байранд байрлаж байна. Магадлан итгэмжлэл, нөхөрлөлийн байгууллагууд, үйлчилгээ үзүүлэх, гомдол гаргах журам гэх мэт байгууллагын талаарх мэдээлэл байхгүй. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тусгай үйлчилгээ байхгүй. Байгууламжид халуун усны хангамж байхгүй.	5 оноо
10	Булган аймгийн Дашинчилэн СЭМТ	Төслийн санхүүжилтээр шинэ барилга барихаар төлөвлөгдсөн. Үзлэгийн өрөөнүүд нь жижиг боловч гэрэлтүүлэг, агааржуулалт сайтай. Ажилтнууд болон үйлчилгээний талаарх мэдээллийг ил тод байрлуулсан. Дотоод тохижилт сайн. Аюулгүй байдлын менежмент сайн. Ундны усны хангамж хангалттай.	Төвийн барилга 1988 онд баригдсан. Байгууламжийн нөхцөл байдал муу, засвар хийх шаардлагатай Үйлчлүүлэгчийн хүлээлгийн талбай хязгаарлагдмал. Байгууламжид халуун усны хангамж байхгүй. Ажилтнууд болон өвчтөнд зориулсан бие засах газар барилгын гадна байдаг.	4 оноо
11	Дорноговь аймгийн Эрдэнэ СЭМТ,	Төслийн санхүүжилтээр шинэ барилга барихаар төлөвлөгдсөн. Улсын төсвөөр өргөтгөлийн 300 м.кв талбайтай барилга баригдаж байна. Үзлэгийн	Төвийн барилга 1999 онд баригдсан. Тус байгууламжийн байр байдал тааруу, зарим хананд нь бүтцийн эвдрэл, томоохон	4 оноо

		<p>ерөөнүүд нь жижиг боловч гэрэлтүүлэг, агааржуулалт сайтай. Ажилтнууд болон үйлчилгээний талаарх мэдээллийг ил тод байрлуулсан. Дотоод тохижилт сайн. Аюулгүй байдлын менежмент сайн.</p>	<p>ан цав үүссэн. Ундны усыг 18 км-ийн алсаас дамжуулах хоолойгоор хангадаг. Ажилтнууд энгэртээ нэрийн тэмдэг зүүхгүй байгаа нь ажиглагдсан. Үйлчлүүлэгчийн хүлээлгийн талбай хязгаарлагдмал.</p>	
12	Булган аймгийн Орхон СЭМТ	<p>Төвийн барилга 1957 онд баригдсан. Ирэх оны улсын төсөвт шинэ барилга барихаар төлөвлөсөн. Үзлэг, зөвлөгөө өгөх ерөөнүүд жижиг боловч, зориулалтын дагуу тохиромжтой. Аюулгүй байдлын менежмент сайн.</p>	<p>Барилга байгууламж нь үйлчилгээ үзүүлэх хязгаарлагдмал орчинтой, барилгын байр байдал муу нөхцөлтэй. Магадлан итгэмжлэл, үйлчилгээ үзүүлэх, гэх мэт байгууллагын талаарх мэдээлэл хязгаарлагдмал. Үйлчлүүлэгчийн хүлээлгийн талбай хязгаарлагдмал. Ундны усыг уг байгууламжаас 70 километрийн алсаас авдаг.</p>	3 оноо
13	Хөвсгөл аймаг, “Далай Элбэрэлт” ӨЭМТ	<p>Төвийн барилга 2008 онд баригдсан. Ундны усны хангамж хангалттай. Аюулгүй байдлын менежмент сайн. Үзлэгийн ерөөнүүд жижиг боловч зориулалтын дагуу тохиромжтой.</p>	<p>Байгууламж нь жижиг хавчигдмал зай талбайтай. Гэрэлтүүлэг муутай. Гадна, дотор тохижилт муутай. Үйлчлүүлэгчийн хүлээлгийн талбай хязгаарлагдмал.</p>	2 оноо
14	Нийслэлийн Хан-Уул дүүрэг 10-р хороо, “Амин тус” ӨЭМТ	<p>Төвийн барилга 2002 онд баригдсан. Төслийн санхүүжилтээр шинэ барилга барихаар төлөвлөгдсөн. Аюулгүй байдлын менежмент сайн.</p>	<p>Байшин барилгын бүтэц нь тааруу байдалтай байна. Үзлэг, зөвлөгөө өгөх ерөөнүүд жижиг, давчуу, гэрэлтүүлэг муутай. Хөгжлийн бэрхшээлтэй, тахир дутуу хүмүүст үйлчлүүлэхэд тохиромжгүй. Үйлчлүүлэгчийн хүлээлгийн талбай хязгаарлагдмал.</p>	2 оноо

			Төвд үйлчлүүлэгчдийн болон ажилтнуудын ариун цэврийн өрөө байхгүй. Зэргэлдээх орон сууцанд байрлах, салбар луу явдаг.	
15	Хөвсгөл аймгийн Хатгал СЭМТ	Төвийн барилга 2001 онд баригдсан. Магадлан итгэмжлэл, үйлчилгээ үзүүлэх, гэх мэт байгууллагын талаарх мэдээллийг тавьсан байна. Ажилчдын нэр, зургийг нүдэнд тусах газарт байрлуулсан. Олон нийтийн санал асуулга авах хайрцагтай. Үзлэг, зөвлөгөө өгөх өрөөнүүд жижиг боловч зориулалтын дагуу тохиромжтой.	Барилга, байгууламжийн бүтэц нь муу нөхцөлтэй, жижиг – модон байгууламж. Барилгын баруун тал суулт өгсөн. Улсын төсвөөр өргөтгөлийн барилга барьж байгаад, төсөв хүрэлцэхгүй шалтгаанаар зогссон. Хэвтүүлэн эмчлэх тасагт шөнөдөө 3-4 градус байдаг. Хэтэрхий хүйтнээс болж, үйлчлүүлэгчид тус СЭМТ-г алгасч, шууд Аймгийн Нэгдсэн Эмнэлгээр үйлчлүүлдэг байна. Төвд дотор ариун цэврийн өрөө байхгүй.	1 оноо

График 31. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж буй барилга байгууламж, орчны үнэлгээ



Дээрх графикаас харахад ЭМАШТҮ үзүүлж буй барилга байгууламж, орчны байдал эрс тэс ялгаатай байгаа нь харагдаж байна.

4.4.2 Халдвартай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үнэлгээ

Дэлхийн банкны Эрүүл мэндийн байгууллагуудын үнэлгээний аргачлалын дагуу сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн хэсэг, нэгжийн үйл ажиллагаатай биечлэн танилцаж, төвийн дарга, ахлах сувилагч, статистикийн бага эмч нартай ярилцаж, “Халдвартай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа”-нд дараах түргэвчилсэн үнэлгээг хийсэн (**Хүснэгт 5**).

Хүснэгт 5. СЭМТ, ӨЭМТ-ийн халдвартай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үнэлгээ

№	Эрүүл мэндийн төвийн нэр	Давуу тал	Сул тал	Үнэлгээний оноо
1	Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 17 дугаар хорооны “Увидаст-Од” ӨЭМТ	Байгууламж ерөнхийдөө өндөр түвшинд байгуулагдсан, Үзлэг, зөвлөгөөний бүх өрөөнд ус, угаагуур, нэг удаагийн алчуур зэрэг байна, Спиртийн агууламжтай гар ариутгагч байна, Ажилтнууд болон/эсвэл өвчтөнд зориулсан бие засах газар байна. Хувийн хамгаалах хэрэгсэл бэлэн, зохих ёсоор өмсдөг. Эмнэлгийн хог хаягдлын сав бэлэн, зөв шошготой - устгах ажлыг гэрээт компани гүйцэтгэдэг. Барилгын бүх шал цэвэрхэн. Ариутгалын процедурыг үр дүнтэй гүйцэтгэдэг- долоо хоног бүр гүн цэвэрлэж, хоёр цаг тутамд бүх газарт ариутгалын бодисоор цацдаг. Халдвартай байж болзошгүй өвчтөнүүдийг тусгаарлах газартай.	Хурц үзүүртэй зүйл хаях зориулалттай савнууд байдаг ч тэдгээр нь картон хайрцаг байдаг тул хэрэглэгчдийг болзошгүй гэмтэл бэртлээс зохих ёсоор хамгаалж чаддаггүй.	9 оноо
2	Хөвсгөл аймгийн Их-Уул СЭМТ	Байгууламж ерөнхийдөө өндөр түвшинд байгуулагдсан. Үзлэг, зөвлөгөөний өрөөнд ус, угаагуур зэрэг байна. Спиртийн агууламжтай гар ариутгагч байна. Ажилтнууд болон/эсвэл өвчтөнд зориулсан бие засах газар байна. Хувийн хамгаалах хэрэгсэл бэлэн, зохих ёсоор өмсдөг. Хурц үзүүртэй зүйл хаях зориулалттай хуванцар савнууд байдаг. Эмнэлгийн хог хаягдлын		10 оноо

		сав бэлэн, зөв шошготой. Барилгын бүх шал цэвэрхэн. Ариутгалын процедурыг үр дүнтэй гүйцэтгэдэг. Халдвараас урьдчилан сэргийлэх, хяналтын мэргэжилтэн нь халдварт өвчний бүх тохиолдлыг бүртгэж, мэдээлэх үүрэгтэй. Халдвартай байж болзошгүй өвчтөнүүдийг тусгаарлах газартай.		
3	Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл СЭМТ	Байгууламж ерөнхийдөө өндөр түвшинд байгуулагдсан. Үзлэгийн бүх өрөөнд ус, угаагуур, нэг удаагийн алчуур зэрэг байна. Спиртийн агууламжтай гар ариутгагч байна. Ажилтнууд болон/эсвэл өвчтөнд зориулсан бие засах газар байна. Хувийн хамгаалах хэрэгсэл бэлэн, зохих ёсоор өмсдөг. Эмнэлгийн хог хаягдлын сав бэлэн, зөв шошготой - устгах ажлыг гэрээт компани гүйцэтгэдэг. Барилгын бүх шал цэвэрхэн. Ариутгалын процедурыг үр дүнтэй гүйцэтгэдэг. Халдвартай байж болзошгүй өвчтөнүүдийг тусгаарлах газартай.	Хурц үзүүртэй зүйл хаях зориулалттай савнууд байдаг ч тэдгээр нь картон байдаг тул хэрэглэгчдийг болзошгүй гэмтэл бэртлээс зохих ёсоор хамгаалж чаддаггүй.	9 оноо
4	Булган аймгийн Баяннуур СЭМТ	Байгууламжид засвар хийсэн тул ерөнхийдөө сайн. Үзлэгийн өрөөнд ус, угаагуур зэрэг байна. Спиртийн агууламжтай гар ариутгагч байна. Ажилтнууд болон өвчтөнд зориулсан бие засах газар байна. Хувийн хамгаалах хэрэгсэл бэлэн, зохих ёсоор өмсдөг. Хурц үзүүртэй зүйл хаях зориулалттай картон хайрцаг савтай. Эмнэлгийн хог		10 оноо

		хаягдлын сав бэлэн, зөв шошготой. Барилгын бүх шал цэвэрхэн. Ариутгалын процедурыг үр дүнтэй гүйцэтгэдэг. Халдварт өвчний тохиолдлыг бүртгэж, шаардлагатай тохиолдолд мэдээлдэг. Халдвартай байж болзошгүй өвчтөнүүдийг тусгаарлах газартай.		
5	Булган аймгийн Хутаг-Өндөр СЭМТ	Байгууламж ерөнхийдөө хуучивтар боловч, эрүүл ахуйн шаардлага хангаж байна. Үзлэг, зөвлөгөөний өрөөнд ус, угаалтаар зэрэг байна. Спиртийн агууламжтай гар ариутгагч байна. Ажилтнууд болон өвчтөнд зориулсан бие засах газар байна. Хувийн хамгаалах хэрэгсэл бэлэн, зохих ёсоор өмсдөг. Эмнэлгийн хог хаягдлын сав бэлэн, зөв шошготой. Барилгын бүх шал цэвэрхэн. Ариутгалын процедурыг үр дүнтэй гүйцэтгэдэг. Халдварт өвчний тохиолдлыг бүртгэж, шаардлагатай тохиолдолд мэдээлдэг. Халдвартай байж болзошгүй өвчтөнүүдийг тусгаарлах газартай.	Хурц үзүүртэй зүйл хаях зориулалттай савнууд байдаг ч тэдгээр нь картон байдаг тул хэрэглэгчдийг болзошгүй гэмтэл бэртлээс зохих ёсоор хамгаалж чаддаггүй.	8 оноо
6	Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ СЭМТ	Байгууламжийн байр байдал ерөнхийдөө маш хязгаарлагдмал хэдий ч ажилчид өөрсдийн чадамжаараа сайн стандартад хүргэж ажиллаж байна. Спиртийн агууламжтай гар ариутгагч байна. Хувийн хамгаалах хэрэгсэл бэлэн, зохих ёсоор өмсдөг. Эмнэлгийн хог хаягдлын	Үзлэг, зөвлөгөө өгөх өрөөнүүдэд угаалтуур хязгаарлагдмал мөн усгүй. Ажилтнууд болон/эсвэл өвчтөнд зориулсан бие засах газар төв байгууламжийн гадаа байдаг бөгөөд хэрэглэхэд маш муу нөхцөлтэй байсан.	5 оноо

		сав бэлэн, зөв шошготой - устгах ажлыг гэрээт байгууллага гүйцэтгэдэг. Барилгын бүх шал цэвэрхэн. Халдвараас урьдчилан сэргийлэх, хянах ажлыг нэг эмнэлгийн ажилтан хариуцаж, халдварт өвчний бүх тохиолдлыг Үндэсний мэдээллийн санд бүртгэж, сар бүр нэгтгэн гаргадаг. Халдвартай байж болзошгүй өвчтөнүүдийг тусгаарлах газартай.	Хурц үзүүртэй зүйл хаях зориулалттай савнууд байдаг ч тэдгээр нь картон байдаг тул хэрэглэгчдийг болзошгүй гэмтэл бэртлээс зохих ёсоор хамгаалж чаддаггүй. Ариутгалын процедур байдаггүй (тоног төхөөрөмж байгаа боловч байгууламж дотор ашиглах зай байхгүй).	
7	Дорноговь аймаг “Мишээлт мана” ӨЭМТ	Байгууламж ерөнхийдөө өндөр түвшинд байгуулагдсан. Үзлэгийн бүх өрөөнд ус, угаагуур, нэг удаагийн алчуур зэрэг байна. Спиртийн агууламжтай гар ариутгагч байна. Ажилтнууд болон өвчтөнд зориулсан бие засах газар байна. Хувийн хамгаалах хэрэгсэл бэлэн, зохих ёсоор өмсдөг. Эмнэлгийн хог хаягдлын сав бэлэн, зөв шошготой - устгах ажлыг гэрээт байгууллага гүйцэтгэдэг. Барилгын бүх шал цэвэрхэн. Халдвараас урьдчилан сэргийлэх, хянах ажлыг нэг эмнэлгийн ажилтан хариуцаж, халдварт өвчний бүх тохиолдлыг Үндэсний мэдээллийн санд бүртгэж, сар бүр нэгтгэн гаргадаг. Халдвартай байж болзошгүй өвчтөнүүдийг тусгаарлах газартай.	Хурц үзүүртэй зүйл хаях зориулалттай савнууд байдаг ч тэдгээр нь картон хайрцаг байдаг тул хэрэглэгчдийг болзошгүй гэмтэл бэртлээс зохих ёсоор хамгаалж чаддаггүй. Ариутгалын процедур байдаггүй.	8 оноо
8	Хөвсгөл аймгийн Тариалан СЭМТ	Байгууламж ерөнхийдөө хуучивтар боловч, эрүүл ахуйн шаардлага хангаж байна. Үзлэгийн бүх өрөөнд ус, угаагуур,	Хурц үзүүртэй зүйл хаях зориулалттай савнууд байдаг ч тэдгээр нь картон байдаг тул хэрэглэгчдийг	9 оноо

		<p>нэг удаагийн алчуур зэрэг байна. Спиртийн агууламжтай гар ариутгагч байна. Ажилтнууд болон/эсвэл өвчтөнд зориулсан бие засах газар байна. Хувийн хамгаалах хэрэгсэл бэлэн, зохих ёсоор өмсдөг. Эмнэлгийн хог хаягдлын сав бэлэн, зөв шошготой - устгах ажлыг гэрээт компани гүйцэтгэдэг. Барилгын бүх шал цэвэрхэн. Ариутгалын процедурыг үр дүнтэй гүйцэтгэдэг. Халдвартай байж болзошгүй өвчтөнүүдийг тусгаарлах газартай.</p>	<p>болзошгүй гэмтэл бэртлээс зохих ёсоор хамгаалж чаддаггүй.</p>	
9	<p>Нийслэлийн Баянзүрх дүүргийн 17 дугаар хорооны “Орхон түшээ мөрөн” ӨЭМТ</p>	<p>Барилга, байгууламж ерөнхийдөө цэвэрхэн. Зөвхөн 2 үзлэгийн өрөөнд ус, угаагуур, нэг удаагийн алчуур зэрэг байна. Спиртийн агууламжтай гар ариутгагч байна. Ажилтнууд болон өвчтөнд зориулсан бие засах газар байна. Хувийн хамгаалах хэрэгсэл бэлэн, зохих ёсоор өмсдөг. Эмнэлгийн хог хаягдлын сав бэлэн, зөв шошготой - устгах ажлыг гэрээт компани гүйцэтгэдэг. Барилгын бүх шал цэвэрхэн. Ариутгалын процедурыг үр дүнтэй гүйцэтгэдэг. Халдвартай байж болзошгүй өвчтөнүүдийг тусгаарлах газартай.</p>	<p>Хурц үзүүртэй зүйл хаях зориулалттай савнууд байдаг ч тэдгээр нь картон хайрцаг байдаг тул хэрэглэгчдийг болзошгүй гэмтэл бэртлээс зохих ёсоор хамгаалж чаддаггүй.</p>	9 оноо
10	<p>Булган аймгийн Дашинчилэн СЭМТ</p>	<p>Байгууламж ерөнхийдөө хуучивтар боловч, эрүүл ахуйн шаардлага хангаж байна. Үзлэгийн бүх өрөөнд ус, угаагуур, нэг удаагийн алчуур зэрэг байна. Спиртийн агууламжтай гар</p>	<p>Ажилтнууд болон өвчтөнд зориулсан бие засах газар барилгын гадна байдаг. Хурц үзүүртэй зүйл хаях зориулалттай савнууд байдаг ч тэдгээр нь картон</p>	6 оноо

		ариутгагч байна. Хувийн хамгаалах хэрэгсэл бэлэн, зохих ёсоор өмсдөг. Эмнэлгийн хог хаягдлын сав бэлэн, зөв шошготой - устгах ажлыг гэрээт компани гүйцэтгэдэг. Барилгын бүх шал цэвэрхэн. Ариутгалын процедурыг үр дүнтэй гүйцэтгэдэг- долоо хоног бүр гүн цэвэрлэж, хоёр цаг тутамд бүх газарт ариутгалын бодисоор цацна. Халдвартай байж болзошгүй өвчтөнүүдийг тусгаарлах газартай.	хайрцаг байдаг тул хэрэглэгчдийг болзошгүй гэмтэл бэртлээс зохих ёсоор хамгаалж чаддаггүй.	
11	Дорноговь аймгийн Эрдэнэ СЭМТ,	Байгууламж ерөнхийдөө хуучивтар боловч, эрүүл ахуйн шаардлага хангаж байна. Спиртийн агууламжтай гар ариутгагч байна. Ажилтнууд болон өвчтөнд зориулсан бие засах газар байдаг. Хувийн хамгаалах хэрэгсэл бэлэн, зохих ёсоор өмсдөг. Хурц үзүүртэй зүйл хаях зориулалттай картон хайрцаг савтай. Эмнэлгийн хог хаягдлын сав бэлэн, зөв шошготой. Барилгын бүх шал цэвэрхэн. Ариутгалын процедурыг үр дүнтэй гүйцэтгэдэг. Халдварт өвчний тохиолдлыг бүртгэж, шаардлагатай тохиолдолд мэдээлдэг. Халдвартай байж болзошгүй өвчтөнүүдийг тусгаарлах газартай.	Үзлэг, зөвлөгөөний өрөөнд ус, угаагуур зэрэг байхгүй.	7 оноо
12	Булган аймгийн Орхон СЭМТ	Спиртийн агууламжтай гар ариутгагч байна. Хувийн хамгаалах хэрэгсэл бэлэн, зохих ёсоор өмсдөг. Эмнэлгийн хог	Байгууламж ерөнхийдөө дунд түвшинд байгуулагдсан. Үзлэгийн өрөөнд ус, угаагуур зэрэг	2 оноо

		хаягдлын сав бэлэн, зөв шошготой. Барилгын бүх шал цэвэрхэн. Ариутгалын процедурыг үр дүнтэй гүйцэтгэдэг. Халдварт өвчний тохиолдлыг бүртгэж, шаардлагатай тохиолдолд мэдээлдэг. Халдвартай байж болзошгүй өвчтөнүүдийг тусгаарлах газартай.	байхгүй. Ажилтнууд болон өвчтөнд зориулсан бие засах газар байгууламжийн гадаа байдаг.	
13	Хөвсгөл аймаг, “Далай Элбэрэлт” ӨЭМТ	Байгууламж ерөнхийдөө хуучивтар боловч, эрүүл ахуйн шаардлага хангаж байна. Үзлэгийн бүх өрөөнд ус, угаагуур, нэг удаагийн алчуур зэрэг байна. Спиртийн агууламжтай гар ариутгагч байна. Хувийн хамгаалах хэрэгсэл бэлэн, зохих ёсоор өмсдөг. Эмнэлгийн хог хаягдлын сав бэлэн, зөв шошготой - устгах ажлыг гэрээт байгууллага гүйцэтгэдэг. Барилгын бүх шал цэвэрхэн. Халдвараас урьдчилан сэргийлэх, хянах ажлыг нэг эмнэлгийн ажилтан хариуцаж, халдварт өвчний бүх тохиолдлыг Үндэсний мэдээллийн санд бүртгэж, сар бүр нэгтгэн гаргадаг. Халдвартай байж болзошгүй өвчтөнүүдийг тусгаарлах газартай.	Ажилтнуудын болон үйлчлүүлэгчид зориулсан бие засах газар гол байгууламжийн гадаа байдаг. Хурц үзүүртэй зүйл хаях зориулалттай савнууд байдаг ч тэдгээр нь картон байдаг тул хэрэглэгчдийг болзошгүй гэмтэл бэртлээс зохих ёсоор хамгаалж чаддаггүй. Ариутгалын процедурыг байдаггүй.	3 оноо
14	Нийслэлийн Хан-Уул дүүрэг 10-р хороо, “Амин тус” ӨЭМТ	Бүтцийн хязгаарлалттай хэдий ч ерөнхийдөө байгууламж цэвэрхэн байна. Зарим үзлэгийн өрөөнд ус, угаалтаар, нэг удаагийн алчуур зэрэг байна. Спиртийн агууламжтай гар ариутгагч байна. Хувийн	Ажилтнууд болон өвчтөнд зориулсан бие засах газар байхгүй. Хурц үзүүртэй зүйл хаях зориулалттай савнууд байдаг ч тэдгээр нь картон байдаг тул хэрэглэгчдийг болзошгүй гэмтэл бэртлээс	4 оноо

		хамгаалах хэрэгсэл байдаг бөгөөд зохих ёсоор өмсдөг. Эмнэлгийн хог хаягдлын сав бэлэн, зөв шошготой - устгах ажлыг гэрээт компани гүйцэтгэдэг. Барилгын бүх шал цэвэрхэн. Ариутгалын процедурыг үр дүнтэй гүйцэтгэдэг. Халдвартай байж болзошгүй өвчтөнүүдийг тусгаарлах газартай.	зохих ёсоор хамгаалж чаддаггүй.	
15	Хөвсгөл аймгийн Хатгал СЭМТ	Байгууламжийн байр байдал ерөнхийдөө маш хязгаарлагдмал хэдий ч ажилчид өөрсдийн чадамжаараа тусламж, үйлчилгээг стандартын дагуу хүргэж ажиллаж байна. Спиртийн агууламжтай гар ариутгагч байна. Хувийн хамгаалах хэрэгсэл бэлэн, зохих ёсоор өмсдөг. Эмнэлгийн хог хаягдлын сав бэлэн, зөв шошготой - устгах ажлыг гэрээт байгууллага гүйцэтгэдэг. Халдвараас урьдчилан сэргийлэх, хянах ажлыг нэг эмнэлгийн ажилтан хариуцаж, халдварт өвчний бүх тохиолдлыг Үндэсний мэдээллийн санд бүртгэж, сар бүр нэгтгэн гаргадаг. Халдвартай байж болзошгүй өвчтөнүүдийг тусгаарлах газартай.	Үзлэг, зөвлөгөө өгөх өрөөнүүдэд угаагуур хязгаарлагдмал мөн усгүй. Өрөөнүүд хүйтэн тул цэвэрлэгээ хийхэд хүндрэл учирдаг. Ажилтнууд болон өвчтөнд зориулсан бие засах газар төв байгууламжийн гадаа байдаг бөгөөд хэрэглэхэд маш муу нөхцөлтэй байна. Хурц үзүүртэй зүйл хаях зориулалттай савнууд байдаг ч тэдгээр нь картон байдаг тул хэрэглэгчдийг болзошгүй гэмтэл бэртлээс зохих ёсоор хамгаалж чаддаггүй. Жуулчид хог хаягдлаа замбараагүй хаяхтай холбоотой зарим асуудал гардаг. Ариутгалын процедур байдаггүй (тоног төхөөрөмж байгаа боловч байгууламж дотор ашиглах зай байхгүй).	1 оноо

График 32. Халдвартай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үнэлгээ

Дэлхийн банкны Эрүүл мэндийн байгууллагуудын үнэлгээний аргачлалын дагуу сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн хэсэг, нэгжийн үйл ажиллагаатай биечлэн танилцаж, "Халдвартай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа"-г 10 оноогоор үнэлэхэд дээрх графикт харуулсан байдлаар ӨЭМТ, СЭМТ тус бүр үнэлэгдсэн байна.

Үзлэг, зөвлөгөө өгөх өрөөнүүдэд угаагуур хязгаарлагдмал мөн усгүй. Өрөөнүүд хүйтэн тул цэвэрлэгээ хийхэд хүндрэл учирдаг. Ажилтнууд болон өвчтөнд зориулсан бие засах газар төв байгууламжийн гадаа байдаг бөгөөд хэрэглэхэд маш муу нөхцөлтэй байна. Хурц үзүүртэй зүйл хаях зориулалттай савнууд байдаг ч тэдгээр нь картон байдаг тул хэрэглэгчдийг болзошгүй гэмтэл бэртлээс зохих ёсоор хамгаалж чаддаггүй. Үйлчлүүлэгчид хог хаягдлаа замбараагүй хаяхтай холбоотой зарим асуудал гардаг. Ариутгалын процедур байдаггүй (тоног төхөөрөмж байгаа боловч байгууламж дотор ашиглах зай байхгүй) зэрэг нийтлэг сул талууд ажиглагдлаа.

4.4.3 Эмийн хангалт, зохион байгуулалтын үнэлгээ

Хүснэгт 6. СЭМТ, ӨЭМТ-ийн Эмийн хангалт, зохион байгуулалтын үнэлгээ

№	Эрүүл мэндийн төвийн нэр	Давуу тал	Сул тал	Үнэлгээний оноо
1	Нийслэлийн Баянзүрх дүүргийн 17 дугаар хорооны “Орхон түшээ мөрөн” ӨЭМТ	Эмийг хадгалах хугацаан дотор хэрэглэж, дуусахаас өмнө дахин нөөцөлдөг. Эмийн бүртгэл хөтөлдөг.	Өвчтөний хэрэгцээг хангахад шаардлагатай эм эмнэлгийн хэрэгсэл хүрэлцээтэй ч хааяа нөөцгүй болох тохиолдол байдаг. Эмийг цоожтой шүүгээнд тусдаа хадгалдаггүй. Яаралтай тусламжийн тоног төхөөрөмж, хэрэгсэл, эмийн хүртээмж муу. Яаралтай тусламжийн тэргэнцэр байдаг ч яаралтай тусламжийн эм тариа ховор. Тэргэнцэр дээрээ яаралтай тусламжийн тоног төхөөрөмж байрлуулсан. Тоног төхөөрөмжийг зохих ёсоор хадгалах, шалгах системгүй.	3 оноо

Нийслэлийн Баянзүрх дүүргийн 17 дугаар хорооны “Орхон түшээ мөрөн” ӨЭМТ-өөс бусад бүх ӨЭМТ, СЭМТ-үүд “Өвчтөний хэрэгцээг хангахад шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл хүрэлцээтэй. Эмийг хадгалах хугацаан дотор хэрэглэж дуусахаас өмнө дахин нөөцөлдөг. Эмийг цоожтой шүүгээнд тусдаа хадгалж, тогтмол хянаж байдаг. Эмийн бүртгэл хөтөлдөг. Яаралтай тусламжийн тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгсэл хүртээмжтэй. Тоног төхөөрөмжийг зохих ёсоор хадгалах, шалгах системтэй.” гэж үнэлэгдэн тус бүрд нь 9 оноогоор үнэлсэн.

4.4.4 Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын үнэлгээ

Хүснэгт 7. СЭМТ, ӨЭМТ-ийн Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын үнэлгээ

№	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын үнэлгээний үзүүлэлтүүд	Хөвсгөл аймгийн Хатгал СЭМТ																Бүгд	Хувь
		Хөвсгөл аймгийн Хатгал СЭМТ	Булган аймгийн Орхон СЭМТ	Хөвсгөл аймаг, "Далай Элбэрэлт" ӨЭМТ	Хан-Уул дүүрэг 10-р хороо, "Амин тус" ӨЭМТ	Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ СЭМТ	Булган аймгийн Дашинчилэн СЭМТ	Дорноговь аймгийн Эрдэнэ СЭМТ,	Дорноговь аймаг "Мишээлт маня" ӨЭМТ	Булган аймгийн Хутаг-Өндөр СЭМТ	СБД-ийн 17 дугаар хорооны "Увидаст-Од" ӨЭМТ	Хөвсгөл аймгийн Тариалан СЭМТ	Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл СЭМТ	БЗД-ийн 17-р хорооны "Орхон түшээ мөрөн" ӨЭМТ	Булган аймгийн Баяннуур СЭМТ	Хөвсгөл аймгийн Их-Уул СЭМТ			
1	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын баг байгуулсан	1	1	1	0	1	1	1	1	1	1	1	1	0	1	1	13	86.7	
2	Улирал тутамд хуралдаж шийдвэр гаргадаг	1	0	0	0	1	1	1	0	0	1	1	0	0	1	1	8	53.3	
3	Багийн гишүүд сургалтанд хамрагдсан	0	0	0	0	0	1	0	0	0	0	1	0	0	1	1	4	26.7	
4	ХШҮ, арга зүйн дэмжлэг үзүүлдэг	0	0	0	0	0	1	0	0	1	1	1	0	0	1	1	6	40.0	
5	Ажилтнуудад чанарын сургалт зохион байгуулдаг	0	0	0	0	0	1	0	0	1	0	1	0	0	0	1	4	26.7	
6	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын төлөвлөгөөтэй	1	1	1	0	1	1	1	1	1	1	1	1	0	1	1	13	86.7	
7	Төлөвлөгөөний биелэлтийн хувь	60	65	50	0	50	80	90	80	85	80	70	75	0	80	90		63.7	
8	ЭМ-ийн ТҮ-ний стандарт, эмнэлзүйн удирдамж зааврыг мөрдүүлж, хэрэгжилтэд хяналт тавьдаг	1	1	1	0	1	1	1	1	1	1	1	1	0	1	1	13	86.7	
9	Үйлчлүүлэгчдээс сэтгэл ханамжийн судалгаа авдаг	1	1	1	0	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	14	93.3	
10	Үйлчлүүлэгч, ажилчдын аюулгүй байдлыг хангах, эрсдлээс хамгаалах орчныг бүрдүүлэх санал гаргаж шийдвэрлүүлсэн	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	1	0	1	6.7	
11	Тусламж, үйлчилгээний чанар, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын талаар зохион байгуулсан арга хэмжээ, сайн туршлага	0	0	0	0	0	1	1	0	1	0	1	0	0	0	1	5	33.3	
12	Иргэдийн санал гомдлыг шийдвэрлэдэг	0	0	0	0	0	1	0	0	1	1	1	0	0	0	1	5	33.3	
13	Чанарын шалгуур үзүүлэлтэнд дүгнэлт хийдэг	0	0	0	0	0	1	0	0	1	0	1	0	0	0	1	4	26.7	
14	Сөрөг тохиолдлуудыг үр дүнтэй удирдаж, мэдээлдэг	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	15	100.0	
15	Ажилтнууд шинжилгээ, эмчилгээ хийхээс өмнө өвчтөний шинж тэмдгийг оношлох зөв процедурыг хийдэг	1	0	1	0	1	0	0	1	0	0	0	0	0	0	1	5	33.3	
16	Эмнэлгийн орчинд үйлчлүүлэгч унахаас сэргийлдэг	0	0	0	0	0	0	0	0	0	1	0	0	0	1	0	2	13.3	
17	Эрсдлийн үнэлгээ хийдэг	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0.0	

Дээрх хүснэгтээс харахад ӨЭМТ, СЭМТ-д “Эрсдлийн үнэлгээ” огт хийдэггүй байна.

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын багийн төвийн даргын тушаалаар 86,7 хувь байгуулжээ. Төвийн ажилтнуудад чанарын сургалт 26,7 хувь хийжээ.

Үйлчлүүлэгч, ажилчдын аюулгүй байдлыг хангах, эрсдлээс хамгаалах орчныг бүрдүүлэх санал гаргаж 6,7 хувь нь шийдвэрлүүлсэн байна.

Эмнэлгийн орчинд үйлчлүүлэгч унахаас сэргийлж хананд зориулалтын урт бариулыг зөвхөн Булган аймгийн Баяннуур СЭМТ, СБД-ийн 17 дугаар хорооны “Увидаст-Од” ӨЭМТ-д тус тус хийсэн байна.

Түргэвчилсэн үнэлгээ хийсэн ӨЭМТ, СЭМТ-ийн Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын төлөвлөгөөний биелэлт дундажаар 63,7 хувь байна.

4.5 ЭМАШТҮ-ний байгууллагын мэдээллийн технологийн өнөөгийн байдал

4.5.1 Интернет ба мэдээллийн сүлжээ

Монгол Улсын хэмжээнд орон нутгийн буюу сумын төвийн харилцаа холбоог шугамын шилэн кабелиар холбох ажил 95 хувьтай явагдсан байна. Эмнэлгийн барилга хүртэлх холболтыг WiFi болон шилэн кабель утас ашиглан шийдэж байна. Сумын эрүүл мэндийн төвийн хувьд интернэтийн холболтын хурд өнөөгийн шаардлагагыг бүрэн хангаж байна. Интернэтийн төлбөр өөр өөр байгаа нь байршил болон орон нутгийн нөхцөлөөс хамаарч байна.

Анхан шатны эрүүл мэндийн төвүүдийн интернэтийн сүлжээг WiFi хэлбэрийн холболтоор авч байгаа тохиолдолд програм хангамж гацах нөхцлийг бий болгож байна. Сүлжээний ачаалал болон үүрэн холбооны сүлжээний ачааллын нөлөө нь эмнэлгийн програмд ачаалал үүсгэж удаашруулах, холбогдохгүй байх гэх мэт алдаанууд гарч байна.

Монголын цахилгаан холбоо компани нь интенэтийн холболтыг эрүүл мэндийн төв рүү татах техникийн нөхцөлийг бүрдүүлж шилэн кабелиар холбох боломжтой болгосон. Шилэн кабель ашиглан сумын эрүүл мэндийн төвийн интернэтийг холбож, Эрүүл мэндийн програм хангамж өндөр хурдаар өгөгдлөө дамжуулах боломжтой болно.

Хүснэгт 8. ӨЭМТ, СЭМТ-үүдийн интeнeтийн холболт, хурд, төлбөрийн хэмжээ

Интернет	Булган аймгийн Баяннуур СЭМТ	Булган аймгийн Дашинчилэн СЭМТ	Булган аймгийн Хулаг-Өндөр СЭМТ	Булган аймгийн Орхон СЭМТ	БЗД 17-р хороо ӨЭМТ	Булган аймгийн Хулаг-Өндөр СЭМТ	Дорноговь аймгийн Эрдэнэ СЭМТ	Хөвсгөл аймгийн Хатгал сум	Хөвсгөл аймгийн Их-Уул СЭМТ	Хөвсгөл аймгийн Тариалан СЭМТ	ХУД-ийн 10-р хороо ӨЭМТ
Төрөл	Шилэн	Шилэн	Шилэн	Шилэн	WiFi	WiFi	WiFi	WiFi	WiFi	Cable	Wifi
Интeнeтийн Хурд	10м	10м	10м	10м	3м	5м	4м	5,3м	4м	4м	2м
Сарын зардал /мянган төгрөг/	231	85	108	103	100	85	88	220	220	220	104
Үйл ажиллагаа	+	+	+	+	-	+	-	-	-	+	+

4.5.2 Мэдээллийн технологийн тоног төхөөрөмжийн хангамж, хэрэгцээ

Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын эмч, эмнэлгийн ажилтан тус бүрт компьютер, мэдээллийн технологийн хүрэлцэхгүй байна. Сүүлийн 3 жилийн дотор хангагдсан одоо ашиглагдаж буй компьютер нь эрүүл мэндийн мэдээ, мэдээллийг боловсруулахад хангалттай боловч, түүнээс өмнөх үеийн компьютерийн үзүүлэлт нь өнөөгийн програм хангамжийн шаардлагыг хангахгүй, олон жил ашиглагдсан зэргээс шалтгаалан шинэчлэх шаардлагатай. Хэдий анхан шатны байгууллагын санхүүжилтийн сайжруулах арга хэмжээг авч байгаа ч тоног төхөөрөмжийг сайжруулах төсөв хангалттай хүрэлцэхгүй байна.

Иймд мэдээллийн технологийг сайжруулах, шинэ дэвшилтэт мэдээллийн технологиудыг нэвтрүүлэх шаардлага байна. Зайн эмнэлзүйн чиглэлээр тоног төхөөрөмж, технологийн нэвтрүүлэх нь зүйтэй. Мобайл технологийг нэвтрүүлвэл үйл ажиллагаа болон хяналтыг сайжруулахад түлхэц болно.

Хүснэгт 9. ӨЭМТ, СЭМТ-үүдийн мэдээллийн технологийн тоног төхөөрөмж, хэрэгцээ

Мэдээллийн технологийн тоног төхөөрөмж	Булган аймгийн Баяннуур СЭМТ	Булган аймгийн Дашинчилэн СЭМТ	Булган аймгийн Хутаг-Өндөр СЭМТ	Булган аймгийн Орхон СЭМТ	БЗД 17-р хороо ӨЭМТ	Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл СЭМТ	Дорноговь аймгийн Эрдэнэ СЭМТ	Хөвсгөл аймгийн Хатгал сум	Хөвсгөл аймгийн Их-Уул СЭМТ	Хөвсгөл аймгийн Тариалан СЭМТ	ХУД-ийн 10-р хороо ӨЭМТ
Одоо ашиглаж байгаа											
Ширээний компьютер	5	5	4	3	6	5	3	7	4	8	14
Зөөврийн компьютер	2	5	9	6	2	2	8	5	6	4	2
Хэвлэх төхөөрөмж	4	3	5	6	4	3	6	4	5	10	6
Шинээр шаардлагатай байгаа											
Ширээний компьютер	3	2	2	2	6	5	3	2	2	10	3
Зөөврийн компьютер	3	8	2	3	2	2	5	3	3	5	3
Хэвлэх төхөөрөмж	2	2	2	2	2	2	3	5	1	5	4

Хүснэгт 10.. ЭМАШТҮ-ний байгууллагуудын мэдээллийн технологийн тоног төхөөрөмжийн хангалт, аймгаар

№	Аймгийн нэр	<= 2017	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он	Дүн
1	Архангай	65	10	19	17	80	13	204
2	Баян-Өлгий	62	18	16	7	0	51	154
3	Баянхонгор	54	64	70	73	102	108	471
4	Булган	20	1	1	5	56	4	87
5	Говь-Алтай	16	6	4	8	64	0	98
6	Говьсүмбэр	20	21	24	20	29	30	144
7	Дархан-Уул	54	63	79	103	104	114	517
8	Дорноговь	34	13	9	15	31	7	109
9	Дорнод	33	5	8	6	22	60	134
10	Дундговь	34	25	42	41	85	22	249
11	Завхан	64	5	13	13	57	53	205
12	Орхон	60	5	3	14	33	4	119

13	Өвөрхангай	33	3	13	7	72	2	130
14	Өмнөговь	12	7	10	16	17	28	90
15	Сүхбаатар	19	0	1	0	38	3	61
16	Сэлэнгэ	45	3	15	3	59	1	126
17	Төв	74	27	39	24	89	7	260
18	Увс	34	14	100	23	76	24	271
19	Ховд	46	6	9	7	26	54	148
20	Хөвсгөл	41	30	130	56	84	137	478
21	Хэнтий	15	5	11	6	73	2	112
22	Улаанбаатар хот	441	106	182	218	163	101	1211
	НИЙТ	1276	437	798	682	1360	825	

4.5.3 Програм хангамж

Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудад мэдээллийн олон тооны програм хангамж ашиглаж байна. Эдгээр програм хангамжид гацалт, саатал, мэдээлэл боловсруулалт дутуу гэх мэт дутагдал байна. ӨЭМТ, СЭМТ-үүдэд хэрэглэгдэж програмууд үйл ажиллагааг бүрэн дэмжиж чадахгүй байна. ӨЭМТ, СЭМТ-үүдээс Хөтөч програм, утасны дуудлага зохицуулах програм, архив, албан бичиг хөтөлтийн програм хэрэгцээтэй байна гэсэн саналууд гаргасан байна. Ихэнх нь эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудад зориулсан нэг цонхоор мэдээлэл оруулдаг цогц програм хангамж шаардлагатай байна гэсэн санал гаргажээ.

Програм хангамж нь мэдээллийн технологийн хөгжлийн хурдацийг гүйцэтгэхгүй байгаагаас төрөл бүрийн програм хангамжууд гарч ирж байна. Мөн мэдээллийг боловсруулах хэрэгцээг өнөөгийн програм хангамж хангахгүй байгаагаас програм хангамжууд янз бүрээр хийгдэж байна.

Хүснэгт 11.. ЭМАШТҮ-ний байгууллагуудын програм хангамжийн хэрэглээ

Програм хангамжийн нэрс	Булган аймгийн Баяннуур СЭМТ	Булган аймгийн Дашинчилэн СЭМТ	Булган аймгийн Хутаг-Өндөр СЭМТ	Булган аймгийн Орхон СЭМТ	БЗД 17-р хороо ӨЭМТ	Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл СЭМТ	Дорноговь аймгийн Эрдэнэ СЭМТ	Хөвсгөл аймгийн Хатгал сум	Хөвсгөл аймгийн Их-Уул СЭМТ	Хөвсгөл аймгийн Тариалан СЭМТ	ХУД-ийн 10-р хороо ӨЭМТ
H-Info v3 статистик мэдээллийн програм хангамж	+	+	+	+	+	+	+	+	+	+	+
Hinfo-Stata жилийн эцсийн үйл ажиллагааны тайлангийн програм хангамж	+	+	+	+	-	+	+	+	+	+	-
E-hospital Дэлхийн банкны ЦЭМТ-өөр шинээр нэвтэрч байгаа	+	+	+	+	-	+	+	-	+	+	+
Health.gov.mn Жор, вакцин, тусламж үйлчилгээнд	+	+	+	+	-	+	+	-	+	-	+
Hr.hdc.gov.mn Хүний нөөцийн програм хангамж	+	+	+	-	-	-	+	-	+	+	-
screening					+						+
Mobile Health						+					
Тандалт – гэрэгэ систем						+					+
flu.mn Томуу харуулдан тандалтын нэгж					+						+

4.6 ЭМАШТҮ-ний санхүүжилтын өнөөгийн байдал**4.6.1 Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн шинэчлэл**

УИХ-ын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаар “Эрүүл мэндийн тухай”, “Эрүүл мэндийн даатгалын тухай” хуулиудад нэмэлт өөрчлөлт орж, төр төлбөрийг нь хариуцах тусламж, үйлчилгээнүүд болох Эрүүл мэндийн тухай хуулийн 24.6.1, 24.6.2, 24.6.5-24.6.8, 24.6.10, 35^{1.3}-т заасан дараах тусламж, үйлчилгээнүүдийг эрүүл мэндийн даатгалын сангаар дамжуулан худалдан авах замаар Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь “Нэг худалдан авагч” болох эрх зүйн орчин бүрдсэн. Энэхүү эрүүл мэндийн суурь хуулийн нэмэлт өөрчлөлтийн хүрээнд улсын төсөв, ЭМД-ын сангуудыг нэгтгэж ЭМД-ын санд төвлөрүүлэх, тусламж, үйлчилгээний чанартай уялдсан стратегийн худалдан авалтын тогтолцоог

бүрдүүлэх, лавлагаат шатлалын тусламж үйлчилгээг ОХБ-ээр тохиолдолд суурилсан төлбөрийн аргаар санхүүжүүлэх, цахим дээр суурилсан гүйцэтгэлийн хяналтын тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр томоохон шинэчлэл хийгдэж байна. Энэхүү шинэчлэлийн хүрээнд гол үйл ажиллагаа явуулах байгууллага нь ЭМДЕГ болж ЭМДҮЗ-өөр дээрх бодлогуудыг шингээсэн 3 тогтоол батлуулан хэрэгжүүлж байна. Үүнд: ЭМДҮЗ-ийн 03, 04, 13-р тогтоолууд гарсан бол тусламж, үйлчилгээний чанар, үр дүнг хянах 05-р тогтоолыг гаргасан. ЭМДҮЗ-ийн 2021 оны 03-р тогтоол шинэчлэгдэж 2022 оны 1-р тогтоол болон батлагдсан. Энэхүү хууль, эрх зүйн орчны хүрээнд Монгол улсын эрүүл мэндийн салбар нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжих бодлогын чанартай арга хэмжээг хэрэгжүүлж эхлээд байна.

Стратегийн худалдан авалт нь тусламж үйлчилгээний гүйцэтгэл, эдийн засгийн шинжилгээ, нотолгоонд суурилан санхүүгийн эх үүсвэрийг оновчтой хуваарилах нөхцөлийг бүрдүүлдэг. Монгол улс дахь стратегийн худалдан авалтын тогтолцоог дараахь хүснэгтэд харуулав

Хүснэгт 12 Стратегийн худалдан авалтын тогтолцоо


	Ямар тусламж, үйлчилгээ?	Хэнээс?	Ямар үнээр?	Ямар аргаар?
Анхан шатлалын тусламж, үйлчилгээ	<ul style="list-style-type: none"> Жирэмсний хяналт Дархлаажуулалт Халдварт өвчний хяналт.... 	<ul style="list-style-type: none"> ӨЭМТ СТЭМТ 	<ul style="list-style-type: none"> 17-53.3 мянган төгрөг 35-260 мянган төгрөг 	Нэг иргэнээр тооцсон – 10 эрсдэлийн бүлэг Тохиолдолд суурилсан – 3 бүлэг
Өрх, СТЭМТ-өөс үзүүлэх ЭМД хариуцах тусламж, үйлчилгээ	<ul style="list-style-type: none"> Оношилгоо, шинжилгээ Сэргээн засах Гэрийн ТҮ Өдрийн эмчилгээ 	<ul style="list-style-type: none"> ӨЭМТ СТЭМТ 	<ul style="list-style-type: none"> 20-80 мянган төгрөг 	Тохиолдолд суурилсан (Тохиолдолд суурилсан 4 бүлэг)
Лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээ	<ul style="list-style-type: none"> Хорт хавдар Эх барих Гэмтэл КОВИД-19 гэх мэт 	<ul style="list-style-type: none"> Лавлагаа шатлалын улсын эмнэлэг Хувийн эмнэлэг 	<ul style="list-style-type: none"> 14 мянган төгрөг – 113 сая төгрөг 	Тохиолдолд суурилсан (Оношийн хамааралтай 563 бүлэг)
Хөнгөлөлт-тэй эм	<ul style="list-style-type: none"> Амлодифин Метформин Терафлу??? 	<ul style="list-style-type: none"> Гэрээт эмийн сан 	<ul style="list-style-type: none"> 40 төгрөг – 99 мянган төгрөг 	Тохиолдолд суурилсан (541 нэр төрлийн бүлэг)
Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн багц	<ul style="list-style-type: none"> Зүрх судасны өвчний багц Хорт хавдрын багц 	<ul style="list-style-type: none"> Оношилгооны төв Төрийн өмчит эмнэлэг Лаборатори 	<ul style="list-style-type: none"> 50 мянган төгрөг 	Тохиолдолд суурилсан (Нас, хүйс, эрсдэл бүрээр тогтсон 4 бүлэг)

4.6.2 ЭМАШТУ-ны санхүүжилт, төлбөрийн арга

4.6.2.1 ЭМАШТУ-ний санхүүжилтийн өнөөгийн байдал

Эрүүл мэндийн зардал оны үнээр 2010 онд 250,3 тэрбум төгрөг байсан бол 2020 онд 986,9 тэрбум төгрөг болж өссөн. Гэвч ДНБ-нд эзлэх улсын эрүүл мэндийн салбарын зардал өнгөрсөн 15 жилийн хугацаанд 2.2-2.8 хувь эзэлж байна.

График 33. ДНБ-нд эзлэх улсын эрүүл мэндийн зардал



Эх үүсвэр: Эрүүл мэндийн үзүүлэлт 2020


Эрүүл мэндийн нийт зардлын 26 орчим хувийг эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээнд зарцуулж байна. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвүүд нь эмнэлгийн тусламж, үйлчилгээний 49 орчим хувийг үзүүлж, 3.2 сая хүн амд үйлчилж байна.

Бүх нийтийн эрүүл мэндийн хамралтанд хүрэх зорилтын хүрээнд анхан шатны тусламж үйлчилгээнд зарцуулах санхүүжилтийг нэмэгдүүлэх, хүртээмж, чанар, үр ашгийг сайжруулах асуудал нэн чухал болж байна. Түүнчлэн лавлагаат шатлал болон анхан шатны тусламж үйлчилгээний интеграцчилалыг сайжруулах шаардлагатай болж байна. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагууд өвчтөн илгээх хуудсаар 194 мянган хүн¹ шилжүүлсэн байна.

¹ ЭМЯ-ны судалгаагаар

Зураг 34 Тусламж, үйлчилгээний зардал, шатлалаар

Сум, тосгоны эрүүл мэндийн төв дунджаар 2 000-6 000 хүнд үйлчилж, 400-600 сая төгрөг зарцуулж байна. ӨЭМТ 5 000-20 000 хүнд үйлчилж 200-500 сая төгрөг зарцуулж байна. Доорхи зургаас харахад ӨЭМТ-н санхүүжилт нь илүү хүн амын тоотой уялдаж байна. Харин СТЭМ-н төсөвт хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ 60 орчим хувийг эзэлж байгаа учир хүн амын тоотой бага хамааралтай байна.

Зураг 35 Өрх, сум тосгоны эрүүл мэндий төвийн санхүүжилт хүн ам

Эх үүсвэр: ЭМДЕГ

Эрүүл мэндийн даатгалын сангаас 2021 онд 444.3 мянган тохиолдолд 15.1 тэрбум төгрөг зарцуулсан байна. Оношилгоо, шинжилгээний тусламж үйлчилгээ хамгийн өндөр буюу нийт тохиолдлын 58.1 хувийг, нийт санхүүжилтийн 17.8 хувийг тус тус эзэлж байна. Гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ нийт тохиолдлын хамгийн бага

буюу 13.7 хувийг эзэлж, нийт санхүүжилтийн 37.4 хувь буюу 5,6 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна

Хүснэгт 13 Эрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэл, 2018-2021 он

Тусламж, үйлчилгээний төрөл	2018 он		2019 он		2020 он		2021 он	
	Хүний тоо	Мөнгөн дүн /сая.төг/	Хүний тоо	Мөнгөн дүн /сая.төг/	Хүний тоо	Мөнгөн дүн /сая.төг/	Хүний тоо	Мөнгөн дүн /сая.төг/
Сэргээн засах тусламж, үйлчилгээ	42,838	946.3	70,794	1 957.2	59,763	2,230.4	63,366	2,543.7
Гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ	7,538	188.5	41,545	1 286.5	38,189	1,513.7	60,995	5.663,4
Өдрийн эмчилгээ	7,259	217.6	52,871	2 013.4	59,052	3,930.0	61,840	4.234,9
Оношилгоо шинжилгээ	24,571	368.7	287,418	2729.0	340,376	4,015.2	258,173	2.693,9
Нийт дүн	82,206	1,720.1	452,628	8,986.1	497,380	11,690.4	444,374	15,135.9

Эх үүсвэр: ЭМДЕГ

Эрүүл мэндийн байгууллагын төрлөөр нь харахад улсын хэмжээнд 297 ӨЭМТ-ийн үзүүлсэн 13,854 тусламж, үйлчилгээний тохиолдолд 4.8 тэрбум төгрөгийн санхүүжилт, 312 СЭМТ-ийн үзүүлсэн 430,520 тусламж, үйлчилгээний тохиолдолд 10.4 тэрбум төгрөгийн санхүүжилт авсан байна.

4.6.2.2 Эрх зүйн орчин

Нэг иргэнээр санхүүжүүлэх төлбөрийн аргыг 2000 оноос хэрэглэж эхэлсэн. Ингэхдээ тогтмол зардлыг орон нутгаас төсвөөс гүйцэтгэлээр (40 хувь) хувьсах зардлыг (60 хувь) АХБ-ны бодлогын зээлээс нэг иргэнээр тооцон санхүүжүүлж байсан бөгөөд сүүлд нь хувьсах зардлыг ЭМД-н сангаас санхүүжүүлдэг болсон. Нэг иргэнээр тооцсон тариф нь хүн амын эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хэрэгцээ болон ядуу ба ядуу биш гэсэн 2 хүчин зүйлийг харгалзан тооцож байсан.

2006 онд Эрүүл мэндийн тухай хууль болон эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж 2007 оноос эхлэн 100 хувь улсын төсвөөс нэг иргэнээр санхүүжүүлдэг болсон. Нэг иргэнээр тооцоход ядуу болон ядуу биш бүлгийг зааглахад хүндрэлтэй байсан тул амьдарч буй газраар нь гэр хороолол ба байшин хороолол гэж ялгах болсон. 2020 оныг хүртэл нэг иргэнээр тооцсон тарифыг Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын тушаалаар баталж ирсэн.

Хүснэгт 14 Нэг иргэнээр тооцсон суурь тариф

Батлагдсан огноо	Дугаар	Суурь тариф	Өсөлтийн хувь
2012.06.05	Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын 193/A/136 хамтарсан тушаал	6,559	14.7
		7,521	
2015.04.09	Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын 136/A/77 хамтарсан тушаал	8,865	17.9
2017.12.07	Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын 498/A/350 хамтарсан тушаал	9,173	3.5
2018 он		10,140	10.5
2019.12.09	Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын 257/A/562 хамтарсан тушаал	17,772	75.3

Нэг иргэнээр тооцсон тарифыг анх тогтоохдоо өртгийн судалгаа хийж, эрсдлийн коэффициентийг тодорхойлсноос хойш анхан шатлалын тусламж, үйлчилгээний тарифыг өртөг зардлын судалгаа, нотолгоонд үндэслэн боловсруулалгүй зөвхөн төрийн албан хаагчдын цалингийн өсөлттэй уялдуулан механик байдлаар нэмэгдүүлж ирсэн. Үүний дүнд тусламж, үйлчилгээний нэр төрөл, багц нэмэгдэж ирсэн хэдий ч, чанар үр дүнг дээшлүүлэхэд санхүүжилт хангалтгүйн улмаас зорилгодоо хүрч чадахгүй байна.

“Эрүүл мэндийн тухай”, “Эрүүл мэндийн даатгалын тухай” хуулиудад 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдөр орсон нэмэлт өөрчлөлтийн дагуу 2021 оноос эхлэн төр төлбөрийг нь хариуцах тусламж, үйлчилгээний нэг болох “Эрүүл мэндийн тухай хуулийн 24.6.10-т заасан өрх, сум, тосгоны хэмжээнд зарим тусламж, үйлчилгээ”-г эрүүл мэндийн даатгалын сангаар дамжуулан худалдан авахаар болсон.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 11.2. Энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын эрүүл мэндийн даатгалын сангаас болон даатгуулагчаас төлөх төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журмыг эрүүл мэндийн даатгалын байгууллага болон санхүү, төсвийн, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг тус тус үндэслэн Үндэсний зөвлөл тогтооно” гэж заасан.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9.1.9-д заасан өрх, сум, тосгоны ЭМТ-өөс үзүүлэх зарим сэргээн засах тусламж, үйлчилгээ, оношилгоо, шинжилгээ, өдрийн эмчилгээ, гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээний зардлыг даатгалын сангаас санхүүжүүлэх хүрээнд магадлан итгэмжлэгдсэн, сонгон шалгаруулалтанд тэнцсэн өрх, сум, тосгоны ЭМТ-ийн 4 төрлийн тусламж, үйлчилгээг 2018 оны 8 дугаар сараас эхлэн даатгалын сангаас ЭМДҮЗ-ийн 23 дугаар тогтоолын дагуу санхүүжүүлж ирсэн. Мөн ЭМДҮЗ-н 2021 оны 04 тоот тогтоолоор “Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээ”, “Эрүүл

мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийн арга”, “Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн төсвийг тооцох, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх журам”, “Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн тээвэр, шатахууны зардлыг тооцох индекс”-ийг баталсан. Гэхдээ 2019 оны Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалын нэг иргэнд ногдох зардлын тарифыг өөрчлөлгүйгээр баталсан.

Дээрхи эрх зүйн орчны өөрчлөлттэй уялдуулан “Монгол улсын 2021 оны Төсвийн тухай” хуулиар өрх, сум, тосгоны хэмжээнд үзүүлэх тусламж, үйлчилгээнд улсын төсвөөс санхүүжүүлдэг 198,7 тэрбум төгрөгийг эрүүл мэндийн даатгалын санд шилжүүлсэн.

Гэвч “Төсвийн тухай” хуулийн дагуу анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын улсын төсвөөс санхүүжүүлэх санхүүжилт нь “Тусгай зориулалтын шилжүүлэг”-ийн дагуу аймаг, нийслэлийн Засаг даргын санхүүжилт рүү шилждэг тогтолцоо хэвээр байсан нь анхан шатны эрүүл мэндийн байгууллагыг санхүүжүүлэх улсын төсвийн болон эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн тушаал шийдвэрүүдийг нэгтгэх боломжгүйд хүрсэн.

“Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай” хуулиар өрх, сум, тосгоны хэмжээнд үзүүлэх тусламж, үйлчилгээг төсвийн тухай хуулийн дагуу тусгай зориулалтын шилжүүлгээр ЭМДС-гаас ЭМДҮЗ-ийн 2021 оны 04 тоот тогтоолын дагуу орон нутагт шилжүүлж хэрэгжүүлсэн. Харин 2022 онд Төсвийн тухай хуулийн шинэчлэлийн хүрээнд анхан шатны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тусгай зориулалтын шилжүүлгээс гаргаж ЭМДС-гаас шууд санхүүжүүлэхээр УИХ-аас баталсан.

2022 онд сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээг лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээний багц, төлбөрийн аргаар санхүүжүүлэхээр бодлогын шийдвэр гарсан тул өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам батлах тухай тогтоолыг шинэчлэн батлах шаардлага үүссэн. Үүнтэй уялдан ЭМДҮЗ-н 04 тогтоолыг 2022 оны 3-р сард шинэчилэн баталсан.

4.6.2.3 Төлбөрийн арга

Эрүүл мэндийн анхан шатны байгууллагууд нэг иргэнээр болон тохиолдолд суурилсан төлбөрийн холимог тогтолцоог хэрэглэж байна. Нэг иргэнээр тооцох арга үр ашиг, иргэдэд хүрч үйлчлэхэд хөрөнгөө ашиглах боломж өгдөг тул хүн амын дундах тусламж үйлчилгээний хүртээмжид эерэг нөлөөтэй гэж үздэг. Үйлчилгээ үзүүлэгчид төсвөө уян хатан зарцуулах боломжийг бүрдүүлж байгаа нь үр ашигт сайнаар нөлөөлдөг.

Хүснэгт 15. Анхан шатны тусламж, үйлчилгээний төлбөрийн арга

	Санхүүжилтийн эх үүсвэр	Тусламж, үйлчилгээ	Төлбөрийн арга
ӨЭМТ	Төсөв	Үндсэн тусламж, үйлчилгээ	Нэг иргэнээр
	Эрүүл мэндийн даатгал	Оношилгоо, шинжилгээ	Тохиолдлоор
		Зарим сэргээн засах ТҮ	
		Гэрээр үзүүлэх ТҮ	
		Өдрийн эмчилгээ	
СЭМТ	Төсөв	Үндсэн тусламж үйлчилгээ	Нэг иргэнээр
Эрүүл мэндийн даатгал	Хэвтүүлэн эмчлэх ТҮ	Тохиолдлоор	
	Түргэн тусламж		
	Яаралтай тусламж		
	Төсөв	Шатахуун	Алслагдмал байдал
	Орон нутгийн төсөв	Тогтмол зардал	Гүцэтгэлээр

Монголын нэг иргэнээр тооцох тогтолцооны төлбөрийн суурь хэмжээг тооцоолохдоо төрийн албаны цалин хөлстэй уялдуулан тогтоож ирсэн. 2020 оноос ЭМД-ын сангаар дамжуулан тусламж үйлчилгээг худалдан авах болсонтой уялдан өртөгт суурилж тооцоолдог болсон. 2022 онд нэг иргэнээр тооцсон тарифыг 2020 оныхоос 2 дахин нэмэгдүүлсэн.

Хүснэгт 16. Нэг иргэнээр тооцсон тарифын өөрчилөлт

№	Хүн амын эрүүл мэндийн эрсдлийн бүлэг		Хүн амын эрсдлийн бүлгийн коэффициент	Тариф			
	Насны бүлэг	Оршин суугаа газар		2008	2017	2020	2022
1	5	Гэр хороолол	3.0	13,440	27,518	53,316	106,632
2	хүртэлх нас	Орон сууц	2.6	11,760	23,849	46,207	92,414
3	6-15 нас	Гэр хороолол	1.3	5,460	11,924	23,104	46,208
4		Орон сууц	1.2				
5	16-49 насны эмэгтэйчүүд	Гэр хороолол	1.4	5,880	12,842	24,881	49,762
6		Орон сууц	1.4	5,880	12,842	24,881	49,762
7	60 наснаас дээш	Гэр хороолол	1.9	8,400	17,428	33,767	67,534
8		Орон сууц	1.7				
9	Бусад*	Гэр хороолол	1.1	4,620	10,090	19,549	39,098
10		Орон сууц	1.0				
Дундаж тариф				7224	15,227	30,000	59,003

2022 оны ЭМДҮЗ-ийн 5 дугаар тогтоолоор сум, тосгоны эрүүл мэндийн төвийг дараахь томъёогоор тооцож санхүүжүүлэхээр болсон.

$$НС = НИС + ЭТҮС + ТЗС + ЭМДС$$

НС – тухайн сум, тосгоны эрүүл мэндийн төвийн нийт санхүүжилт

НИС – нэг иргэнээр тооцсон суурь санхүүжилт

ЭТҮС – тохиолдлоор тооцсон тусламж, үйлчилгээний санхүүжилт

ТЗС – байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын санхүүжилт

ЭМДС – ЭМД – ын сангаас хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилт

$$НИС = \sum_{k=0}^n \binom{n}{k} Pop_i \times Tari * Geoi$$

НИС – нэг иргэнээр тооцсон суурь төсөв

Pop_i – хүн амын эрсдлийн бүлгийн коэффициент

Tari – нэг иргэнд ногдох зардлын доод хэмжээ

Geoi – газарзүйн коэффициент

Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх тусламж үйлчилгээний багцыг тохиолдол суурилсан төлбөрийн аргаар тооцож санхүүжүүлж байна.

Хүснэгт 17. ЭМД-н сангаас санхүүжүүлэх тусламж үйлчилгээний тариф

		2019-10-25, 23-р тогтоол, ЭМДҮЗ	2020-11-25, 14-р тогтоолд, ЭМДҮЗ
Сэргээн засах тусламж, үйлчилгээ		45,000	45,000
Өдрийн эмчилгээ		70,000	70,000
Гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ	ӨЭМТ,СЭМТ 20 км дотор радиуст	50,000	10,000 (Тохиолдлоор)
	Сумын ЭМТ-с 20 км-с дээш радиуст	70,000	14,000 (Тохиолдлоор)
Оношилгоо шинжилгээ		20,000	20,000

Харин 2022 оны ЭМДҮЗ-ийн тогтоолоор сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээг лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээний багц, төлбөрийн аргаар санхүүжүүлэхээр болсон.

Мөн Сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх дараахь тусламж үйлчилгээг тохиолдол суурилсан төлбөрийн аргаар улсын төсвийн эх үүсвэрээр эрүүл мэндийн даатгалын сангаар дамжуулан санхүүжүүлж ирсэн.

Тусламж үйлчилгээний төрөл	Төлбөрийн хэмжээ (төгрөг)
Яаралтай тусламж, үйлчилгээ	35,000
Түргэн тусламжийн үйлчилгээ	43,000
Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ	260,000

ЭМДҮЗ-ийн 2019 оны 23 дугаар тогтоолоор баталсан Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9-д заасан өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх 4 төрлийн тусламж, үйлчилгээг анхан шатны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний үндсэн багцтай уялдуулж, нэгтгэн боловсруулсан.

2022 оны ЭМДҮЗ-ийн 03 дугаар тогтоолоор анхан шатны эрүүл мэндийн байгууллагын төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн баталсан. Энэхүү тогтоолын хүрээнд сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх дээрхи (яаралтай, түргэн, хэвтүүлэн эмчлэх) тусламж, үйлчилгээг тохиолдолд суурилсан төлбөрийн аргаар лавлагаа шатлалын эмнэлгийн тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх багц, төлбөрийн аргаас санхүүжүүлэхээр болсон. Энэхүү шийдвэр анхан болон лавлагаа шатлалын санхүүжилтийн уялдаа холбоог сайжруулах, давхардлыг арилгах, үр ашгийг сайжруулахад чухал алхам болсон.

4.6.3 Гэрээлэх

Өрхийн эрүүл мэндийн төв нь аймаг, хийслэлийн эрүүл мэндийн газрын даргатай гэрээ байгуулж аймаг нийслэлийн засаг даргаар баталгаажуулж байна. Энэхүү гэрээгээр анхан шатны цогц тусламж, үйлчилгээг чанартай үзүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулж байна. Гэрээг гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт болон гэрээний хэрэгжилтийн тайланг хагас, бүтэн жилд гарган аймаг нийслэлийн эрүүл мэндийн газарт албан бичгээр хүргүүлэхээр зохицуулсан. Гэрээний хүрээнд эмнэлгийн тусламж үйлчилгээ, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, урьдчилан сэргийлэхтэй холбоотой 110 гаруй гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүдээр ӨЭМТ нь тайлагнаж байна.

Эрүүл мэндийн багц хуулиудын нэмэлт өөрчлөлтийн хүрээнд улсын төсөв, ЭМД-ын сангуудыг нэгтгэж ЭМД-ын санд төвлөрүүлэх, тусламж, үйлчилгээний чанартай уялдсан стратегийн худалдан авалтын хүрээнд ЭМДЕГ нь анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудтай “Тусламж үйлчилгээг худалдан авах гэрээ” байгуулах болж байна. Энэхүү гэрээгээр тусламж, үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээ, төлбөрийн хэмжээ, тусламж үйлчилгээний тоо болон чанарыг хэмжих шалгуур үзүүлэлтүүд болон талуудын харилцах сувгийг тодорхойлсон. Гэрээгээр Эрүүл мэндийн тухай хуулийн 24.6.10-т заасан өрх, сум, тосгоны хэмжээнд үзүүлэх төлбөрийг нь төр хариуцах тусламж, үйлчилгээнд нэг иргэнээр тооцсон санхүүжилтийн 80 хувийг сар бүрийн 11-ний дотор эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчид олгон, үлдэгдэл 20 хувийг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчийн сар бүр цахимаар гэрээний шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэлийн үнэлгээнд үндэслэн олгох эсэхийг шийдэхээр заалт орсон. Энэхүү гэрээний хавсралтаар гарцад сууилсан 14 гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт батлагдсан. Энэхүү гэрээ нь стратегийн худалдан авалтын тогтолцоонд суурилан **ямар** төрлийн тусламж үйлчилгээг, **хэдий** хэмжээгээр, хэнээс худалдан авахыг тодорхой оруулж өгсөн.

4.7 СЭМТ-ийн нөхцөл байдлын үнэлгээний дүн

Булган аймгийн Дашинчилэн, Хутаг-Өндөр, Баяннуур, Орхон, Хөвсгөл аймгийн Тариалан, Тосонцэнгэл, Хатгал, Их-Уул сумын эрүүл мэндийн төвийн дарга, их эмч, ахлах сувилагч, эх баригч бага эмч, статистикийн бага эмч нартай эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний давуу болон сул талуудын талаар ярилцаж, нөхцөл байдлын үнэлгээ хийж, тулгамдсан асуудлуудыг тодорхойлсон.

Хүснэгт 18. СЭМТ-ийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний давуу болон сул тал, нийтлэг тулгамдсан асуудлууд

Үзүүлэлтүүд	Давуу тал	Сул тал	Тулгамдсан асуудлууд
Эрүүл мэндийн санхүүжилт	<ul style="list-style-type: none"> - Нэг иргэнээр тооцсон санхүүжилт нэмэгдсэн - Хүн ам олонтой (6,500) тул, цаашид нэг иргэнээр тооцсон санхүүжилт нэмэгдэнэ 	<ul style="list-style-type: none"> - Өнөөдрийн байдлаар энэхүү нэмэгдэл орж ирээгүй байна. - ЭМД-аас 4 төрлийн тусламж үйлчилгээг үзүүлж санхүүжилт авахаас өөр уламжлалтын 	<ul style="list-style-type: none"> - Санхүүжилт хомс - Нэг иргэнээр тооцсон санхүүжилт СЭМТ-д ороогүй - Хүн ам цөөнтэй СЭМТ-үүд санхүүгийн эрсдэлд орно - Хуучин сум дундын том эмнэлгүүд

	<ul style="list-style-type: none"> - Гүйцэтгэлээр санхүүждэг болсон - Өдрийн эмчилгээ, сэргээн засах, гэрийн сувилахуй, оношилгоо шинжилгээний тусламж үйлчилгээгээр санхүүждэг 	<ul style="list-style-type: none"> үйлчилгээг үзүүлэх боломжгүй тул санхүүжилт бага байна - Ойрын дуудлагад шөнө, амралтын өдөр илүү цагаар ажилласан үед илүү цагийн мөнгө өгдөггүй - Санхүүжилт дутснаас өргөтгөлийн барилгын ажил зогссон - Хуучнаараа хийсэн зүйлээ баримтжуулахгүй явахаар гүйцэтгэлийн санхүүжилтийг дутуу авч байна. 	<ul style="list-style-type: none"> санхүүгийн эрсдэлд орохоор байна - Цахим бүртгэлд гүйцэтгэлээ бүрэн оруулаагүйгээс санхүүжилт хасагдах эрсдэлтэй - Цахим бүртгэлийн програм хангамж алдаа өгдөг - Шинэ цахим програмд ажиллах компьютерийн хүрэлцээ муутай - Эмч, эмнэлгийн ажилтны цалин бага.
<p>СЭМТ-ийн хүний нөөц</p>	<ul style="list-style-type: none"> - Залуу эмч нар нэмэгдэж байна - Хөрвөх чадвартай эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдтэй - Эмч, мэргэжилтнүүдийг гардан үйлдлийн сургалтад хамруулдаг - Зарим СЭМТ бүрэн орон тоогоор ажилладаг - Бүх СЭМТ эх баригч бага эмч нараар хангагдсан 	<ul style="list-style-type: none"> - Шинэ боловсон хүчнийг нийгмийн талаас дэмжих дэмжлэг муу (орон сууц гэх мэт) - Уламжлалтын их эмч, шүдний эмч, сувилагч дутмаг - Цалин ажлын ачааллын хэмжээнд биш, ачаалалтай харьцуулалахад цалин хөлс бага, илүү цагаар их ажилладаг - Их эмч нарын тогтвор суурьшил муу 	<ul style="list-style-type: none"> - СЭМТ-д чадвартай мэргэжилтнээр хүний нөөцөө бүрдүүлэх боломж хомс байна. - Сувилагч дутагдалтай - Их эмч нар тогтвор суурьшил муутай - Шинэ боловсон хүчний орон сууцны асуудлыг шийдэх шаардлагатай - Төгсөлтийн дараах сургалтад хамруулалт хангалтгүй - Эмч, сувилагч, эмнэлгийн

		<ul style="list-style-type: none"> - Анхан шатны олон маягт хөтөлдөг - Орон нутгаас эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг бэлтгэдэггүй нь тогтвор суурьшилд сөргөөр нөлөөлж байна. 	<p>мэргэжилтэн, ажилтны хөдөлмөрийн үнэлэмж бага, тэдний хийж буй ажил бодитой үнэлэгдэхгүй, авч буй ажлын хөлс нь амьдралын хэрэгцээгээ хангахад хангахад хүрэлцэхгүй байгаагаас эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтний ажилдаа хандах үнэлэмж буурсан.</p>
<p>Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний үр дүн</p>	<ul style="list-style-type: none"> - Хүний нөөц дутагдалтай ч тусламж үйлчилгээг тасралтгүй хүргэж байна - Жирэмсний хяналт, нярайн эргэлт, халдварт бус өвчнийг эрт илрүүлэлт сайн явагддаг - Сумын нийт хүн амын 85%-ийг урьдчилан сэргийлэх үзлэгт жил бүр хамруулдаг - Жирэмсний эрт үеийн хяналт ихэссэн (96%). Осол гэмтэл буурч байгаа. Зүрх судасны өвчлөл буурсан 	<ul style="list-style-type: none"> - Хүний нөөц дутагдалтай байгаа тул нэг хүн хоёр хүний ажлыг хийдэг - Ихэнх СЭМТ-ийн барилга стандартын шаардлага хангахгүй байна - Өрөө тасалгааны урсгал зохицуулалт буруу - Ажиллах нөхцөл муу - Нарийн мэргэжлийн тусламж, үйлчилгээ үзүүлэхээр АНЭ-т олон хүнийг явуулдаг - Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангамж муу - Автамашин дутмаг - Осол гэмтэл нэмэгдэж байна 	<ul style="list-style-type: none"> - Эмнэл зүйн стандартуудыг Үндэсний стандартын байгууллагаас худалдаж авхыг шаарддаг - Эмч нар төвөөс сургалтад хамрагдаад, дээд шатлалын эмнэлэгт шилждэг.

		<ul style="list-style-type: none">- Яаралтай тусламжийн дуудлага их- Хүн амын дунд шүдний өвчлөл их- Иргэдийн хөдөлгөөний хомсдол их, амьдралын буруу хэв маяг их байна.	
--	--	--	--

5. ДҮГНЭЛТ

5.1 ЭМАШТУ-ний байгууллагын удирдлага, бүтэц, зохион байгуулалтын тулгамдсан асуудлууд

- Хөдөө орон нутгаас Улаанбаатар хот руу шилжин ирэгсдийн урсгал хурдацтай нэмэгдсээр байгаа нь эрүүл мэндийн байгууллагуудын ачааллыг нэмэгдүүлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд хүний нөөцийн, тоног төхөөрөмжийн хангамж, санхүүжилтийн бэрхшээл хүндрэлийг ихэсгэж байна.
- Лаборатори, оношилгоо шинжилгээ дутагдалтай, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ хангалтгүй, хүний нөөцийн чадавхи сул, хувийн хэвшил нь зохицуулалт муутай болон чанарын хяналт тааруу байна,
- Санхүүжилт хомс, байшин барилга, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ хангалтгүй зэргээс шалтгаалан ЭМАШТУ нь хөдөө орон нутагт багагүй бэрхшээлтэй тулгарч байна,
- Тусламж үйлчилгээний нэгдмэл загвар болон цахимжуулалт хөгжөөгүйгээс анхан болон хоёрдогч шатлалын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний уялдаа холбоо муу, салангид байна,
- Төр, хувийн хэвшлийн түншлэлийн (ТХХТ) зохицуулалтын тогтолцоо бүрэн хөгжөөгүй, хувийн хэвшлийн эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх, үр нөлөөг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

5.2 ЭМАШТУ-ний чанар

Дэлхийн улс орнууд эрүүл мэндийн тогтолцоонд гол анхаарлаа хандуулж, эрүүл мэндийн тогтолцоог сайжруулах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, бүх нийтийг чанарын удирдлагад шилжүүлэх өөрчлөлт шинэчлэл хийх талаар ихээхэн анхаарал тавьж, хүчин чармайлт гаргаж байна.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-аас хэн, хаана амьдарч байгаагаас үл хамааран бүхий л иргэд үйлчлүүлэгчийн хувьд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах явцад учирч болох аливаа хохирол эрсдлийг 2030 он хүртэл шат дараатайгаар бууруулах замаар тусламж, үйлчилгээг сайжруулахад чиглэсэн “Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын талаар хэрэгжүүлэх төлөвлөгөө 2021-2030” хөтөлбөрийг баталсан.

Монгол улсын урт хугацааны бодлогын 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2.2 дахь зорилгод “Эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэн төлөвшүүлэн эрүүл мэндийн чанар, хүртээмж, үр дүнтэй тогтолцоог хөгжүүлнэ” гэж заасан.

Манай улсын эрүүл мэндийн салбарын чанарын удирдлага 20 гаруй жилийн түүхтэй, бөгөөд Эрүүл мэндийн сайдын 1998 оны А/155 дугаар тушаалаар эмнэлгүүдэд чанарын менежер ажиллуулах, 2000 оны А/167 дугаар тушаалаар эмнэлгүүдэд орон тооны бус чанарын алба байгуулахыг, 2007 оны 275 дугаар тушаалаар эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарын албаны бүтцийг, 2008 оны А/176 дугаар тушаалаар “Эмнэлгийн тусламж, үйлчилгээний удирдлагын тогтолцоог бэхжүүлэх хөтөлбөр”-ийг, 2010 оны А/225 дугаар тушаалаар “Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарын дотоод хяналтыг эрчимжүүлэх”, 2011 оны 349 дүгээр тушаалаар “Дүрэм батлах тухай”, Монгол улсын шадар сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2012 оны “Чанарын албаны дүрэм батлах тухай” 06/25 дугаар тушаал, Монгол улсын шадар сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2019 оны “Дүрэм батлах тухай” 116/ А /565 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2019 оны “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах зарим арга хэмжээний тухай” А/566 дугаар тушаалаар, Эрүүл мэндийн сайдын 2022 оны “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах ажлын удирдамж, хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлах тухай” А/136 дугаар тушаалаар тус тус батлан хэрэгжүүлж байна.

“Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний хөгжил”-ийн зөвлөх багаас ӨЭМТ, СЭМТ-ийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг үнэлгээ хийж, дараах дүгнэлтийг хийж байна.

А. Давуу тал буюу ололт амжилтууд:

- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах талаар бодлогын баримт бичиг, заавар, журмууд батлагдан хэрэгжиж эхэлсэн,
- ӨЭМТ, СЭМТ-үүдийн 86,7 хувь нь Төвийн даргын тушаалаар “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын баг”-ийг байгуулсан,
- ӨЭМТ, СЭМТ-үүдийн 86,7 хувь нь “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах зарим арга хэмжээний тухай” А/566 дугаар тушаалын дагуу “Чанар аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөө” боловсруулж, батлан хэрэгжүүлдэг,
- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой үүссэн, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх тохиолдлуудыг бүртгэж, мэдээлдэг, арга хэмжээ авах яаралтай тусламжийн багц бэлтгэсэн,
- ӨЭМТ, СЭМТ-үүдийн 93,3 хувь нь үйлчлүүлэгчдээс сэтгэл ханамжийн судалгаа авдаг болсон байна,

- Эмнэлгийн мэргэжилтнүүд чанарын тухай ерөнхий ойлголттой болсон,
- ӨЭМТ, СЭМТ-үүдийн 86,7 хувь нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний стандарт, эмнэлзүйн удирдамж, зааврыг мөрдүүлж, хэрэгжилтэд хяналт тавьдаг,
- Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтний цалин урамшууллын тогтолцоо шинэчлэгдсэн,
- Мэдээллийн технологийн шинэчлэл хийгдэж эхэлсэн.

Б. Сул тал буюу тулгамдсан асуудлууд:

- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах талаар эрх зүйн баримт бичиг, тушаал, заавар, журмууд байгаа ч анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад хэрэгжих боломжгүй, бичиг цаас бүрдүүлэх ажил төдий болж байна.
- “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах зарим арга хэмжээний тухай” А/566 дугаар тушаалын дагуу эрсдлийн үнэлгээ хийдэггүй,
- ӨЭМТ, СЭМТ-үүдийн “Чанар аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөө”-ний биелэлт нь дунджаар 63,7 хувь байна,
- Үйлчлүүлэгчид болон эмнэлгийн ажилтнуудын аюулгүй байдлыг хангах, эрсдлээс хамгаалах орчныг бүрдүүлэх санал гаргаж шийдвэрлүүлсэн байдал дөнгөж 6,7 хувь байгаа нь ямар санаачлагагүй ажил урсгалаар явж байгааг харуулж байна,
- Эмнэлгийн орчинд үйлчлүүлэгч унахаас сэргийлэх арга хэмжээг 13,3 хувь буюу хоёрхон төвд хэрэгжүүлсэн нь хангалтгүй байна,
- ӨЭМТ, СЭМТ-үүдийн 26,7 хувь чанарын шалгуур үзүүлэлтэнд дүгнэлт хийж байгаа нь, чанарыг сайжруулах үйл ажиллагаа хангалтгүйг илтгэж байна,
- Үйлчлүүлэгчийг танин тодруулга хийх талаар эмч, мэргэжилтнүүдээс асууж тодруулахад мэдлэг муу байсан,
- “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах зарим арга хэмжээний тухай” А/566 дугаар тушаалын дагуу ижил мэргэжилтний үнэлгээ хийдэг боловч, үнэлгээний шалгуур нь тодорхойгүйгээс, тогтмолжсон үйл ажиллагаа болж хэвшээгүй байна,
- ӨЭМТ, СЭМТ-үүдийн “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын баг”-ийн ажиллах журмыг тусгайлан боловсруулах шаардлагатай,
- Чанарын багаас хийгддэг хяналт, шалгалтыг ямар зорилготойгоор хийдэг тухай нэгдсэн ойлголт дутмаг, эргэн мэдээлэх тогтолцоо бүрдээгүй, чанар сайжруулах арга хэрэгсэл болж чадаагүй байна.

5.3 ЭМАШТҮ-ний хүний нөөц

“Эрүүл мэндийн салбар дахь хүний нөөцийн талаарх олон улсын стратеги: Ажилчдын хүч 2030” нь 2016 оны 5 сард болсон 69 дэх удаагийн Дэлхийн Эрүүл мэндийн Чуулганы тогтоолоор батлагдсан. Энэхүү стратеги дэхь 19 зорилго нь эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх, эрүүл мэндийн тогтолцоонд хамаарах эрүүл мэндийн нийт ажилтнуудын хүртээмж, хамрах хүрээ, чанарыг хангахад чиглэгддэг.


Монгол Улсад Үндсэн хуулийг удирдлага болгон Төрийн албаны тухай хуулийг 1995 онд анх батлан хэрэгжүүлж эхэлсэн. Уг хуулиар төрийн албаны ангилал, зарчим, төрийн албан тушаал, түүнд тавигдах шаардлага, төрийн албан хаагчийн эрх зүйн байдал, төрийн алба хаах болзол, журмыг зааж төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл баталгааны талаар олон асуудлыг зохицуулж өгсөн. Тухайлбал Монгол улсын Үндсэн хуулийн 46 дугаар зүйлийн 46.3-т “Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгааг хуулиар тогтооно”, Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.13-т “Төрийн байгууллагаас төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөр болон ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг арга зүйн удирдлагаар хангах” гэж заасан.

Хууль эрх зүйн орчны хувьд эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн чиглэлээр “Эрүүл мэндийн тухай” хуулинд Төгсөлтийн дараах сургалтын төрөл, Резидент эмчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, Төгсөлтийн дараах сургалтын удирдлага, зохион байгуулалт, Төгсөлтийн дараах сургалтын улсын төсвийн санхүүжилт, “Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай” хуулинд Мэргэшсэн эмчийн эрх, үүрэг, Резидент эмчийн ажлын байр, эрх үүрэг, цалин, Сургалт эрхлэх байгууллага, Сувилахуйн дагнасан тусламж, үйлчилгээний зохион байгуулалт, санхүүжилтын асуудлыг тус тус хуульчлан батлан мөрдүүлж байна. Мөн Эрүүл мэндийн сайдын тушаалаар Мэргэшүүлэх болон тасралтгүй сургалт зохион байгуулах,, сургалт эрхлэх байгууллагыг сонгох, зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох журам (2017), Төгсөлтийн дараах мэргэшүүлэх сургалтын чиглэл, индекс (2016, 2021), Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, нөхөн олгох,, хүчингүй болгох журам (2015), Мэргэшлийн зэрэг олгох, нөхөн олгох, хүчингүй болгох журам (2019)-ыг тус тус батлан хэрэгжүүлж байна. ЭМЯ “Хүний хөгжлийн зорилтот хөтөлбөр” дунд хугацааны бодлогын баримт бичгийг боловсруулж байна.

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн гаргасан “Эрүүл мэндийн үзүүлэлт”-ээс харахад 2020 онд нийт 56,502 эрүүл мэндийн ажилтнууд байгаагаас 3175 нь ӨЭМТ-д ажиллаж байна. ӨЭМТ-ийн нийт ажилтнуудын 35.4 хувь нь их эмч, 32.9 хувь нь сувилагч, 4.2 хувь нь нийгмийн

эрүүл мэндийн мэргэжилтэн байна. Улсын хэмжээнд сувилагч, эмчийн харьцаа 1.1:1 байгаа ба ӨЭМТ-ийн хэмжээнд 0.9:1 байгаа нь олон улсын дундаж үзүүлэлтээс доогуур байна² (График 36).

График 36. Сувилагч, эмчийн харьцаа, 2017



Эх сурвалж: Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD) Эрүүл мэндийн статистик, 2019 он

Улаанбаатар хотод ажиллаж буй их эмчийн тоо орон нутагт ажиллаж буй эмчийн тооноос харьцангуй их байна. 209 өрхийн эрүүл мэндийн төвд их эмч 1123, сувилагч 1045 болон нийт 3175 эмч, эмнэлгийн ажилтнууд хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлж байна.

Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/540 дугаар тушаалаар сумын эрүүл мэндийн төвүүдийг (аймгийн төвөөс алслагдсан байдал, хүн амын тоо, аймагийн төв хүртэлх зорчих хугацаанаас хамааран) А, Б, В гэсэн 3 зэрэглэлд ангилсан.

Сумын эрүүл мэндийн төвийн А зэрэглэлд өөрийн сумын иргэдэд өрхийн эрүүл мэндийн төвийн тусламж үзүүлэхээс гадна зэргэлдээх сумын хүн амд 4-өөс доошгүй үндсэн мэргэшлийн тусламж үйлчилгээг үзүүлэх чадавхи бүхий сумын эрүүл мэндийн төвүүд хамаарна.

² Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD) Эрүүл мэндийн статистик, 2019 он

Сумын эрүүл мэндийн төвийн Б зэрэглэлд улсын хилийн дагуу болон улсын чанартай автозам, төмөр зам дагуу байрласан, осол гэмтлийн онцгой бүс, уул уурхай, үйлдвэрлэл, аялал жуулчлал хөгжсөн бүс нутгийн сумын эрүүл мэндийн төвүүд хамаарна. Сумын эрүүл мэндийн төвийн А болон Б зэрэглэлд хамрагдаагүй бусад бүх сумын эрүүл мэндийн төвүүд В зэрэглэлд хамрагдана.

2020 оны байдлаар А зэрэглэлд хамаарах сумын эрүүл мэндийн төв 54, Б зэрэглэлийн 123, В зэрэглэлд хамрагдах сумын эрүүл мэндийн төв 145, сумын нэгдсэн эмнэлэг 6 байгаа бөгөөд тухайн оны үзүүлэлтэд сумын хөдөөгийн нэгдсэн эмнэлгийн үзүүлэлтийг оруулж тооцсон.

Сум, тосгоны эрүүл мэндийн төвүүд, сумын нэгдсэн эмнэлэгт нийт 8399 ажиллагчид хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж байна. Үүнээс А зэрэглэлд хамаарах сумын эрүүл мэндийн төвд 20.9 хувь, Б зэрэглэлийн сумын эрүүл мэндийн төвд 31.8 хувь, В зэрэглэлд хамрагдах сумын эрүүл мэндийн төвд 36.8, тосгоны эрүүл мэндийн төвд 2.2, сумын нэгдсэн эмнэлэгт 8.23 хувь нь тус тус ажиллаж байна.

2020 оны байдлаар хүний их эмч 1257 буюу нийт ажиллагчдын 15.0 хувийг эзэлж байгаа ба сувилагч 2038 /24.3 хувь/, бага эмч 1019 /9.9 хувь/, эх баригч 370 /4.4 хувь/, эм найруулагч 153 /1.8 хувь/ тус тус ажиллаж байна. СЭМТ-ийн хэмжээнд сувилагч, эмчийн харьцаа 1.6:1 байна.

“Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний хөгжил”-ийн зөвлөх багаас ӨЭМТ, СЭМТ-ийн хүний нөөцийн өнөөгийн байдалд үнэлгээ хийж, дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- ӨЭМТ- стандартын дагуу ажиллах хүний нөөц 50 хувь дутуу ажиллаж байгаа нь иргэн бүрт хүрч очих тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжид сөргөөр нөлөөлж байна,
- СЭМТ-д их эмч, сувилагч дутагдалтай, тогтвор суурьшил муу байна,
- Сувилагч, эмчийн харьцаа үзүүлэлт олон улсын дунджаас доогуур байна,
- Эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны хөдөлмөрийн үнэлэмж бага, тэдний хийж буй ажил бодитой үнэлэгдэхгүй, авч буй ажлын хөлс нь амьдралын хэрэгцээгээ хангахад хангахад хүрэлцэхгүй байгаагаас эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтний ажилдаа хандах үнэлэмж буурсан байна,
- Үндсэн мэргэшлийн сургалт шаардлагатай,
- ӨЭМТ, СЭМТ-д чадвартай мэргэжилтнээр хүний нөөцийг бүрдүүлж чадахгүй байна.

5.4 ЭМАШТҮ-ний санхүүжилт

Өнөөгийн төлбөрийн аргын үнэлгээ

Нэг иргэнээр тооцсон төлбөрийн арга гэж тухайн багцад хамаарах тусламж, үйлчилгээнд хамрагдах нэг хүнд ногдох зардлыг урьдчилан тооцож санхүүжүүлэхийг хэлнэ.

Гол онцлог

- Урьдчилсан төлбөрт үйлчилгээ
- Зардлын дээд хэмжээг урьдчилан тогтооно
- Төсвийг шударга хуваарилдаг
- Хүнээ эрүүл байлгасны төлөөх урамшуулал

Өрхийн эрүүл мэндийн төв дээр нэг иргэнээр тооцох аргын хэрэгжилтийн зохицуулалт олон улсын жишиг, сайн туршлагад бусад төлбөрийн аргыг бодвол илүү ойр байна. ӨЭМТ нь хувийн хэвшлийн байгууллага учир илүү уян хатан төсвөө зарцуулах боломжтой байна. Сумын эрүүл мэндийн төв нь төсвийн байгууллага учраас мөнгөө зүйл ангиудаар уян хатан хуваарилдаг хэдий ч хязгаарлагдмал түвшинд байна.

Хүснэгт –19. Төлбөрийн тогтолцооны үнэлгээ

Төлбөрийн тогтолцооны үнэлгээ	
Давуу тал	
Нэг иргэнээр	Нэг иргэнээр тооцох төлбөрийн арга нь үйлчилгээ үзүүлэгчид илүү уян хатан нөхцөлийг өгдөг тул үр ашгийг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлдэг.
Тохиолдолд суурилсан (ОХБ)	Тохиолдолд суурилсан төлбөрийн арга нь тухайн тохиолдлын өртгийн хувийн жин ашигладаг тул үйлчилгээ үзүүлэгчид тусламж үйлчилгээний чанараа бууруулахгүй үр ашигаа нэмэгдүүлэх боломжийг өгдөг
Сул тал	
Нэг иргэнээр	Нэг иргэнээр тооцох төлбөрийн аргад зорилтот бүлгийн хүн амаа хэрхэн тооцож байгаад гэдгээс өөр онцгой хүндрэл багатай

Тохиолдолд суурилсан	<p>Энэхүү төлбөрийн аргын сул тал нь тохиолдол бүрийг бүрэн тодорхойлох, олон төрлийн оношилгоог зохицуулалт хийх боломж нь хязгаарлагдмал байдаг</p> <p>Эмнэлгүүдэд үр ашигаа (чанараа) сайжруулах хөшүүрэг болдог тул нэмэгдэл орлого олох нөхцөлийг бүрдүүлдэг</p>
----------------------	---

2022 оны ЭМДҮЗ-ийн 5 дугаар тогтоолоор өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн нэг иргэнээр тооцох санхүүжилтийг 2 дахин нэмэгдүүлж, төлбөрийн аргыг шинэчлэн баталсан. Гэвч анхан шатны эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудын төлбөрийн аргын талаархи ойлголт бага, компьютер, техник хангамж хангалттай бус байгаа нь бодит цагийн горимоор нэхэмжлэл илгээх, санхүүжилтээ бүрэн авч чадахгүй байх эрсдэл гарахаар байна. Мөн тусламж, үйлчилгээний гүйцэтгэл муутай, хүчин чадлаараа ажиллаж чаддаггүй сум дундын эмнэлгүүдийн санхүүгийн байдал хүндрэхээр байна.

6. ЗӨВЛӨМЖ

6.1 ЭМАШТУ-ний байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтийн санал, зөвлөмж

Төслийн ЭМАШТУ-г хөгжүүлэх бүрэлдэхүүн хэсэг нь бүтцийн болон зохион байгуулалтын өөрчлөлтөд дараах ажлуудыг багтаасан болно:

а) Анхан шатны тусламж үйлчилгээний чанар, гүйцэтгэл, үр ашгийг дээшлүүлэхийн тулд бүтцийн болон зохион байгуулалтын цогц шинэчлэлийг хэрэгжүүлнэ.

1. Салбарын дүн шинжилгээ хийж, өөрчлөлтийн үзэл баримтлалыг шинэчилнэ
 - Монгол Улсын ЭМАШТУ-ний өнөөгийн байдалд дүгнэлт хийж үнэлнэ.
 - Анхдагч болон хоёрдогч шатлалын тусламж, лавлагаа тусламж үйлчилгээний нэгдмэл загварыг боловсруулах
 - Өрх, сумын эрүүл мэндийн төвийн өргөтгөсөн үйлчилгээний багцыг боловсруулж, ӨЭМТ-үүдэд үзүүлж буй тусламж үйлчилгээний багцыг шинэчлэн (өргөтгөх), ӨЭМТ/СЭМТ-ийн байрны үйл ажиллагааны төлөвлөгөөг тодорхойлж, засвар үйлчилгээ үзүүлэхэд нэгээс доошгүй ТХХТ (Төр, хувийн хэвшлийн түншлэл)-ийн загварыг санал болгох.
2. ЭМАШТУ-ний шинэ загварыг турших
 - ӨЭМТ-ийн шинэ загварыг турших (тусламж үйлчилгээний үр ашиг, чанарыг сайжруулахын тулд илүү том боловч цөөн тооны ӨЭМТ-үүдийг байгуулах;
 - ЭМАШТУ-ний тусламж үйлчилгээний гүйцэтгэл, чанарын үзүүлэлтүүдийг тодорхойлох байнгын хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог бий болгох.
3. Нэгдмэл тусламж үйлчилгээний загварыг турших замаар байгууллагын шинэчлэлийг дэмжих
 - Улаанбаатар хотын анхан болон хоёрдогч шатлалын тусламж, үйлчилгээ үзүүлэгчдийн хоорондын уялдаа холбоог хангах тусламж үйлчилгээний нэгдмэл загварыг бий болгох боломжийн талаар үнэлгээ хийх
 - Монгол орны нөхцөл байдалд тохирсон туршилтын загваруудыг санал болгож, хэрэгжүүлэхийг дэмжих

ЭМАШТУ-ний Хөгжлийн Зөвлөх Баг нь Ажлын Даалгаварт хэд хэдэн аргыг ашигласан бөгөөд тухайлбал, “Монгол Улсын ЭМАШТУ-ний шуурхай үнэлгээ” зэрэг холимог арга барилыг ашигласан юм.

6.1.1 Одоогийн үйлчилгээний загвар

ЭМАШТҮ нь иргэдэд үнэ төлбөргүй үйлчлэх бөгөөд Эрүүл мэндийн тухай хуульд зааснаар улсын төсвийн орлогоос санхүүждэг. Монгол улсын ЭМАШТҮ-ний байгууллагууд (Өрхийн эрүүл мэндийн төв, сумын эрүүл мэндийн төвүүд) хүн амд эрүүл мэндийн гол үйлчилгээг өөрсдийн тогтоосон цэгт үзүүлдэг. Дархлаажуулалт, амаржих, 5 хүртэлх насны хүүхдийг гэрээр үзэх зэрэг найман төрлийн үйлчилгээ үзүүлдэг.

Тодруулбал, ӨЭМТ-үүд амбулаторийн үзлэг, урьдчилан сэргийлэх үзлэг, зарим лабораторийн шинжилгээ, гэрийн үзлэг, вакцинжуулалт зэрэг нэн шаардлагатай үйлчилгээний багцын хүрээнд төвлөрсөн суурин газрын хүн амд эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээг үзүүлдэг.

Одоогийн үйлчилгээний загвар нь Улаанбаатар хот болон аймгийн төвүүдийн Өрхийн эрүүл мэндийн төвд (ӨЭМТ) хамаарч байна. Өрхийн эмнэлгийн тогтолцоо 2002 оноос хойш бүрэлдэн орон даяар үйл ажиллагаагаа явуулж байна.

2019 оны байдлаар улсын хэмжээнд 209 ӨЭМТ үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд Улаанбаатар хотод 131 ӨЭМТ 1.466 мянган хүнд, 21 аймагт 78 ӨЭМТ 702.7 мянган хүнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж байна.

ӨЭМТ нь хувийн хэвшлийнх бөгөөд эрүүл мэндийн төв болон аймаг, дүүргийн Засаг даргын Тамгын газартай гурвалсан гэрээ байгуулан тусламж үйлчилгээ үзүүлдэг.

6.1.2 Одоогийн үйлчилгээний загвар – Хязгаарлах хүчин зүйлүүд

Одоогийн үйлчилгээний загварт хэд хэдэн хязгаарлах хүчин зүйлүүд харагдаж байна:

- Олон төрлийн үйлчилгээ үзүүлэгч нь ЭМЯ-нд захиргааны болон хүнд суртлын дарамтыг бий болгодог. Үйлчилгээ үзүүлэх гэрээг олон тооны бие даасан байгууллагуудтай байгуулж, олон тооны тайлан, хяналтын шугамыг хадгалах шаардлага гардаг.
- ЭМАШТҮ үзүүлэх өнөөгийн загвар (бие даасан үйлчилгээ үзүүлэгчид) нь үйлчилгээ үзүүлэхэд "нэгдмэл" хандлагыг шаарддаг тусламж, үйлчилгээг хөгжүүлэхэд томоохон саад учруулж байна. "(Хэвтээ) интеграци нь үйлчилгээ үзүүлэх үйл явцын нэг үе шатанд байгаа үйл ажиллагаа явуулж буй нэгжүүд болон байгууллагуудын үйл ажиллагаа нэг дор цугларах үед үүсдэг" (Lewis et al, 2010)
- Бие даасан менежерүүд болон байгууллагууд бэлэн санхүүжилтийг ашиглахтай холбоотой өөр өөр шийдвэрүүдийг гаргаж болох ба зарлагатай холбоотой шийдвэрүүд нь байгууллагуудын хооронд нийцэхгүй тохиолдолд үр дүнтэй сайн засаглал үүсэхэд бэрхшээл тулгардаг. Тухайлбал, байгууллагуудын хэмжээнд ижил албан тушаалд

(эмч/сувилагч) харьцангуй цалин санал болгож байгаа нь илт харагддаг бөгөөд боловсон хүчнийг тодорхойлохдоо өөр стандартыг мөрддөг: шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авахад өвчтний харьцаа болон өөр стандарт ашиглагдах гэх мэт. Ийм зөрчилтэй үйл явц нь худалдан авагч болон үйлчилгээ үзүүлэгчийн хооронд ил тод байдал дутмаг байгааг харуулж байна.

- ӨЭМТ нь ихэвчлэн 8-12 ажилтантай жижиг байгууллага юм. Ийм жижиг байгууллагууд нь зардал багатай, тоног төхөөрөмж худалдан авах гэх мэтэд санхүүгийн байдал хангалтгүй байдаг. Ажилтны хувийн болон мэргэжлийн хөгжлийн боломж болон байгууллагын хөгжлийн боломж хоцрогдолтой байдаг.
- Санхүүгийн хуваарьлалт зөвхөн “нэг хүнд ногдох” зарчмаар байдаг учир үйлчилгээний “илүү нийлүүлэлт” эсвэл “дутуу нийлүүлэлт” үүсэх боломж бий. Хүн ам нь бүтцийн хувьд харилцан адилгүй байдаг, тухайлбал, өндөр настан болон амьдралын боломж муутай хүн амд залуу насанд хүрэгчдийнхээс үйлчилгээ илүү хэрэгцээтэй байна.
- Үйлчилгээ үзүүлэгч тус бүр ямар үйлчилгээг үзүүлэх нь тодорхойгүй байгаа бөгөөд ӨЭМТ-үүдийн үйлчилгээг тусад нь хүргэж байгаа тул үйлчилгээний хуваагдал үүсэх нь зайлшгүй юм. Үйлчилгээ үзүүлэгчдийн хооронд үйлчилгээ үзүүлэх тодорхой зохицуулалт байхгүй байна.
- Олон тооны (бие даасан) үйлчилгээ үзүүлэгч нь үйлчилгээний стандарт, чанарын баталгаажуулалтын арга зүй, стандарт үйл ажиллагааны журам, өвчтөний аюулгүй байдалтай холбоотой үйл ажиллагаа, халдвараас урьдчилан сэргийлэх, хянах менежмент, сөрөг ослын менежмент зэрэг эмнэлзүйн засаглалын журамд нийцэхгүй байдалд хүргэдэг
- Өвчтөнд төвлөрсөн тусламж үйлчилгээний мөн чанар болох хэрэглэгчийн шаардлагад нарийвчилсан дүн шинжилгээ хийснээр үйлчилгээ үзүүлэх үйлчилгээ байхгүй. Тусламжийг өвчтөнд үзүүлж байгаа боловч өвчтөнтэй хамтран ажилладгүй.
- Хоёрдогч болон анхан шатны тусламж үйлчилгээний хооронд ямар ч уялдаа холбоо байхгүй

6.1.3 Санал болгож буй нэгдмэл тусламж үйлчилгээний загвар

Нэгдсэн тусламж үйлчилгээг хөгжүүлэх менежментийн үйл явцын "эхлэх цэг"-ийг хүлээн зөвшөөрч, түүнд дасан зохицох шаардлагатай. Одоо байгаа загваруудыг зүгээр л хуулбарлаад, тэр загвар нь Монголын ЭМАШТУ-ний эрүүл мэндийн тогтолцоонд ажиллана гэж хүлээх нь зохисгүй юм. "Нэгдмэл тусламж" гэсэн ойлголт нь 20 орчим жилийн хугацаанд илүү их нөөцтэй орчинд хөгжиж ирсэн. "Аливаа нэгдмэл загвар хөгжүүлэлт нь контекстээс шалтгаалсан, хуулбарлах бараг боломжгүй бөгөөд зөвхөн өөрийн үйлчлэхийг зорьж буй хүн амын өвөрмөц хэрэгцээ, шинж чанарыг харгалзан үзсэн тохиолдолд л амжилтанд хүрч чадна."

(ДЭМБ. 2016 оны 10-р сар). Тусламж үйлчилгээний нэгдсэн загварыг ЭМАШТҮ үзүүлэх загварт зүгээр нэг нэмж оруулахгүй, харин тусламж үйлчилгээний үйл явцад "тохируулж оруулах" ёстой.

Санал болгож буй Тооно ба Унь (Hub and Spoke) загвар нь дүүрэг, аймгийн нэгдсэн эмнэлэг болон тухайн дүүрэг, аймгийн өрхийн эрүүл мэндийн төвүүдийн харилцан уялдаа холбоос, тусламж үйлчилгээний нэгдмэл тогтолцоог харуулж байгаа хэвтээ болон босоо интеграцийг агуулсан болно.

Нэгдсэн эмнэлгийн дэргэд дүүрэг, аймгийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний Удирдах зөвлөл (эмнэлгийн Удирдах зөвлөлийн өргөтгөсөн хэлбэр) ажиллах бөгөөд анхан болон хоёрдогч шатлалын аль алиных нь тусламж, үйлчилгээ болон бусад улс, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын тусламж үйлчилгээг нэгтгэн зохицуулж удирдах үүрэгтэй байна.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний Удирдах зөвлөлийг нэгдсэн эмнэлгийн дэргэд байгуулснаар хоёрдогч болон анхан шатны тусламж үйлчилгээний аль алиных нь орчинд нэгдмэл тусламж үйлчилгээ үзүүлэх чадавхи бий болж, хуваагдлыг бууруулж, тусламж үйлчилгээний стандартыг хангах болно.

Мөн энэхүү загвар нь эмнэлгийн ажилтнуудад хоёрдогч болон анхан шатлалын хооронд сэлгэн ажиллах боломжийг олгож, тэдний мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэн хөгжүүлэх боломж олгох болно. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний Удирдах зөвлөл нь тухайн орон нутгийн хүн амын эрүүл мэндийн хэрэгцээнд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр тусламж үйлчилгээ үзүүлэгч бүрийн үзүүлэх тусламж үйлчилгээний хүртээмж, нэр төрлийг тогтоох болно.


Санал болгож буй загварын давуу талууд:

- Хоёрдогч болон анхан шатны тусламж үйлчилгээний нэгдмэл байдал (босоо интеграци) нь тусламж үйлчилгээ үзүүлэх замыг төлөвлөхөд чухал ач холбогдолтой.
- ӨЭМТөвүүдийн уялдаа холбоог сайжруулснаар (хэвтээ интеграци) тусламж үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах, зардлын үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн төвлөрсөн төлөвлөлтийг хийх боломжтой болно.
- Хоёрдогч болон анхан шатны тусламж үйлчилгээнд өвчтөн үйлчлүүлэгчийн замын зураглалыг оруулан төлөвлөсөн стандарт эмчилгээний удирдамж бүхий тусламж үйлчилгээг сайжруулах механизмыг бүрдүүлнэ.

- Тусламж үйлчилгээний хүртээмжийг оновчтой төлөвлөх, тухайлбал, хүрч очих үйлчилгээг нэмэгдүүлэх, "хөдөлгөөнт" үйлчилгээг хөгжүүлэх боломжийг олгоно.
- Эмнэлгийн ажилтнууд харилцан туршлага судлах замаар мэргэжлийн ур чадвараа хөгжүүлэх боломжийг хоёрдогч болон анхан шатны тусламж үйлчилгээ хооронд сэлгэн ажиллах журмаар зохицуулан олгох боломжтой.
- Тусламж үйлчилгээний нэгдмэл загвар нь цахим эрүүл мэнд, телемедицин гэх мэт технологийн хэрэглээг дээд зэргээр нэмэгдүүлэх боломжийг олгодог.

Энэхүү загварыг Зураг 1 – д үзүүлэв.

ЗУРАГ 1. САНАЛ БОЛГОЖ БУЙ ЗАГВАР



6.1.4 Эрүүл мэндийн үйлчилгээг нэгтгэх үндэслэл нь юу вэ?

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний илүү тэгш, цогц, нэгдмэл, тасралтгүй загваруудыг эрэлхийлэх нь шинэ зүйл биш юм. Ихэнх тохиолдолд эдгээр хүчин чармайлт нь 1978 оны Алма-Атагийн тунхаглалаас сэдэвлэж гарсан юм. Тунхаглалын VII зүйлд Эрүүл Мэндийн Анхан Шатны Тусламж Үйлчилгээ (ЭМАШТҮ) нь *“нэгдсэн, функциональ, харилцан бие биенээ дэмжсэн лавлагааны системээр тогтвортой байх ёстой, Энэ нь хүн бүрт зориулсан эрүүл мэндийн цогц тусламж үйлчилгээг аажмаар сайжруулж, хамгийн их хэрэгцээтэй хүмүүст тэргүүлэх ач холбогдол өгөхөд хүргэдэг”* гэсэн байдаг.

- *“Үндэсний болон орон нутгийн түвшинд лавлагаат болон шатлал хоорондын лавлагаат тусламжийн тогтолцоог бэхжүүлж, эрүүл мэндийн мэдээллийн системийг боловсронгуй болгох нь тусламж үйлчилгээг цаг алдалгүй, иж бүрэн хүргэхэд дөхөм болно”.*
- *“Анхан шатны тусламж үйлчилгээ, төрийн санхүүжилт, бүх нийтийн хамрагдалтад суурилсан, хэсэгчлэл, хуваагдлын үр нөлөөг бууруулах чадавхийг харгалзан бусад нийгмийн үйлчилгээний сүлжээнүүдтэй уялдаа холбоотой эрүүл мэндийн тусламж үйлчилгээний сүлжээг хөгжүүлэх хэрэгцээ”*
- *Саяхны жишээг дурьдахад ДЭМБ-ын Дэлхийн Эрүүл Мэндийн Ассамблей нь WNA62.12 тогтоолыг баталсан бөгөөд үүнд эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх, тусламж үйлчилгээний загваруудын тухай 1.3-т: “...эрүүл мэндийг дэмжих, өвчин эмгэг зэрэг эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг цогцоор хангадаг, урьдчилан сэргийлэх, эмчлэх, хөнгөвчлөх тусламж үйлчилгээг бусад түвшний тусламж үйлчилгээтэй уялдуулж, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн зохицуулахын зэрэгцээ хоёр, гуравдугаар шатлалын тусламж үйлчилгээнд үр дүнтэй шилжүүлэхийг баталгаажуулна” хэмээн тусгасан (9).*

Сүүлийн үед хийгдсэн шуурхай үнэлгээний судалгааны үр дүнд үндэслэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нэгдмэл загварыг хэрэгжүүлэх гол шалтгаан нь Монгол Улсад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хуваагдал өндөр байгаатай холбоотой нь тогтоогдсон.

Хөгжиж буй ихэнх орнуудын эрүүл мэндийн тогтолцоо нь эрүүл мэндийн үйлчилгээний хуваагдмал байдлаар тодорхойлогддог. Хэт хуваагдмал байдал нь тусламж үйлчилгээний хүртээмжид хүндрэл учруулж, чанар муутай үйлчилгээ үзүүлэх, байгаа нөөцийг үр ашиггүй зарцуулах, үйл ажиллагааны зардлыг үндэслэлгүй өсгөх, үзүүлсэн тусламж үйлчилгээ нь хэрэглэгчийн сэтгэл ханамжид хүрэхгүй байх зэрэгт хүргэдэг болохыг өнөөгийн байдал харуулж байна.

Хэт хуваагдмал байдлын гол хүчин зүйлүүд нь: эрүүл мэндийн тогтолцооны институцийн сегментчилэл, эрүүл мэндийн үйлчилгээний төвлөрлийг сааруулснаар тусламж үйлчилгээний түвшинг хуваах, тодорхой өвчин, түүний эрсдэл болон хүн амд чиглэсэн эрүүл мэндийн тогтолцоонд нийцүүлээгүй хөтөлбөрүүд, (босоо хөтөлбөр) нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээг хувь хүнд чиглэсэн тусламж үйлчилгээнээс тусгаарлах, өвчин эмгэг, эрчимт эмчилгээний зориулалттай болон эмнэлэгт суурилсан эмчилгээнд төвлөрсөн тусламж үйлчилгээний загвар, эрүүл мэндийн байгууллагын удирдах үүрэг сул, нөөцийн тоо хэмжээ, чанар, хуваарилалтын асуудал гэх мэт орно.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хуваагдмал байдал нь эрүүл мэндийн тогтолцооны янз бүрийн түвшинд олон янзаар илэрдэг. Эрүүл мэндийн тогтолцооны түвшинд хуваагдал нь янз бүрийн түвшний тусламж, үйлчилгээний байгууллагуудын хоорондын уялдаа холбоо дутмаг, үйлчилгээ, дэд бүтцийн давхардал, ашиглагдаагүй үйлдвэрлэл үйлчилгээний хүчин чадал, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хамгийн тохиромжгүй байршилд, ялангуяа эмнэлгүүдэд үзүүлэх зэргээр илэрдэг.

Гэсэн хэдий ч хэвлэлийн тойм болон улс орнуудын зөвлөлгөөнөөс хуваагдмал байдлын дараах гол шалтгааныг онцлон тэмдэглэв:

- Эрүүл мэндийн тогтолцооны институцийн сегментчилэл;
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний төвлөрлийг сааруулах;
- Эрүүл мэндийн тогтолцоотой уялдаа холбоо зохицуулалтгүй, нэгдмэл бус тодорхой өвчин, эрсдэл, хүн амд чиглэсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хөтөлбөрүүд (босоо хөтөлбөрүүд) давамгайлах;
- Нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээг хувь хүнд чиглэсэн тусламж үйлчилгээнээс хэт тусгаарлах;
- Өвчин эмгэг, хурц цочмог өвчний тусламж болон эмнэлэгт суурилсан эмчилгээнд төвлөрсөн тусламж үйлчилгээний загвар;
- Эрүүл мэндийн байгууллагын удирдлагын чадавхи сул;
- Нөөцийн тоо хэмжээ, чанар, хуваарилалтын асуудал;
- Эрүүл мэндийн ажилтны үүрэг, чадамж, гэрээлэлтийн механизм тодорхой бус, түүнчлэн эрүүл мэндийн ажилтнуудын цалин хөлсний зөрүү;

- Олон төрлийн төлбөр төлөгч байгууллага болон үйлчилгээний төлбөрийн механизм;
- Интеграцид харшлах хүн ам, үйлчилгээ үзүүлэгчдийн зан байдал;
- Хууль эрх зүйн болон захиргааны саад бэрхшээл; болон
- Босоо хөтөлбөрийг дэмжигч олон улсын хамтын ажиллагааны зарим агентлаг/хандивлагчдын санхүүжилтийн дадал

6.1.5 Эрүүл мэндийн цогц, нэгдмэл, тасралтгүй үйлчилгээний тухай ойлголт, тэдгээрийн төрөл бүрийн хэлбэрүүд

“Эрүүл мэндийн тогтолцооны янз бүрийн түвшний тусламж, үйлчилгээний байгууллагуудаар дамжуулан эрүүл мэндийг дэмжих, өвчнөөс урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх, өвчний менежмент, нөхөн сэргээх, хөнгөөчлөх тусламж үйлчилгээг тасралтгүй авах эрүүл мэндийн үйлчилгээг удирдах, хүргэх, амьдралынхаа туршид тэдний хэрэгцээг хангах.” ЭХ СУРВАЛЖ: ДЭМБ-аас өөрчлөлт оруулсан. Эрүүл мэндийн нэгдмэл үйлчилгээ - Юу, яагаад? Техникийн товч танилцуулга №1, 2008 оны 5-р сар.

Цаашилбал, интеграци нь хэвтээ интеграци, босоо интеграци, бодит интеграци, виртуал интеграци гэх мэт өөр өөр аргуудтай байж болно (**хүснэгт 20**-ыг харах). Хавсралт А-д эрүүл мэндийн үйлчилгээг нэгтгэх үзэл баримтлалтай холбоотой нэмэлт нэр томъёог оруулсан болно.

Хүснэгт 20. Хэвтээ, босоо, бодит, виртуал интеграцийн тухай ойлголт

Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх нэгдмэл сүлжээ

Концепци	Тодорхойлолт	Ажиглалт
Хэвтээ интеграци *	Үйлчилгээ үзүүлэх үйл явцын нэг үе шатанд байгаа үйл ажиллагааны нэгжүүдийн зохицуулалтыг хэлнэ.	Энэ төрлийн интеграцчлалын жишээ бол нэг түвшний тусламж үйлчилгээний хүрээнд нэгдсэн, хуваалцсан үйлчилгээ юм.
Босоо интеграци*	Энэ нь үйлчилгээ үзүүлэх үйл явцын янз бүрийн үе шатанд байгаа үйл ажиллагааны нэгжүүдийн хоорондын үйлчилгээний зохицуулалтыг хэлнэ.	Энэ төрлийн интеграцчлалын жишээ бол эмнэлгүүд болон эмнэлгийн бүлгүүд, амбулаторийн мэс заслын төвүүд болон гэрийн асрамжийн газрууд хоорондын уялдаа холбоо юм. Өвчтөн үйлчлүүлэгч рүү чиглэсэн урагш босоо интеграци, мөн эмнэлгийн тоног төхөөрөмж, ханган нийлүүлэлтийн компаниуд гэх мэт ханган нийлүүлэгч тал руу чиглэсэн арагш босоо интеграци байдаг.

		Цаашлаад эрүүл мэндийн даатгагчтай босоо нэгдэх боломж бий.
Бодит интеграци **	Хяналт, шууд өмчлөлийн замаар системийн бүх хэсгүүдийг нэгтгэхийг хэлнэ (хөрөнгийн нэгдмэл өмчлөл).	
Виртуал интеграци**	Системийн бүрэлдэхүүн хэсгүүдийн хоорондын хамтын ажиллагааны хэрэгсэл болох өмчийн эзэмшил биш харин харилцаа холбоогоор дамжуулан нэгтгэхийг хэлнэ.	Хөрөнгийн эзэмшлийн үр ашгийг "өдөөсөн" гэрээ, хэлэлцээр, стратегийн түншлэл, нэгдэл эсвэл франчайзыг ашигладаг арга. Энэ төрлийн интеграци нь хөрөнгийн эзэмшилтэй зэрэгцэн оршиж болно.

ЭХ СУРВАЛЖ: * Shortell SM; Anderson DA; Gillies RR; Mitchell JB; Morgan KL (1993). Нэгдсэн Системийг Бий Болгох: Голографийн байгууллага. Эрүүл мэндийн форумын сэтгүүл 1993; 36(2):20-6. ** Satinsky MA (1998). Нэгдсэн тусламж үйлчилгээний үндэс: Өөрчлөлтийн сорилттой нүүр тулах нь. American Hospital Publishing, Inc.

6.1.6 Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх нэгдмэл сүлжээ гэж юу вэ?

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний нэгдмэл сүлжээг (ЭМТҮНС) “тодорхойлогдсон хүн амд эрүүл мэндийн үйлчилгээг тэгш, иж бүрэн, нэгдмэл, тасралтгүй үзүүлэх, эсвэл үзүүлэх зохицуулалтыг хийдэг байгууллагуудын сүлжээ бөгөөд эмнэлзүйн болон эдийн засгийн үр дүн, хүн амын эрүүл мэндийн байдалд хариуцлага хүлээх этгээдийг хэлнэ.” ЭХ СУРВАЛЖ: * Shortell SM; Anderson DA; Gillies RR; Mitchell JB; Morgan KL (1993). Нэгдсэн Системийг Бий Болгох: Голографийн байгууллага. Эрүүл мэндийн форумын сэтгүүл 1993; 36(2):20-6.

ЭМТҮНС нь системийн хүртээмжийг сайжруулж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хуваагдлыг бууруулж, системийн нийт үр ашгийг дээшлүүлж, дэд бүтэц, үйлчилгээний давхардлаас сэргийлж, үйлдвэрлэлийн зардлыг бууруулж, хүмүүсийн хэрэгцээ, хүлээлтийг илүү сайн хангаж чадна.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний нэгдмэл сүлжээний зорилго нь ЭМАШТУ-д суурилсан эрүүл мэндийн тогтолцоог хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах, улмаар эрүүл мэндийн үйлчилгээг илүү хүртээмжтэй, тэгш, үр ашигтай, техникийн өндөр чанартай хүргэх, иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг илүү сайн хангахад оршино.

ЭМАШТУ-д суурилсан эрүүл мэндийн тогтолцоо нь хүн амд хүлээн зөвшөөрөгдсөн, эрх тэгш байдлыг нэмэгдүүлэх үйлчилгээнд бүх нийтээр хамрагдах, хүртээмжтэй байх баталгааг хангадаг функциональ болон бүтцийн үндсэн элементүүдээс бүрдэнэ. Энэ нь цаг хугацааны хувьд иж бүрэн, нэгдмэл, тохирсон тусламж үйлчилгээг үзүүлж, эрүүл мэндийг дэмжих, урьдчилан сэргийлэхэд анхаарч, анхны холбоо барих тусламжийг баталгаажуулдаг. ЭМАШТУ-д суурилсан эрүүл мэндийн тогтолцоо нь хууль эрх зүй,

институци, зохион байгуулалтын сайн үндэс суурь, түүнчлэн хангалттай, тогтвортой хүний, санхүү, технологийн нөөцийг шаарддаг. Энэ нь чанар, үр ашиг, үр дүнтэй байдалд хүрэхийн тулд бүх түвшинд зохион байгуулалт, менежментийн оновчтой туршлагыг ашигладаг бөгөөд эрүүл мэндэд хувь хүний болон хамтын оролцоог нэмэгдүүлэх идэвхтэй механизмыг боловсруулдаг. ЭМАШТУ-д суурилсан эрүүл мэндийн тогтолцоо нь эрүүл мэнд, тэгш байдлыг тодорхойлогч хүчин зүйлсийг шийдвэрлэх салбар хоорондын арга хэмжээг боловсруулдаг.”

Эрүүл мэндийн үйлчилгээний түвшинд ЭМАШТУ-д суурилсан эрүүл мэндийн тогтолцоо нь бүх нийтийн хамрах хүрээ, хүртээмж, анхны холбоо барих, иж бүрэн, нэгдсэн болон тасралтгүй тусламж үйлчилгээ, зохистой тусламж үйлчилгээ, оновчтой зохион байгуулалт, менежмент, гэр бүл, олон нийт зэрэг хэд хэдэн чухал элементүүдийг бодитой болгоход тусалдаг.

ТА 8970-MON нь **ЭМАШТУ-ний систем болон ЭМАШТУ-ний үйлчилгээний** хувьд дараах зүйлийг санал болгосон:

ЭМАШТУ-ний тогтолцооны сул талуудыг үр дүнтэй шийдвэрлэхийн тулд хөндлөнгийн оролцооны хоёр стратеги шаардлагатай: 1) ӨЭМТ-үүдийг дэд бүтэц, тоног төхөөрөмж, боловсон хүчний хувьд шинэчлэх, 2) үйлчилгээг нэг дор зохион байгуулах, илүү нэгдмэл, илүү үр дүнтэй тусламж үйлчилгээний загварыг бий болгох чиглэлээр эрүүл мэндийн анхан шатны болон хоёрдогч шатлалын түвшинд зохицуулалт хийх. Иймд олон улсын хэмжээнд санал болгосны дагуу ӨЭМТ-үүд хүн амын эрүүл мэндийн тусламж үйлчилгээний 80%-ийг (архаг өвчтэй өвчтөнүүдийн үзлэг, хяналтыг оролцуулах) хангах, харин үлдсэн 20%-ийг дээд түвшний үйлчилгээ үзүүлэхээр тоноглогдсон байх ёстой.

Цаашилбал, ЭМАШТУ-ний түвшинд хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өсвөр насныхан, эрэгтэйчүүд (нас барах эрсдэл өндөртэй) зэрэг хүн амын тодорхой бүлэгт, мөн гэр бүлийн болон жендэрт суурилсан хүчирхийллийн тулгамдсан асуудалд зориулсан үйлчилгээг тус тус сайжруулах хэрэгтэй. Урьдчилан сэргийлэх, эмчлэх, зөвлөгөө өгөх зорилтот сургалтаар дамжуулан ӨЭМТ-үүдийг энэ чиглэлд хөгжүүлэх, ӨЭМТ болон тэдгээрийн үйлчилгээг өвчтөн болон ажилтнуудын аль алинд нь илүү хэрэгцээтэй болгохын тулд үйлчилгээний цар хүрээ, чанарыг нэмэгдүүлэх (дэд бүтэц, илүү сайн тоног төхөөрөмж, мэргэшсэн боловсон хүчин гэх мэт) бүтцийн болон зохион байгуулалтын шинэчлэл хийх шаардлагатай байна.

Боломжит шийдэл бол илүү олон тооны ажилтан (мөн өвчтөн) бүхий томсгосон (гэхдээ цөөн) ӨЭМТ-үүдийг байгуулах явдал юм. 20 000 хүртэлх зорилтот хүн амд үйлчлэх ӨЭМТ-үүдэд илүү чанартай, үр ашигтай үйлчилгээ үзүүлэх төрөлжсөн загварыг боловсруулах боломжийг олгоход тохиромжтой. Энэ нь тус бүр 10 орчим өрхийн эмчтэй, нийслэлийн нийт

хүн амын хувьд 70-80 орчим ӨЭМТ-үүд тохирно. Энэ нь унааны зардал өндөр гарч болох ч гүйцэтгэл, чанар, үр ашиг сайжрах нь мэдэгдэхүйц байх тул үүнийг зохицуулах, хүлээн зөвшөөрөхүйц байх ёстой (одоогийн байдлаар олон өвчтөн ӨЭМТ-ийг алгасч, бүр алслагдсан хоёр, гуравдугаар шатлалын эмнэлгүүд рүү зорчдог).

6.2 ЭМАШТҮ-ний чанарын удирдлагын шинэчлэлийн санал, зөвлөмж

Анхан шатны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулахын тулд ӨЭМТ, СЭМТ-д “Эмнэл зүйн засаглал”-ыг бий болгож, хэрэгжүүлэхийг санал болгож байна. Эмнэл зүйн засаглалыг амжилттай хэрэгжүүлсний үр дүнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал сайжирна. ӨЭМТ, СЭМТ-ийн дарга нарыг сургаж бэлтгэснээр, эмнэл зүйн засаглалаа хариуцаж явах боломжтой.

“Эмнэл зүйн засаглалын үндэс суурь нь хариуцлагын механизмд суурилсан хамгийн өндөр стандартыг хангах, тусламж, үйлчилгээний ээлтэй, таатай орчныг бүрдүүлэх замаар чанарыг тасралтгүй сайжруулах юм” гэж Английн Үндэсний Эрүүл мэндийн тогтолцооны байгууллага тодорхойлсон байна.

Эмнэл зүйн засаглалын 7 үндсэн бүрэлдэхүүн хэсэг байдаг. Үүнд:

1. Эмнэл зүйн үр дүн
2. Эмнэл зүйн аудит
3. Эрсдлийн удирдлага
4. Сургалт ба мэргэшүүлэлт
5. Үйлчлүүлэгч ба олон нийтийн оролцоо
6. Мэдээлэл ба мэдээллийн технологи
7. Мэргэжлийн хүний нөөцийн удирдлага

Эмнэл зүйн хамгийн сайн үр дүнд хүрэхийн тулд эмч, мэргэжилтнүүд нотолгоонд суурилсан эмнэл зүйн стандарт, удирдамж, заавар, хөтөч, протоколыг ашигладаг байх бөгөөд үргэлж өвчтөний эрх ашгийн төлөө ажиллах ёстой. Энэ эь хамгийн сайн, үр дүнтэй тусламж, үйлчилгээ үзүүлэх боломжийг бий болгодог. Мөн хурдан хувьсан өөрчлөгдөж буй анагаах ухааны хөгжил, технологийн дэвшилттэй уялдуулан эмнэл зүйн стандарт, удирдамж, заавар, протоколыг тогтмол шинэчилдэг байх, эмчилгээний хамгийн сайн практикийг нэвтрүүлснээр зардлыг бууруулж, үр ашгийг нэмэгдүүлдэг.

Эмнэл зүйн аудит нь эмнэл зүйн үр дүнг одоо байгаа стандарт, удирдамж, протоколын дагуу үнэлдэг. Энэхүү үнэлгээгээр алдаа дутагдлыг олж тогтоох, үр дүнг сайжруулах арга

замыг боловсруулах боломжтой болно. Эцсийн дүндээ эмч, мэргэжилтнүүдийн үзүүлж буй тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах зорилготой.

Эрсдлийн удирдлага нь өвчтнүүд болон эмч, мэргэжилтнүүдэд учирч болзошгүй эрсдлийг тогтоох, бүртгэх, багасгах, хариу арга хэмжээ авах удирдлага зохицуулалт юм. Өнгөрсөн хугацаанд гарсан аливаа алдаа, ослоос суралцснаар өвчтөнд үзүүлэх тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах боломжтой.

Эмнэл зүйн засаглалыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд сургалт ба мэргэшүүлэлт маш их ач холбогдолтой үйл ажиллагаа юм. Эмч, эмнэлгийн мэргэжилтний карьер бол тасралтгүй суралцах ажил, мэргэжил юм. Үүний тулд ажлын байрны тасралтгүй сургалт, эмнэл зүйн тохиолдлуудын хэлэлцүүлэг, мэргэшүүлэх богино, урт хугацааны сургалтууд, эмнэл зүйн судалгааны ажлууд, мэдлэг ур, чадвараа дээшлүүлэхийн тулд семинар, лекцэд хамрагдах ёстой.

Эмнэлгийн тусламж, үйлчилгээг төлөвлөхдөө үйлчлүүлэгч болон олон нийтийн хэрэгцээнд суурилан төлөвлөх, тусламж, үйлчилгээг сайжруулахын тулд үйлчлүүлэгч болон олон нийтийн санал, гомдлыг ашигласнаар асуудлаа зөв тодорхойлох, оновчтой шийдвэр гаргах, эмнэл зүйн үр дүнг үнэлэх үйл явцад үйлчлүүлэгч болон олон нийтийн оролцоог хангадаг зохицуулалт хийх шаардлагатай.

Мэдээлэл ба мэдээллийн технологи нь өвчтнүүдийн мэдээллийн хамгаалалт, нууцлалыг хангахад чиглэсэн эмнэл зүйн менежментийг хэрэгжүүлэхээс гадна мэдээллийн өгөгдлийг зохих ёсоор хадгалах, удирдахад оролцох ба мэдээллийг эмнэл зүйн аудит хийхэд ашиглах үйл ажиллагаа юм.

Эмнэл зүйн засаглал нь биет материаллаг нөөцийг удирдахгүй, харин мэргэжлийн хүний нөөцийг удирддаг үйл явц юм. Мэргэжлийн хүний нөөцийн удирдлага нь зөв мэргэжилтнийг тохирсон ажлын байранд нь ажиллах боломжийг олгох, мэргэжлийн хүний нөөцийн гүйцэтгэлийн үнэлгээний үйл явцыг удирдах, ажлын байранд зөв хандлага тогтоох, ажлын байрны таатай нөхцлийг бүрдүүлэхэд чиглэгдэнэ.

“Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний хөгжил”-ийн зөвлөх багаас ЭМАШТҮ-ний чанарын удирдлагын шинэчлэлийн дараах санал, зөвлөмжийг гаргаж байна. Үүнд.

- ӨЭМТ, СЭМТ-ийн даргын ажлын байрны чиг үүргийг эмнэл зүйн засаглалын 7 бүрэлдэхүүн хэсгийн дагуу тодорхойлж, ажлын байрны тодорхойлолтыг өөрчлөх,

- ӨЭМТ, СЭМТ-үүд тусламж, үйлчилгээний эмнэл зүйн эрсдэлийн түвшинг тогтоож, маш өндөр, өндөр эрсдэлтэй үнэлгээ авсан тусламж, үйлчилгээ тус бүр дээр эрсдлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах,
- ӨЭМТ, СЭМТ-үүд өөрийн хүчин чадал, чадавхиас хамаарсан тусламж, үйлчилгээний жагсаалтыг гаргах, уг жагсаалтын дагуу эмнэл зүйн удирдамж, түгээмэл үйлдлийн стандартын жагсаалтаа батлах, эмч, мэргэжилтэн бүрийн ажлын байрны тодорхойлолтод заасан мэдлэгт тохирсон, эзэмшсэн байх ур чадварт нийцүүлсэн мөрдөж ажиллах ёстой стандарт, эмнэл зүйн практикт ашиглах эмнэл зүйн удирдамжийн жагсаалтыг гаргаж, хэн ашиглах, хэрхэн ашиглах, хэзээ ашиглах талаар журамлаж эрх зүйн баримт бичиг болгох,
- Анагаах ухааны нотолгоонд суурилсан эмнэл зүйн стандарт, удирдамж, заавар, протокол, эмчилгээ, оношилгооны үнэлгээний хуудсыг ашиглан эмнэл зүйн хувьд үр дүнтэй тусламж, үйлчилгээний менежментийг хэрэгжүүлэх,
- Эмнэл зүйн үр дүнг тогтмол үнэлэх, үнэлгээний үр дүнд суурилсан чанар сайжруулах арга хэмжээг авч төлөвлөж, хэрэгжүүлэх,.
- Эмнэл зүйн эрсдлийн удирдлагыг хэрэгжүүлэх, өвчтөнд учрах хор хөнөөлийг багасгах арга хэмжээг авах, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн ажлын хариуцлагын механизмыг бий болгох,
- Эмч, сувилагчийн мэргэжлийн мэдлэг, ур чадвар нь хийж буй ажилтай нь нийцсэн байх нөхцлийг бүрдүүлэх, мэдлэг, ур чадварыг нь байнга дээшлүүлэх, мэргэшүүлэхэд тогтмол дэмжлэг үзүүлэх, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх асуудлыг хариуцах,
- Чанарыг сайжруулахад өвчтөн болон олон нийтийн саналыг ашиглан үйлчлүүлэгчдийн хэрэгцээг хангах үйлчилгээг төлөвлөх,
- Өвчтнүүдийн мэдээллийн хамгаалалт, нууцлалыг хангахад чиглэсэн эмнэл зүйн менежментийг хэрэгжүүлэх,
- Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн ажлын байранд тавигдах шаардлагыг тогтоох, ажлын байрны тодорхойлолыг боловсруулах ажлыг удирдлагаар хангах,
- Эмч, эмнэлгийн мэргэжилтний ажлын гүйцэтгэлийн үнэлгээг хийх, аттестатчлалыг удирдан зохион байгуулах, үнэлгээнд суурилсан урамшууллын тогтолцоог бүрдүүлэх ажлыг хариуцах,
- Эмнэлгийн үйл ажиллагааг зохицуулсан бүх тушаал, шийдвэр, журамд үйлчлүүлэгч болон тэдгээрийн ар гэр, олон нийтийн оролцоог хангасан зохицуулалтыг тусгах,
- Үйлчлүүлэгч, олон нийтээс ирж буй санал гомдлын мөрөөр арга хэмжээг хэрэгжүүлэхдээ шийтгэх бус ажлаа сайжруулах арга хэрэгсэл болгодог хандлагыг тогтоох,
- Тусламж, үйлчилгээг төлөвлөхдөө үйлчлүүлэгч, олон нийтийн эрэлт хэрэгцээг юуны түрүүнд судалдаг байх тогтолцоог бүрдүүлэх,

- Эмнэл зүйн стандартуудыг үндэсний стандартын байгууллагаас худалдаж аваад өөрийн сайтад үнэгүй татаж авч хэрэглэх боломжтой олгох нь зүйтэй.

6.3 Хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах талаарх санал, зөвлөмж

Бидний зүгээс ӨЭМТ, СЭМТ-д “Эмнэл зүйн засаглал”-ыг бий болгож, хэрэгжүүлэхийг санал болгож байгаа. Эмнэл зүйн засаглалын “Сургалт ба мэргэшүүлэлт” бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах талаарх дараах санал, зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

- Эмнэлгийн мэргэшсэн ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор анхан шатны тусламж, үйлчилгээний эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн баримт бичгийг боловсронгуй болгох,
- Хүний нөөцийн карьер хөгжүүлэх төлөвлөгөөг боловсронгуй болгох, эрх зүйн орчныг бүрдүүлэх,
- Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын чадамжид суурилсан хөтөлбөр боловсруулах,
- Сувилагч, эмчийн харьцаа үзүүлэлт олон улсын дунджаас доогуур байгаа тул ЭМАШТУ-ний байгууллагуудад ажиллах сувилагчийн тоог нэмэгдүүлэх боломжийг судалж, хэрэгжүүлнэ.

6.4 ЭМАШТУ-ний санхүүжилтын шинэчлэлийн санал, зөвлөмж

1. 2022 оны ЭМДҮЗ-ийн тогтоолоор өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн нэг иргэнээр тооцох санхүүжилтийг 2 дахин нэмэгдүүлж, төлбөрийн аргыг шинэчлэн баталсан. Гэвч анхан шатны эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудын төлбөрийн аргын талаархи ойлголт бага, компьютер, техник хангамж хангалттай бус байгаа нь бодит цагийн горимоор нэхэмжлэл илгээх, санхүүжилтээ бүрэн авч чадахгүй байх эрсдэл гарахаар байна. Мөн тусламж, үйлчилгээний гүйцэтгэл муутай, хүчин чадлаараа ажиллаж чаддаггүй сум дундын эмнэлгүүдийн санхүүгийн байдал хүндрэхээр байна. *Иймд анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын санхүүгийн удирдлагын чадварыг сайжруулах сургалт нэн чухал болж байна.*
2. Дээд болон доод шатлалын тусламж үйлчилгээ үзүүлэгчидтэй нэгдсэн босоо сүлжээ байгуулан ажиллах шаардлагатай. Худалдан авагчийн зүгээс үйлчилгээг сайжруулахын тулд босоо байдлаар үйлчилгээг нэгтгэх, лавлагаа тусламжийг үр дүнтэй ашиглах явдлыг дэмждэг. *Тусламж үйлчилгээний нэгдсэн загварыг бий болгоход санхүүгийн дэмжлэг*

үзүүлэх зорилгоор сонгогдсон өвчнийг тохиолдолд суурилсан санхүүжилтийг нэвтрүүлэх асуудлыг судлана.

3. Хэвтээ чиглэлд нэгдсэн сүлжээ үүсгэн ажиллах хэсэг. Тусламж үйлчилгээний тасралтгүй байдлыг (бие биеэ нөхөх) хангах, эмнэлгийн дотоод аудитыг илүү хийх, үе тэнгийнхний үнэлгээ хийх, төгсөлтийн дараахь сургалт зэрэгтэй холбоотойгоор иймэрхүү сүлжээ байдлаар ажиллаж буй өрхийн эмнэлгүүд нь ганц нэгээрээ ажиллаж буй эмч, мэргэжилтнүүдээс хавьгүй давуу талтай байдаг. Энэхүү сүлжээний хүрээнд дэмжлэг үзүүлэх санхүүжилтийн тогтолцоог судлах шаардлагатай болж байна.
4. Сонгогдсон өвчин эмгэгийн "Өвчний менежментийн хөтөлбөр"-ийг нийт үнийн дүнд суурилсан санхүүжүүлэх боломжийг судлах хэрэгтэй болж байна.

ХАВСРАЛТУУД

Хавсралт 1. Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн түргэвчилсэн үнэлгээний асуумж

БҮЛЭГ 2. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Дэд бүлэг 1. ЗАСАГЛАЛ, УДИРДЛАГА, МАНЛАЙЛАЛ

№	Үйл ажиллагаанд тавигдах шаардлага	Шалгуур үзүүлэлт	Хэмжих үзүүлэлт	Үнэлгээ
1.1	Байгууллагын бүтэц, орон тоог баталж, тусламж, үйлчилгээний чиглэлийн дагуу зохион байгуулсан байна.	1.1.1. Тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эрхлэх бүтэц, зохион байгуулалтыг хийсэн байх	1. Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагааны стандарт (MNS)-тай уялдуулан өөрийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг баталсан тушаалтай 2. Баталсан бүтцийн дагуу тасаг, нэгжийг бүрэн зохион байгуулсан	Шалгуур үзүүлэлт бүрийг 5, 4, 3, 2, 0 оноогоор дүгнэнэ.
		1.1.2. Батлагдсан тусламж, үйлчилгээний жагсаалтын дагуу үйл ажиллагаа явуулдаг байх	1. Жагсаалтад заасан тусламж, үйлчилгээг бүрэн үзүүлдэг 2. Хяналт тавьдаг	5, 4, 3, 2, 0
		1.1.3. Зөвшөөрөгдсөн орны фонд ашиглалт хангалттай байх	1. Зөвшөөрөгдсөн орыг ашигладаг 2. Орны фонд ашиглалтыг тооцдог 3. Орны ашиглалтад хийсэн дүгнэлт, авсан арга хэмжээ	5, 4, 3, 2, 0
		1.1.4. Өдрийн эмчилгээг зохион байгуулсан байх	1. Өдрийн эмчилгээний баталсан журамтай, мөрддөг 2. Өдрийн эмчилгээ, ажилбар хийх стандарт, удирдамжийн хэрэгжилтэд хяналт тавьдаг 3. Эмчилгээг эмчийн заалтаар хийдэг	5, 4, 3, 2, 0

1.2	Байгууллагын ажлын уялдаа холбоо, хамтын ажиллагааг хангаж ажиллана.	1.2.1. Бусад эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллах зохицуулалтыг хийсэн байх	1.Лавлагаа шатлалын болон бусад эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллах гэрээ, үйл ажиллагааны журамтай, баталгаажжлсан 2.Хамтран ажилласан чиглэл, гарсан үр дүнг тооцсон	5, 4, 3, 2, 0
		1.2.2. Тасаг, нэгжийн үйл ажиллагааны уялдаа холбоо, хамтын ажиллагааны зохицуулалтыг хийсэн байх	1.Тасаг, нэгжийн үйл ажиллагааны уялдаа, холбоог зохицуулсан журамтай, баталсан 2.Журмын хэрэгжилтийг хангасан	5, 4, 3, 2, 0
1.3	Байгууллагыг хөгжүүлэх төлөвлөлтийг хийж, үр дүнтэй хэрэгжүүлсэн байна.	1.3.1. Судалгаа, шинжилгээнд үндэслэсэн дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөөтэй, хэрэгжилтэд явцын болон төгсгөлийн үнэлгээ хийсэн, үр дүнг тооцсон байх	1.Байгууллагын хөгжлийн төлөвлөгөөг салбарын бодлого, харъяалах орон нутгийн бодлоготой уялдуулан баталж, хэрэгжүүлсэн 2.Төлөвлөгөөнд хийсэн явцын, төгсгөлийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, дүгнэлт, цаашид анхаарах санал, зөвлөмжийн хэрэгжилтийг тусгасан 3.Төлөвлөгөөний хэрэгжилтэд хийгдсэн явцын болон төгсгөлийн үнэлгээний дүгнэлтийг удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн тэмдэглэлтэй, гарсан шийдвэр, түүнийг хэрэгжүүлсэн 4.Төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэхэд хамт олны оролцоог хангасан 5.Төлөвлөгөөний хэрэгжилтийг жил бүр дүгнэдэг, тайлантай	5, 4, 3, 2, 0
		1.3.2. Жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөө нь дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөөтэй уялдсан, хэрэгжилтийг тоодог байх	1.Тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулж, батлан хэрэгжүүлсэн 2.Жилийн төвлөвлөгөөний хэрэгжилт, тайлан, дүгнэлттэй	5, 4, 3, 2, 0
1.4	Байгууллагын засаглалын үр дүнтэй тогтолцоо бүрдсэн байна.	1.4.1. Удирдлагын багийн үйл ажиллагаа хэвшиж, үр дүнтэй ажилладаг байх	1.Удирдлагын багийн ажиллах журам, бүрэлдэхүүнийг баталсан тушаалтай 2.Батлагдсан журмын дагуу ажилладаг /хурлын тоо, хурлын тэмдэглэл, гарсан шийдвэр, түүний биелэлт-эргэх холбоо/ 3.Бүрэлдэхүүнд ажилтны төлөөллийг оруулсан	5, 4, 3, 2, 0

			4.Удирдлагын зөвлөлийн хурлаар тасаг, нэгжийн үйл ажиллагаа, тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хэлэлцэж шийдвэрлэдэг	
1.5	Байгууллагын үйл ажиллагаанд үр дүнтэй дотоодын хяналтыг хийдэг тогтолцоотой байна.	1.5.1. Байгууллагын дотоод үйл ажиллагаанд хийгдэх хяналт, үнэлгээ хэвшсэн байх	1.Дотоод хяналт, үнэлгээний багийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг баталсан тушаалтай 2.Дотоод хяналт, үнэлгээний батлагдсан төлөвлөгөө, үйл ажиллагааны чиглэл бүрээр хяналт, үнэлгээ хийх хуваарьтай 3.Хяналт, үнэлгээ хийх хяналтын хуудсыг чиглэл бүрээр боловсруулж, хэрэглэдэг 4.Хийгдсэн хяналт, үнэлгээний тайлан, дүгнэлттэй 5.Гарсан зөвлөмж, түүний дагуу ажил хийгдсэн 6.Хяналт, үнэлгээний дүгнэлтийг удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлсэн, асуудлыг шийдвэрлүүлсэн	5, 4, 3, 2, 0
1.6	Хариуцлагатай, үр дүнтэй манлайллын тогтолцоо бүрдсэн байна.	1.6.1. Бүх ажилтнуудын хурлыг тогтмол хийж, байгууллагын бодлого, шийдвэрийг танилцуулдаг, тэдний санал бодлыг сонсдог үйл ажиллагаа тогтмолжсон байх	1.Байгууллагын ажилтнуудын хурлын тэмдэглэлтэй 2.Гарсан шийдвэрийн дагуу арга хэмжээ авсан 3.Эргэн мэдээлэл хийдэг, баримтжуулсан	5, 4, 3, 2, 0
		1.6.2. Байгууллагын удирдлага нь тасаг, нэгжийн үйл ажиллагаатай газар дээр нь очиж танилцаж, ажилтнуудын санал, хүсэлтийг шийдвэрлэдэг байх	1.Удирдах ажилтны нэгжид ажиллах хуваарьтай, ажилласан баримттай 2.Шийдвэрлэх асуудал, шийдвэрлэсэн асуудлын тэмдэгдэлтэй 3.Хэрэгжилтийг тооцдог	5, 4, 3, 2, 0
		1.6.3. Тусламж, үйлчилгээний нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, зохион байгуулалтын арга хэмжээ авдаг тогтолцоотой байх	1.Тусламж, үйлчилгээний нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээний тайлантай 2.Авч хэрэгжүүлсэн зохион байгуулалтын арга хэмжээний төрөл, удаа	5, 4, 3, 2, 0
		1.6.4. Ажилтнуудад хууль зүйн ба сэтгэл зүйн зөвлөгөө өгөх нөхцөлийг бүрдүүлсэн байх	1.Хууль эрх зүйн зөвлөгөө авсан ажилтны бүртгэлтэй 2.Сэтгэл зүйн зөвлөгөө авсан ажилтны бүртгэлтэй 3.Ажилтнуудын сэтгэл ханамжийн үнэлгээний үр дүн	5, 4, 3, 2, 0

			4.Нөхцөл бүрдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ (хууль, эрх зүйн цахим мэдээний сан, тохижуулсан өрөө, гарын авлага, ном товхимол гэх мэт)	
	1.6.5. Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах хөтөлбөр/ төлөвлөгөөг хэрэгжүүлж, үр дүнтэй ажилладаг байх		1.Байгууллагын хэмжээнд ажлын байрны орчны үнэлгээ хийлгэсэн 2.Ажлын байрны орчинг сайжруулах арга хэмжээ авч хэрэгжүүлсэн 3.Тусламж, үйлчилгээтэй холбоотой ажлын байрны орчинд үүсч болох эрсдлээс сэргийлэх арга хэмжээ хэрэгжүүлсэн 4.Хувийн хамгаалах хэрэгслээр хангасан, хүртээмжтэй 5.Эрсдэл, ослын бүртгэлтэй	5, 4, 3, 2, 0
Онооны дүн	Авбал зохих оноо		...	
	Авсан оноо		...	

Дэд бүлэг 2. ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРЫН УДИРДЛАГА

№	Үйл ажиллагаанд тавигдах шаардлага	Шалгуур үзүүлэлт	Хэмжих үзүүлэлт	Үнэлгээ
2.1	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын удирдлагын тогтолцоог бүрдүүлсэн байна.	2.1.1.“Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөө” /Чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөө/-тэй, хэрэгжүүлж, хянадаг байх	1.Чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөөг баталсан 2.Чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэдэг, үр дүнг жил бүр тооцсон, тайлантай	5, 4, 3, 2, 0
		2.1.2. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал /ЭМТҮЧАБ/-ын багийн үйл ажиллагаа тогтмолжсон, асуудалд чиглэсэн тодорхой, үр дүнтэй ажилладаг байх	1.Холбогдох тушаал, шийдвэрт заасны дагуу /ЭМТҮЧАБ/-ын багийг зохион байгуулж, гишүүдийг томилсон 2./ЭМТҮЧАБ/-ын багийн гишүүдийн албан тушаалын тодорхойлолт /АТТ/-д холбогдох тушаал, шийдвэрт заасан чиг үүргийг хэрэгжүүлэхээр тусган баталсан 3.АТТ-д заасан чиг үүргийн дагуу ажиллуулдаг	5, 4, 3, 2, 0

			4.Төвийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдалд дүн шинжилгээ хийсэн, гарсан ахиц, үр дүнтэй	
